



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийгмийн даатгалын сан даатгуулагчийн ирээдүйд учирч болох санхүүгийн эрсдэлийг хуваалцахад хүндрэл үүсэж, улсын төсөвт үзүүлэх ачаалал нэмэгдэхээр байна

Аудитын сэдэв: Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

Аудитын код: ГНАГ-2024/24-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд

Утас: 263755, Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер Х.Баярмаа

Утас: 261745, Цахим хаяг: bayarmaakh@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Сандуйжав

Утас: 329876, Цахим хаяг: sanduijavb@audit.gov.mn

Аудитор Ш.Наранбаатар

Цахим хаяг: naranbaatarsh@audit.gov.mn

Аудитор Ж.Чинбат

Цахим хаяг: chinbati@audit.gov.mn

Аудитор А.Мөнхбадрал

Цахим хаяг: munkhbadrala@audit.gov.mn

Аудитор С.Оюун-Эрдэнэ

Цахим хаяг: oyunerdenes@audit.gov.mn

Аудитор С.Номин-Эрдэнэ

Цахим хаяг: nominerdenes@audit.gov.mn

Аудитор А.Төгөлдөр

Цахим хаяг: tuguldura@audit.gov.mn

Улаанбаатар хот. 2024 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/84

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т даалгасугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд (Л.Энх-Амгалан), Эрүүл мэндийн сайд (Т.Мөнхсайхан) нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Самбууням)-д даалгасугай.


Д.ЗАГДЖАВ

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2024 оны 11 дүгээр сарын 15
өдрийн А/84 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитаар өгсөн
албан шаардлагын жагсаалт

№	Зөрчил хариуцах		Албан шаардлагын товч утга
	Байгууллага	Албан тушаалтан	
1	Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын яам	Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, ХШҮДАГ- ын дарга Ц.Мөнхзул	НДЕГ-ын Капитал банканд байршуулсан мөнгөн хадгаламжийн гэрээний жагсаалтад 2013, 2015, 2016 онуудын НДҮЗ-ийн даргаас НДЕГ-т гэрээ байгуулах эрх олгох зөвшөөрлийн баримт бичиг нь НДЕГ-ын архив болон НДҮЗ-ийн ажлын албанд байхгүй асуудлыг шалгаж, зохих арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах, “Капитал банк”-ны эрх хүлээн авагчаас Нийгмийн даатгалын санд хүлээн авсан хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, худалдан борлуулалт, түрээсийн гэрээ зэрэгт хяналт шалгалт хэрэгжүүлж үр дүнгийн талаар 2025 оны 6 дугаар сарын 15- ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2	Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар	Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, НДЕГ-ын Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг, НДЕГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн дарга Г.Хүрэлбаатар	2019 онд “Ай Ти Зон” ХХК-тай “Нийгмийн даатгалын мэдээллийн системийг хөгжүүлж, нэвтрүүлэх” гэрээний санхүүжилтийн 95 хувийг 2020 онд олгосон боловч 2024 оны 10 дугаар сарын байдлаар системийг бүрэн нэвтрүүлээгүй байна. Иймд системийг хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бүрэн нэвтрүүлэхэд хяналт тавьж хэрэгжилтийг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
3	Эрүүл мэндийн яам	Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга С.Төгсдэлгэр	ЭМДЕГ-ын мэдээллийн систем нь бусад байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд шүүлтүүр хийдэггүйгээс алдаатай мэдээлэл бүртгэгдэж байгаа тул тайланд тусгагдсан алдаатай өгөгдлүүдэд дотоод аудит хийж 2025 оны 7 дугаар сарын 01- ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт үр дүнгийн талаар мэдэгдэх.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн жагсаалт	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл	7
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	7
Аудитын зорилго	7
Аудитын хамарсан хүрээ	7
Аудитын арга зүй	7
Аудитын шалгуур үзүүлэлт	8
Аудитын багийн бүрэлдэхүүн	8
Ерөнхий мэдээлэл	9
БҮЛЭГ 1. Нийгмийн даатгалын санг оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн болон менежмент хийх, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх замаар санг арвижуулах, тогтвортой байдлаар удирдах тогтолцоо бүрдээгүй байна .10	
Нийгмийн даатгалын харилцааг зохицуулж буй хууль, тогтоомж, баримталж буй бодлогын зорилт арга хэмжээний уялдаа бүрэн хангагдаагүй байна.	10
Нийгмийн даатгалын үйл ажиллагааг зохистой удирдах удирдлагын оновчтой тогтолцоо бүрдээгүй байна	20
Нийгмийн даатгалын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх санхүү болон хүний нөөц тэгш, хүртээмжтэй хуваарилагдаагүй байна.	27
БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасгийн үйл ажиллагааны зардал нь төвлөрүүлсэн орлогын 35.2 хувийг эзэлж байна.....	29
Нийгмийн даатгалын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн систем нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна	29
БҮЛЭГ 2. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс даатгуулагчийн ирээдүйд учрах эрсдэлийг бууруулах боломжгүй нөхцөл байдалд хүрсэн байна	35
.....	35
НДС-ийн хөрөнгийг үр ашигтай, зохистой удирдаагүй байна	35
Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл сангийн авлагад авсан хөрөнгийг худалдан борлуулах журмаар салбарын албан хаагчдад давуу байдал олгосон байна	42
Ажиллах хүчин нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд бүрэн хамрагдаагүй байна.	52

Ажилгүйдлийн даатгалын сангийн орлогоос давсан зарлагыг хэрхэн нөхөх талаар зохицуулалт байхгүй байна	54
Тэтгэвэртэй холбоотой зарим шийдвэрүүд даатгалын сан 7.3 их наяд төгрөгөөр буурахад нөлөөлсөн байна	59
ЭМДС-ийн өр төлбөр 182.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.....	63
ДҮГНЭЛТ	71
ЗӨВЛӨМЖ.....	73
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	75
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР	98

Товчилсон үгийн тайлбар

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГБНХХЯ	Гэр бүл, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ЗГ	Засгийн газар
КБЭХА	Капитал банкны эрх хүлээн авагч
МАОЭНХ	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
МАХ	Монголын ахмадын холбоо
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
МҮЭХ	Монгол үйлдвэрчний эвлэлийн холбоо
НД	Нийгмийн даатгал
НДБ	Нийгмийн даатгалын байгууллага
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДЕХ	Нийгмийн даатгалын ерөнхий хууль
НДС	Нийгмийн даатгалын газар
НДС	Нийгмийн даатгалын сан
НДТ	Нийгмийн даатгалын тасаг
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НХБГ	Нийгмийн хамгааллын бодлогын газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СаС	Сангийн сайд
СБД	Сүхбаатар дүүрэг
ТЕГ	Татварын ерөнхий газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБТТУТХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХЧТА	Хөдөлмөрийн чадвар түр алдалт
ШТА	Шууд тайлагнах ажил

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

ШУА	Шинжлэх ухааны академи
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДТХ	Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
ЭМДШ	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний өөрчлөлтийн харьцуулалт	9
Хүснэгт 2	Өндөр насны тэтгэврийг салбарын хуулиар зохицуулж буй байдал	12
Хүснэгт 3	Хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх	13
Хүснэгт 4	Өндөр насны тэтгэвэр авагч иргэдийн тоо, санхүүжилтийн дүн	14
Хүснэгт 5	Тэтгэвэр авсан дундаж хугацаа, жилээр	15
Хүснэгт 6	Сайн дураар даатгуулагч нарт үзүүлсэн хөнгөлөлт	17
Хүснэгт 7	Нийгмийн даатгалын байгууллагын орон тооны мэдээлэл	23
Хүснэгт 8	Монгол Улсын хүн ам, үйл ажиллагаа явуулж буй ААНБ, НДГ-ын албан хаагчдын байршсан байдал	28
Хүснэгт 9	Нэг иргэний авсан үйлчилгээний тоо	33
Хүснэгт 10	НДС-аас тэтгэвэр, тэтгэмжийг хамт авдаг иргэдийн мэдээлэл	34
Хүснэгт 11	Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлага	35
Хүснэгт 12	Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлагын зөрүү	35
Хүснэгт 13	Арилжааны банканд мөнгөн хадгаламж байршуулах шалгуур үзүүлэлт	38
Хүснэгт 14	Капитал банкныг татан буулгах үеийн НДС-н хөрөнгө	40
Хүснэгт 15	НДС-ийн 2007-2019 онуудын Капитал банк дахь мөнгөн хөрөнгө	40
Хүснэгт 16	Капитал банкны НДС-д төлж барагдуулах хөрөнгийн үлдэгдэл	41
Хүснэгт 17	НДС-ийн нэхэмжилсэн төлбөрт хүлээн авсан хөрөнгө	41
Хүснэгт 18	Борлуулагдаагүй үлдсэн хөрөнгө	42
Хүснэгт 19	Капитал банкны ЭМДС-д төлж барагдуулсан хөрөнгө	44
Хүснэгт 20	Чингисхаан банканд байршуулсан мөнгөн хөрөнгө	45
Хүснэгт 21	Чингисхаан банкнаас нэхэмжилсэн хөрөнгийн бүтэц	45
Хүснэгт 22	Чингисхаан банкны НДС-д төлж барагдуулах хөрөнгийн үлдэгдэл	46
Хүснэгт 23	Чингисхаан банкны ЭМДС-д төлж барагдуулах хөрөнгийн үлдэгдэл	46
Хүснэгт 24	Арилжааны банканд байршиж байгаа НДС-ийн үлдэгдэл	47

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

Хүснэгт 25	Татан буугдсан банкттай холбоотой хөрөнгийн дүн	48
Хүснэгт 26	Бодлогын хүү, гэрээний хүүгийн зөрүү	49
Хүснэгт 27	Арилжааны банкны хадгаламжийн хүүгийн орлого	50
Хүснэгт 28	Хадгаламж хэлбэрээр байршуулах боломжтой байсан чөлөөт үлдэгдэл	50
Хүснэгт 29	Нийт ажиллах хүч, даатгуулагчдын харьцаа	52
Хүснэгт 30	ААНБ-ын мэдээлэл	53
Хүснэгт 31	ААНБ-ын НДШ-ийн өрийн мэдээлэл	53
Хүснэгт 32	НДШ-ийн өртэй ААНБ-ын мэдээлэл	53
Хүснэгт 33	Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл	55
Хүснэгт 34	Сарын дундаж цалингийн өсөлт	55
Хүснэгт 35	Татан буугдсан ААНБ-ын тоо	56
Хүснэгт 36	ҮОМШӨ даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл	56
Хүснэгт 37	ҮОМШӨ-ний сангийн тэтгэмжийн зарлага	57
Хүснэгт 38	ҮОМШӨ-ний сангийн тэтгэврийн зарлага	58
Хүснэгт 39	Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага	59
Хүснэгт 40	Тэтгэвэр нэмэгдүүлэхтэй холбоотой шийдвэр, санхүүжилт	59
Хүснэгт 41	Тэтгэвэртэй холбоотой гарсан шийдвэр, түүний үр нөлөө	59
Хүснэгт 42	Тэтгэвэр авагчдын тоо	60
Хүснэгт 43	Тэтгэвэрт зарцуулсан хөрөнгийн дүн	61
Хүснэгт 44	Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага	62
Хүснэгт 45	ЭМДС-ын орлого, зарлага	63
Хүснэгт 46	ЭМД-д даатгуулсан болон үйлчилгээ авсан иргэдийн тоо	64
Хүснэгт 47	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч байгаа иргэдийн тоо, үйлчилгээний мэдээлэл	65
Хүснэгт 48	ЭМДС-ийн өрийн ангилал	65
Хүснэгт 49	Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлага	66
Хүснэгт 50	Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлага	67
Хүснэгт 51	ЭМД-ын байгууллагаас ЭМБ-дад хуваарилсан ЭМТҮ-ний тоо, санхүүжилтийн дүн	68

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	НДШ-ийн талаар иргэдийн ойлголт	20
Дүрслэл 2	Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллагуудын тогтолцоо	21
Дүрслэл 3	НДЕГ-ын дотоод болон дэргэдэх газруудын батлагдсан бүтэц, орон тоо /2024 он/	22
Дүрслэл 4	ЭМДЕГ-ын дотоод бүтэц, орон тоо, /2024 он/	26
Дүрслэл 5	НДГ-ын нэг албан хаагчид ногдох хөдөлмөрийн насны хүн ам, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо /2024 он/	28
Дүрслэл 6	Ажил хөнгөвчлөхгүй байгаа шалтгаан	30
Дүрслэл 7	НД-ын цахим систем ашиглахад гарч буй асуудал /ААНБ, иргэн/	31
Дүрслэл 8	Иргэдийн ашиглаж байгаа цахим систем	31
Дүрслэл 9	2020-2023 онд нийгмийн даатгалын байгууллагаас үйлчилгээ авсан иргэдийн тоо	31
Дүрслэл 10	Call Pro үйлчилгээний талаарх албан хаагчдын сэтгэгдэл	32

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

Дүрслэл 11	Ажил хөнгөвчлөхгүй байгаа шалтгаан	32
Дүрслэл 12	НДС-ийн орлогод эзлэх хувь	36
Дүрслэл 13	НДС-ийн зарлагад эзлэх хувь	36
Дүрслэл 14	Үйл ажиллагааны зардалд зарцуулсан хөрөнгө	37
Дүрслэл 15	Даатгуулагчдын тоо	37
Дүрслэл 16	НДШ-ийн өртэй ААН-ийн ангилал	54
Дүрслэл 17	НДС-аас тэтгэмж авахад гарч буй асуудал	56
Дүрслэл 18	ҮОМШӨДС-аас тэтгэмж авахад гарч буй асуудал	58
Дүрслэл 19	Тэтгэмж авсан иргэдийн тоо	62
Дүрслэл 20	ХЧТА-ны тэтгэмж авахад гарч буй асуудал	63
Дүрслэл 21	ЭМБ-дад олгосон санхүүжилтийн гүйцэтгэл	69
Дүрслэл 22	ӨЭМТ-ийн санхүүжилт	70
Дүрслэл 23	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад үүсэж буй асуудал	70

Хавсралтын жагсаалт

Дугаар	Агуулга
Хавсралт 1	Чингис хаан банканд байршуулсан мөнгөн хадгаламжийн гэрээний жагсаалт
Хавсралт 2	2014-2019 он Чингис хаан, Капитал банкны мөнгөн хадгаламж байршуулахдаа Монгол банкны бодлогын хүүтэй уялдуулсан эсэх судалгаа
Хавсралт 3	НДЕГ-ийн бонд худалдан авалт хүүгийн орлого
Хавсралт 4	ЭМБ-ын албан хаагчидтай хийсэн уулзалтын тэмдэглэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/152 дугаар тушаалыг үндэслэн “Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

Аудитын зорилго

Монгол Улсад нийгмийн даатгалын талаар баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлэх үр нөлөөтэй, оновчтой тогтолцоо бүрдсэн эсэх, даатгуулагчийн санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж иргэдийн амьдралын баталгаа алдагдаж орлогын эх үүсвэргүй болох аливаа эрсдэлийг нийгмийн даатгалын дэмжлэгтэйгээр бууруулах баталгаагаар хангагдах боломж бүрдсэн эсэхэд аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх оновчтой тогтолцоо бүрдсэн эсэх;
- Нийгмийн даатгалын үйлчилгээ нь даатгуулагчийн ирээдүйд учирч болох эрсдэлийг бууруулж чадаж байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад нийгмийн даатгалын үйл ажиллагаанд оролцож буй Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, тэдгээрийн харьяа байгууллагууд, холбогдох бусад байгууллагуудыг (Монгол банк, Үндэсний статистикийн хороо, Архивын ерөнхий газар, Татварын ерөнхий газар) хамруулж, бодлогын баримт бичиг, бүтэц зохион байгуулалт, хүний, санхүүгийн болон бусад нөөц, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ, судалгаа, гаргасан шийдвэрүүд, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, шаардлагатай бусад баримт материал, мэдээллийн сангийн өгөгдлийг хамруулав.

Нийгмийн даатгалын сангуудын бүрдүүлэлт, зарцуулалтын 2019-2023, 2024 оны 10 дугаар сарын байдлаар, хүний нөөцийн талаарх мэдээллийг 2024 оны эхний хагас жилийн байдлаар, сангуудад нөлөөлж байсан нөхцөл байдлыг урт хугацаанд авч үзлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 3000-3100, нийцлийн аудитын стандарт АДБОУС 400, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх, санал асуулга, судалгаа явуулах арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын хүндрэл, бэрхшээл

Аудитын явцад НДЕГ, ЭМДЕГ-ын цахим системд байгаа Монгол Улсын хэмжээний НДШ, ЭМДШ-ийн их өгөгдөлд дүн шинжилгээ хийхэд хугацааны хязгаарлагдмал байдал шалгаагдагч этгээдээс хамаарч үүссэн нь аудитын багт хүндрэлтэй байлаа.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль,
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль,
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль,
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль,
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль,
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль,
- Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль,
- Шүүхийн тухай хууль,
- Прокурорын тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Нийгмийн даатгалын сангийн 2020-2024 оны төсвийн тухай хууль,
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020-2024 оны төсвийн тухай хууль,
- Холбогдох бусад хууль, эрх зүйн актууд,
- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл",
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр",
- Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө",
- Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө",
- Засгийн газрын 2021 оны 203 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө",
- Монгол Улсын эдийн засаг, статистикийн үзүүлэлтүүд,
- Олон улсын болон дотоодын байгууллага, судлаачдын нийгмийн даатгалын асуудлаар хийсэн судалгаа, тайлан, дүгнэлт.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд удирдаж, аудитын менежер Х.Баярмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Сандуйжав, аудитор Ш.Наранбаатар, Ж.Чинбат, А.Мөнхбадрал, С.Оюун-Эрдэнэ, С.Номин-Эрдэнэ, А.Төгөлдөр нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл

Нийгмийн даатгалын тухай хууль 1994 оны 5 дугаар сарын 31-ний өдөр батлагдсанаас хойш нийт 31 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулж, 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс дагаж мөрдсөн байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль,
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль,
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль,
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх харилцааг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулахаар тусгасан байна.

Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгаар дараах зохицуулалтууд шинээр туссан байна. Үүнд:

- Хуримтлалын тогтолцоонд шилжих,
- Тэтгэврийн нөөц сан бүрдүүлэх,
- Тэтгэврийн нөөц санд бүрдсэн мөнгөжүүлсэн орлогоос өвлүүлэх,
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах,
- Цалин хөлсөнд хэрэглэх итгэлцүүрийг жил бүр шинэчлэн тогтоох, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөхийг хориглох,
- Олон давхаргат тогтолцоонд шилжих,
- Олон жил шимтгэл төлөхийг урамшуулах,
- Тэтгэмжийн хэмжээ, хугацаа нэмэгдүүлэх,
- ҮОМШӨД-ийн үйлчилгээний төрөл протез, ортопедийн зардал гэх мэт.

Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээнд дараах байдлаар өөрчлөлт орсон байна.

Хүснэгт 1. Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний өөрчлөлтийн харьцуулалт

Нийгмийн даатгалын төрөл	Нийгмийн даатгалын ерөнхий хууль			Нийгмийн даатгалын тухай хууль		
	Албан журмын даатгал		Сайн дурын даатгал	Албан журмын даатгал		Сайн дурын даатгал
	Ажил олгогч	Даатгуулагч	Даатгуулагч өөрөө мэдүүлсэн орлогоос	Ажил олгогч	Даатгуулагч	Даатгуулагч өөрөө мэдүүлсэн орлогоос
Тэтгэврийн даатгал	8.5	8.5	11.5	8.5	8.5	11.5
Тэтгэмжийн даатгал	1	0.8	1	1	0.8	1
Ажилгүйдлийн даатгал	0.5	0.2	-	0.2	0.2	-
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	0.5, 1.5, 2.5	-	1	1.8, 2.8	-	1
Нийт	10.5, 11.5, 12.5	9.5	13.5	11.5, 12.5	9.5	13.5


Эх сурвалж: legalinfo.mn

БҮЛЭГ 1. Нийгмийн даатгалын санг оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн болон менежмент хийх, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх замаар санг арвижуулах, тогтвортой байдлаар удирдах тогтолцоо бүрдээгүй байна

Нийгмийн даатгалын харилцааг зохицуулж буй хууль, тогтоомж, баримталж буй бодлогын зорилт арга хэмжээний уялдаа бүрэн хангагдаагүй байна.

1.1. Монгол Улсад баримталж буй урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан нийгмийн даатгалын талаарх зорилго, зорилт нь гол төлөв **“Тэтгэвэр”**-т чиглэсэн байна. Өөрөөр хэлбэл нийгмийн даатгалын хүрээнд тэтгэврийн шинэчлэл хийх бодлогыг голчлон баримталж байна.

1.2. Нийгмийн даатгалын шинэчлэл хийх зорилт, арга хэмжээ хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан ч эдгээр зорилт, арга хэмжээнд НДС-г хэрхэн үр ашигтай удирдах, шаардлагатай санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх талаар тусгаагүй байна. Тодруулбал: НДС-г зүй зохистой удирдах бодлого байхгүй байна.



1.3. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт дээрх байдлаар зорилт дэвшүүлсэн ч хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээнүүд нь зорилтдоо бүрэн чиглээгүй, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээтэй бүрэн уялдахгүй байна.

1.4. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг ерөнхий байдлаар тодорхойлсон, арга хэмжээ тус бүрээр шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй байгаа нь ХБТТУТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.22¹-т заасныг, мөн "төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх зарчим"², "шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх зарчим"³, "зорилго, зорилт хэмжигдэхүйц байх зарчим"⁴-ыг хангаагүй байна.

1.5. Энэ нь нийгмийн даатгалын асуудлаар баримталж буй бодлого оновчтой эсэх, нийгэмд бодит үр нөлөө үзүүлж буй эсэхийг хэмжиж, үнэлэх боломжгүй нөхцөлийг үүсгэж байна.

1.6. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд НДЕГ болон ГБХНХЯ-аас хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн боловч ХБТТУТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.18.⁵-д заасан "Бодлогын үр нөлөө"-г үнэлээгүй байна. Энэ нь дээрх байгууллагууд ХБТТУТХ-ийн 21.3 дугаар зүйлд заасан "цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ" хийгээгүйг харуулж байна.

¹"шалгуур үзүүлэлт" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан тоон болон чанарын үзүүлэлтийг; гэж заасан байна.

² хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлснээр бий болох үр дүнг тодорхойлж, түүнд чиглэсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхой зохион байгуулалт, дэс дарааллын дагуу төлөвлөхийг

³хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн гүйцэтгэлийг тоон болон чанарын үзүүлэлтээр хянах боломжтой байхыг;

⁴хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилтын гүйцэтгэлийг бодлого, төлөвлөлтийн үйл явцад тодорхой тоон болон чанарын үзүүлэлт бүхий шалгуур үзүүлэлтийг ашиглан үнэлж, хэмжих боломжтой байхыг;

⁵"бодлогын үр нөлөө" гэж бодлогыг хэрэгжүүлснээр хүний хөгжил, нийгэм, байгаль орчин, эдийн засаг, засаглалын хүрээнд бий болох эерэг өөрчлөлтийг;


1.7. Нийгмийн даатгалын үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомж нь баримталж буй бодлогын зорилго, зорилттой харилцан уялдаатай эсэхийг авч үзэхэд дараах байдалтай байна.

1.8. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д нийгмийн даатгалын төрлийг заасан ба эдгээр төрөл тус бүрийн харилцааг зохицуулсан хууль, даатгуулагчид үзүүлж буй үйлчилгээний зураглалыг харуулбал:

Нийгмийн даатгалын төрөл				
Тэтгэвэр	Тэтгэмж	Ажилгүйдэл	ҮОМШӨ	Эрүүл мэнд
Харилцааг зохицуулсан хууль				
Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль		Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль	Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
Даатгуулагчид үзүүлж буй үйлчилгээ				
Өндөр насны тэтгэвэр	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	Ажилгүйдлийн тэтгэмж	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	Жирэмсний болон амаржсаны тэтгэмж		Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, халдварт өвчний эсрэг дархлаажуулалтад хамруулах төлбөр
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж		Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж	
	Гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа сайн дураар даатгуулагч эхийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн төлбөр		Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр	
			Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	

Даатгуулагчийн
эрүүл мэндийн
нөхөн сэргээлтийн
зардлын төлбөр
Хөдөлмөрийн
чадвар алдсаны
тэтгэвэр авагчийн
тэтгэврийн
даатгалын
шимтгэлийн
төлбөр

1.9. Даатгуулагчид үзүүлж буй дээрх үйлчилгээнээс “Өндөр насны тэтгэвэр” тогтоох үйл явцад дараах асуудлууд байна. Үүнд:



Өндөр насны тэтгэвэр

- Нийгмийн даатгалын хууль тогтоомжоор бус салбарын хууль тогтоомжоор тэтгэврийн хувь хэмжээг тогтоодог,
- Хөнгөлөлттэй нөхцлөөр тэтгэвэр тогтоох хуулийн заалтууд болон гэнэтийн шийдвэр гаргаж тэтгэвэр тогтоолгох эрх үүсгэж байгаа нь санд ачаалал үүсгэдэг.

1.10. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 3.2-д “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх харилцааг зөвхөн нийгмийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулна” гэж заасан байна.

1.11. Гэтэл зарим салбарын хууль тогтоомж болох Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Шүүхийн тухай хууль, Прокурорын тухай хуульд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа, өндөр насны тэтгэвэрт гарах нас, өндөр насны тэтгэвэр бодох хувь хэмжээг нийгмийн даатгалын талаарх хууль тогтоомжоос ялгаатай байдлаар тусгайлан зохицуулсан байна.

Хүснэгт 2: Өндөр насны тэтгэврийг салбарын хуулиар зохицуулж буй байдал

Үзүүлэлт	Өндөр насны тэтгэвэр тогтоох шалгуур			
	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль	Шүүхийн тухай хууль	Прокурорын тухай хууль
Нас	65	65	60	60
Шимтгэл төлсөн болон ажилласан жил	Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлсөн, тэтгэврийн даатгалын шимтгэлийг 25-аас доошгүй жил төлсөн 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй		55 насанд хүрсэн, эсхүл шүүгчээр 25 жил ажилласан бол өөрийн хүсэлтээр, Шүүгчээр 30, түүнээс дээш жил	50 насанд хүрсэн эмэгтэй, 55 насанд хүрсэн эрэгтэй, эсхүл нас харгалзахгүй прокуророор 25 жил ажилласан

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

			ажилласан 55 насанд хүрсэн. ⁶	бол өөрийн хүсэлтээр ⁷
Тэтгэвэр тогтоох хувь	45	60 ⁸	45	45

1.12. Хуулийн ялгаатай нөхцөл байдлаас хамааран дараах нөхцөл байдал үүсэж байна. Тухайлбал:

Шүүгч болон прокуророор ажиллаж байсан даатгуулагч салбарын хуульд заасан нөхцөлийг хангаж, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан тэтгэвэр тогтоолгох наснаас өмнө хүсэлт гаргасан тохиолдолд Нийгмийн даатгалын байгууллагаас тухайн хүсэлтийг хүлээн авдаггүй бөгөөд иргэд шүүхэд хандан, шүүхээс өндөр насны тэтгэврийг тогтоож олгох шийдвэр гарсан тохиолдолд тэтгэврийг тогтоон, олгож байна.

Үндсэн хуулийн Цэцийн гишүүн болон гишүүнээр ажиллаж байсан хүнд өндөр насны тэтгэвэр тогтоохдоо **2015 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тамгын газраас ирүүлсэн 4/315 тоот албан бичиг, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 1/273 тоот албан бичиг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тамгын газрын 2024 оны 2/223 тоот албан бичгээр** ирүүлсэн чиглэлийг мөрдөж Үндсэн хуулийн цэцийн гишүүний тэтгэврийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 60 хувиар тооцон тэтгэврийг тогтоож байна.

1.13. Иймд Монгол Улсын дээд шүүх нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” бүрэн эрхтэй байгууллага тул тус байгууллагаар албан ёсны тайлбар гаргуулж энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Дээрх салбар хуулиуд нь нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд тусгагдаагүй учраас тэтгэврийн программд бүртгэгддэггүй гэх шалтгаанаар салбарын хуулиар хэдэн иргэн тэтгэвэрт гарсан талаарх тооцоо судалгаа, мэдээлэл байхгүй байна. Иймд нийгмийн даатгалын сангийн бүрдүүлэлт зарцуулалтад ямар нөлөө үзүүлж байгаа эсэхийг дүгнэх боломжгүй байна.

1.14. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлд хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох дараах эрхийг тусгасан байна. Хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3: Хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх

Хөнгөлөлттэй нөхцөл	Шалгуур үзүүлэлт
Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийн тэтгэвэр	Шимтгэл төлсөн байвал зохих хугацаа: 20 жил ба түүнээс дээш Нас: эмэгтэй 50 нас хүрсэн даатгуулагч өөрөө хүсвэл 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж, 3 хүртэл настайд нь үрчлэн авч 6 нас хүртэл нь өсгөсөн. Төрүүлж, өсгөсөн хүүхэд бүрийн тоогоор шимтгэл төлсөн хугацааг 1 жил 6 сараар нэмэгдүүлэн тооцно. (Энэ зохицуулалт нийгмийн даатгалын шимтгэлийг 10 ба түүнээс дээш жил төлсөн, хүүхэдтэй бүх эхчүүдэд хамаарна)

⁶ Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь заалт

⁷ Прокурорын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь заалт

⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэг

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн тэтгэвэр	<p>Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс доор дурдсан хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж шимтгэл төлсөн тохиолдолд өөрөө хүсвэл тухайн насанд хүрээд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд 10 жил шимтгэл төлсөн 50 хүрсэн эрэгтэй, Газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд 7 жил, 6 сар шимтгэл төлсөн 45 хүрсэн эмэгтэй, Хөдөлмөрийн хүнд нөхцөлд 12 жил, 6 сар шимтгэл төлсөн, 55 нас хүрсэн эрэгтэй, Хөдөлмөрийн хүнд нөхцөлд 10 жил шимтгэл төлсөн, 50 нас хүрсэн эмэгтэй
Онцлог ажил, мэргэжлийн тэтгэвэр	<p>Доор дурдсан ажил мэргэжлээр 20-иос доошгүй жил, эсхүл нийтдээ 25-аас доошгүй жил үүнээс 15-аас доошгүй жил сонгодог, мэргэжлийн урлагийн байгууллагын тухайн ажил мэргэжлээр ажилласан даатгуулагч өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Гоцлол дуучин Бүжигчин Агаарын болон хэрэглэлийн гимнастик Акробат Тэнцвэр, уран нугаралт Хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин Зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч Хөөмийчин Найрал хөгжмийн үлээвэр хөгжимчин
Бусад нөхцөлийн тэтгэвэр	<ul style="list-style-type: none"> Төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд 25-аас доошгүй жил ажилласан даатгуулагч өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно. Нийтдээ 20-оос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, үүнээс 15 жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 55 нас хүрсэн эрэгтэй. Нийтдээ 20-оос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, үүнээс 12 жил 6 сар малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 50 нас хүрсэн эмэгтэй.

1.15. Эдгээр нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр авч байгаа иргэд ердийн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр авч байгаа иргэдээс 5 – 10 жилийн өмнө тэтгэвэрт гарч байгаа ба дунджаар нийт тэтгэвэр авагчдын 46 хувийг эзэлж байна. Ердийн болон хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр авч байгаа иргэдийн мэдээллийг харуулав.

Хүснэгт 4: Өндөр насны тэтгэвэр авагч иргэдийн тоо, санхүүжилтийн дүн /сая төгрөг/

Тэтгэврийн төрөл	2022		2023	
	Тэтгэвэр авагч иргэдийн тоо	Санхүүжилтийн дүн	Тэтгэвэр авагч иргэдийн тоо	Санхүүжилтийн дүн
Нийт дүн	372,029	2,408,000.9	382,755	2,887,231.4
Ердийн нөхцөл	200,310	1,331,221.5	207,829	1,630,711.5
Нийт дүнд эзлэх хувь	53.8	55.3	54.3	56.5
Хөнгөлөлттэй нөхцөл	171,719	1,076,779.4	174,926	1,256,519.9
Нийт дүнд эзлэх хувь	46.2	44.7	45.7	43.5

Эх сурвалж: НДЕГ-ын судалгаа

Дээрх мэдээллээс харахад хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр авч байгаа иргэд дунджаар нийт санхүүжилтийн 44 хувийг эзэлж байна.

1.16. Иргэд өндөр насны тэтгэвэр тогтоолгоод дунджаар ямар хугацаанд тэтгэврээ авч байгааг харуулбал:

Хүснэгт 5: Тэтгэвэр авсан дундаж хугацаа, жилээр /2018-2022 нас барсан, зогсоогдсон өндөр насны тэтгэвэр авагчдын тоо, тэтгэвэр авсан хугацаа/

Тэтгэврийн төрөл	Эмэгтэй		Эрэгтэй		Нийт	
	Тэтгэвэр авагчдын тоо	Тэтгэвэр авсан дундаж хугацаа	Тэтгэвэр авагчдын тоо	Тэтгэвэр авсан дундаж хугацаа	Тэтгэвэр авагчдын тоо	Тэтгэвэр авсан дундаж хугацаа
Ердийн нөхцөл	17,267	17.1	23,519	12.7	40,786	14.6
Хэвийн	14,594	18.5	21,781	13.3	36,375	15.4
Хувь тэнцүүлсэн	2,673	9.4	1,738	5.1	4,411	7.7
Хөнгөлөлттэй нөхцөл	19,637	20.4	6,071	9.5	25,708	17.8
Олон хүүхэд төрүүлсэн эхийн болзлоор	17,452	21.1			17,452	21.1
Малчны тэтгэвэр	381	0.7	1,258	1.4	1,639	1.2
Хүнд нөхцөлөөр	1,188	17.6	3,987	11.4	5,175	12.8
Халуун, хортой нөхцөлөөр	603	18.1	682	12.1	1,285	14.9
Газрын дор			103	20.8	103	20.8
Урлагийн тэтгэвэр	13	6.2	36	9.6	49	8.7
Төмөр замын цэрэгжүүлсэн			5	6.1	5	6.1
Цэргийн алба хаасны	353	12.9	3,135	16.9	3,488	16.4
Бүгд	37,257	18.8	32,725	12.5	69,982	15.9

Эх сурвалж: НДЕГ-ын судалгаа

1.17. Дээрх мэдээллээс харахад ердийн нөхцөлт иргэн дунджаар 14.6 жил, хөнгөлөлттэй нөхцөлт иргэн дунджаар 17.8 жил тэтгэвэр авч байна.

Хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа иргэд ердийнхөөс 5-10 жилийн өмнө тэтгэвэрт гардаг, тэтгэврийн даатгалын сангийн 44 хувийг эзэлдэг, 7-15 жил шимтгэл төлөөд 17.8 жил тэтгэвэр авдаг зэргээс харахад эдгээр иргэд тэтгэврийн даатгалын санд илүү ачаалал үзүүлж байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, түүнд нөлөөлсөн зарим үзүүлэлтийн талаар тайлангийн “**Бүлэг 2**”-т харуулсан болно.

1.18. Нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөхтэй холбоотой болон цар тахлын үеийн шийдвэрүүд нийгмийн даатгалын сангийн нөөцийг бууруулахад нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөхтэй холбоотой шийдвэр



2012 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр батлагдсан “Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийн нөхөн тооцох тухай” хууль,

2015 оны 8 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан “Эдийн засгийн ил тод байдлын тухай” хууль,

2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хууль,

2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан “Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” хууль

Цар тахлын үеийн шийдвэр



2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай” хууль,

2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай” хууль,

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай” хууль,

2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай” хууль

Эдгээр шийдвэртэй холбоотой нийгмийн даатгалын санд үзүүлсэн нөлөөллийг тайлангийн “Бүлэг 2”-т харуулсан болно.

Сайн дураар даатгуулах

Нийгмийн даатгалын салбарын хууль, тогтоомжид зааснаар албан журмын болон сайн дураар даатгуулагч нар нийгмийн даатгалын сангаас ижил нөхцөлөөр тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авч байна.

Сайн дураар даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээ нь даатгуулагчийн өөрийн мэдүүлсэн орлого дээр үндэслэж байна. Шимтгэл төлөлтийн дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар заасан байна.

1.19. Сайн дураар даатгуулагч дараах хөнгөлөлт эдлэхээр НДЕХ-д заасан байна. Үүнд:

- **Хүүхдээ 3 нас хүртэл нь асрах чөлөөтэй байгаа эхийн сайн дурын даатгалын шимтгэл төлөлт:**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 6.1-д заасан нөхцөлийг хүүхэд төрүүлэх бүрд хангаж жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан эхийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас, бусад эхийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс тус тус сар бүр төлнө.

- **Малчин, туслах малчны сайн дурын даатгалын шимтгэл төлөлт:**

хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс сар бүр төлөхөөр байгаа бөгөөд улсын төсвөөс хариуцан төлөх хугацаа 5 жилээс ихгүй байна.

- **18 нас хүртэлх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/-ийн сайн дурын даатгалын шимтгэл төлөлт:**

Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг

даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлнө.

1.20. Дээрх хөнгөлөлтөд олгосон санхүүжилтийн мэдээллийг харуулбал:

Хүснэгт 6: Сайн дураар даатгуулагч нарт үзүүлсэн хөнгөлөлт

Д/д	Үзүүлэлт	2021	2022	2023	2024 оны 10 сар
1	Малчин даатгуулагчийн тоо				44,327
	Малчин даатгуулагчийн улсын төсвөөс хариуцсан шимтгэлийн дүн /сая төгрөг/				19,956.0
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх/эцэг-ийн тоо				2,989
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх/эцэг-ийн улсын төсвөөс хариуцсан шимтгэлийн дүн /сая төгрөг/				9,052.0
3	Гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн тоо	25,372	26,194	27,300	15,688
	Гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, шимтгэлийн дүн /сая төгрөг/ Үүнээс	7,953.4	7,342.9	7,609.1	8,220.8
	Тэтгэмжийн даатгалын сангаас	3,172.4	3,184.4	3,748.8	1,142.2
	Улсын төсвөөс	4,781.0	4,158.6	3,860.4	7,078.6
Нийт даатгуулагчийн тоо		25,372	26,194	27,300	63,004
Нийт хөнгөлөлтийн дүн /сая төгрөг/		7,953.4	7,342.9	7,609.1	37,228.8

Эх сурвалж: НДЕГ

1.21. Дээрх үзүүлэлтээс харахад 2024 оны эхний 10 сарын байдлаар нийт 63,004 даатгуулагчид 37,228.8 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн байна. Тус онд нийт 146,455 хүн сайн дураар даатгуулсан бөгөөд нийт 75,356.3 сая төгрөгийн шимтгэл төлсөн байна. Үүнээс харахад нийт даатгуулагчийн 43 хувь нь нийт төлсөн шимтгэлийн 49.4 хувьтай тэнцэх хэмжээний хөнгөлөлт эдэлсэн байна.

1.22. Цэргийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд зааснаар “Цэргийн жинхэнэ алба болон тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүх шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх” байгууллагын алба хаагчид цалингийн 80 хувиар тэтгэвэр тогтоолгох эрхтэй байна.

1.23. Эдгээр байгууллагын албан хаагчдын өндөр насны тэтгэврийг улсын төсвөөс санхүүжүүлж байна. Санхүүжилтийн мэдээллийг “**Бүлэг 2**”-т харуулсан болно.

Тэтгэврийн шинэчлэлийн бодлогын хувилбар

1.24. ХНХЯ /хуучин нэрээр/ хүсэлтээр 2019 онд Дэлхийн банкнаас Монгол Улсын тэтгэврийн асуудлаар урт хугацааны судалгаа, тооцоо хийн дараах бодлогын хувилбаруудыг санал болгосон байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын тогтолцоонд параметрийн шинэчлэл хийх. Үүнд:
 - Тэтгэврийг индексжүүлэн нэмэгдүүлдэг болох,
 - Тэтгэвэр бодоход баримтлах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджийг тооцох суурь хугацааг уртасгаж, хамрах хугацааны цалин хөлсийг итгэлцүүрээр нэмэгдүүлж тооцох,

- Тэтгэврийн насыг нэмэгдүүлж, тэтгэвэрт эрт гарах тохиолдолд тэтгэврийн хэмжээг актуар тооцооллын дагуу бууруулж⁹ тогтоодог болох,
- Шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх.
- Өнөөгийн хуваарилалтын тогтолцоо буюу цалинд суурилсан тэтгэврийн тогтолцоонд параметрийн өөрчлөлт хийж чадвал хийсвэр нэрийн дансны тогтолцооны бүхий л давуу талыг өнөөгийн тогтолцоонд нэвтрүүлэх боломжтой.
 - Нэрийн дансны тогтолцоонд зөвхөн 1979 оноос хойш төрсөн даатгуулагчдыг хамруулна гэхгүйгээр бүх даатгуулагчийг тодорхой нэг өдөр цагт уг тогтолцоонд зэрэг шилжүүлэх,
 - Тэтгэврийн баталгаат доод хэмжээ гэх өнөөгийн зохицуулалтыг халж, орлогоос хамаарсан суурь тэтгэврийг нэвтрүүлэх.
- Тэтгэврийн бүрэн хуримтлалын тогтолцоог Монгол Улсад хэрэгжүүлэх боломж бүрдээгүй, уг тогтолцоог хэрэгжүүлэхийг зөвлөх боломжгүй.
- Тэтгэврийн өнөөгийн тогтолцоонд параметрийн өөрчлөлт хийх, орлогоос хамаарсан суурь тэтгэврийг нэвтрүүлэх гэсэн хоёр шинэчлэлийг хослуулж хэрэгжүүлбэл Монгол Улсын тэтгэврийн тогтолцооны тогтвортой, шударга байдал, мөн тэтгэврийг урьдчилан таамаглах боломжийг эрс нэмэгдүүлнэ.
 - Тэтгэврийн одоогийн тогтолцоонд параметрийн шинэчлэл хийхгүй удах тусам тэтгэврийн зардал нэмэгдэж, шилжилт хийхэд илүү хүндрэлтэй болно.

1.25. Гэсэн хэдий ч дээрх бодлогын хувилбаруудыг одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомжид тусгаагүй, тэтгэврийн даатгалын системд харгалзан үзээгүй байна.

Эрүүл мэндийн даатгалтай холбоотой асуудал

1.26. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлд заасанчлан эрүүл мэндийн даатгал нь нийгмийн даатгалын нэг төрөл бөгөөд үйл ажиллагааг нь ЭМДЕГ, бусад даатгалын үйл ажиллагааг НДЕГ хариуцан явуулж байна. ЭМДЕГ нь ЭМЯ-нд, НДЕГ нь ГБХНХЯ-нд харьяалагдаж байна.

1.27. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан зарим заалтыг авч үзвэл:

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль	Нийгмийн даатгалын ерөнхий хууль
3.1.3. "Эрүүл мэндийн даатгалын байгууллага" гэж эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчийн өмнөөс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг;	4.1.6. "Нийгмийн даатгалын байгууллага" гэж нийгмийн даатгалын сан бүрдүүлж, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зэрэг үйл
4.5. Эрүүл мэндийн албан журмын даатгалын үйл ажиллагааг эрүүл мэндийн даатгалын байгууллага эрхэлнэ.	
14.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан Үндэсний зөвлөл, эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны	

⁹ Тэтгэвэр эрт тогтоолгосон даатгуулагч болон тэтгэврийн нас хүрээд тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийн хэмжээ хоорондоо ялгаатай байх шударга зарчмыг хангахуйц актуар тооцооллыг нэвтрүүлэх

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сумын эрүүл мэндийн даатгал хариуцсан байцаагчаас бүрдэнэ”	ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг;
19.3. Энэ хуулийн 6.1.1, 6.1.11-д заасан эрүүл мэндийн даатгалд хамрагдах бүлгийн даатгуулагчийн шимтгэл, 19.1.8-д заасан шимтгэл, алдангийг цуглуулах, төвлөрүүлэх үйл ажиллагааг нийгмийн даатгалын байгууллага гүйцэтгэх бөгөөд үүнтэй холбогдсон харилцааг Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар зохицуулна.	21.31. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх харилцааг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулна.
19.4. Нийгмийн даатгалын байгууллага төвлөрүүлсэн хөрөнгийг долоо хоног бүр эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлнэ.	
24.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дотоод хяналтын нэгжтэй байх ба дотоод хяналтын нэгжийн дүрмийг Нийгмийн даатгалын байгууллага баталж мөрдөнө.	

1.28. Дээрх заалтуудаас ЭМДТХ-ийн 14.1 дэх заалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Тодруулбал:

Энэ заалтад “Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан Үндэсний зөвлөл” гэж тусгасан байгаа нь:

1. *Нийгмийн даатгалын тухай хууль (1994) хүчингүй болсон,*
2. *Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн үндэсний зөвлөл нь нэг зөвлөл байхаар хэдий ч тусдаа зөвлөлүүд үйл ажиллагаа явуулж байна.*

Иймд уг заалтыг шинэчлэн найруулах шаардлага бий болсон байна.

Дээрх нөхцөл байдлуудаас харахад эрүүл мэндийн даатгал нь нийгмийн даатгалд хамааралгүй, тусдаа бие даасан төрөл мэт тодорхойгүй, хуулийн заалтууд уялдаагүй, үйл ажиллагааг нь удирдан зохион байгуулж байгаа байгууллага, тогтолцоо тусдаа зэрэг нь нарийвчилсан зохицуулалт шаардлагатай байгааг харуулж байна.

1.29. Энэ нөхцөл байдлын үр дүнд ЭМДЕГ болон НДЕГ хоорондын харилцааг зохицуулах хүрээнд хамтран ажиллах гэрээг 2019 оноос хойш байгуулан ажиллаж ирсэн байна.

1.30. НДЕГ нь төвлөрүүлсэн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг ЭМДС-д шилжүүлэхдээ ажил олгогч болон даатгуулагч тус бүрийн төлсөн шимтгэлийн дүнгийн мэдээллийг ЭМДЕГ-т хүргүүлдэггүй байна.

1.31. Үүний улмаас ЭМДЕГ Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан¹⁰ зарим чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломжгүй, мөн шимтгэл төлөлтийн мэдээлэлд үндэслэн санхүүгийн дүн шинжилгээ хийх, салбар бүрд ажиллаж буй даатгуулагчийн нас, хүйс, ажил мэргэжлийн онцлогт тохирсон тусламж, үйлчилгээний багц гарах талаар судлан дүн шинжилгээ хийх нөхцөл бүрдэхгүй байна.

1.32. ЭМДЕГ нь судалгааны ажил хийх, мөн өөрийн орлогыг бүрэн хянах боломж бүрдүүлэх зорилгоор 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 01/2373 тоот албан бичгээр Нийгмийн даатгалын ерөнхий газарт хандсан боловч эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөн аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчийн регистрийн дугаар, шимтгэл төлөлтийн мэдээлэл нь

¹⁰16.1.2.эрүүл мэндийн даатгалын сан бүрдүүлэх, орлого, зарлагын тэнцвэрийг ханган ажиллах, үйл ажиллагаагаа тайлагнах;
16.1.7.эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлд санхүүгийн хяналт тавих;

нууцад хамаарах тул өгөх боломжгүй, харин нийтийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д¹¹, хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 6 зүйлийн 6.2.5-д¹² тус тус заасныг үндэслэн тодорхойлох боломжгүй өгөгдөл болгон нийт дүнгээр гаргах боломжтой гэдгээ илэрхийлсэн байна.

**Нийгмийн
даатгалын шимтгэл
АЛБАН ТАТВАР
биш.**

Иргэдийн төлсөн шимтгэлийн хувь хэмжээ, шимтгэл төлсөн хугацааг тэтгэвэр тогтоолгосон хувь хэмжээ, тэтгэвэр авсан хугацаатай харьцуулахад дараах дүр зураг гарч байна.


Иргэн дунджаар 20 гаруй жил орлогын 26 хувиар шимтгэл төлж, тэтгэвэрт гарсны дараа 15.9 жил 45 хувиар тэтгэвэр авахаар байна. Тэтгэврийг жил бүр нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа нь цаашид 45 хувь өсөхөөр байна. Мөн тэтгэмж, төлбөр зэргээр даатгалын санхүүжилтээр бусад үйлчилгээ авч байна.

Энэ нь иргэн төлсөн шимтгэлээс илүү тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлттэй үйлчилгээ авч байгааг харуулж байна.

1.33. НДШ нь иргэнд дээрх байдлаар үр нөлөө үзүүлж байгаа ч зарим иргэд, нийтийн дунд ойлголт өөр байна. Аудитын явцад сарын хугацаанд цахим хэлбэрээр нийгмийн даатгалын талаар санал асуулга авахад нийт 9,423 иргэн хамрагдсан. Санал асуулгын дүнг харуулбал:

Санал асуулга: Таны бодлоор НДШ гэж юу бэ?

Дүрслэл 1: НДШ-ийн талаар иргэдийн ойлголт



Санал асуулгад оролцсон нийт иргэдийн 37 хувь нь НДШ-ийг “цалингаас суутгадаг татвар, үр ашиггүй зардал” гэж үзсэн байна.

1.34. Энэ нь иргэд, олон нийтэд НДШ-ийн талаарх зөв ойлголтыг төлөвшүүлэх үйл ажиллагааг илүү сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Нийгмийн даатгалын үйл ажиллагааг зохистой удирдах удирдлагын оновчтой тогтолцоо бүрдээгүй байна

1.35. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын харилцааг бодлогоор чиглүүлэх, хариуцан гүйцэтгэх, дэмжин ажиллах, хянах чиг үүрэг бүхий зохион байгуулалтын 128 нэгж,

¹¹ Хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр, тэдгээрийн эрэлт, хэрэгцээг харгалзан эдийн засаг, бизнесийг дэмжих, судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй, хязгаарлалттай болон хаалттай мэдээллийн хүн, хуулийн этгээд, төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон боловсруулж, нээлттэй өгөгдөл болгож болно.

¹² Хүнийг тодорхойлох боломжгүй болгож түүх, эрдэм шинжилгээ, урлаг, утга зохиолын бүтээл туурвих, статистикийн мэдээлэл бэлтгэх.


ны Ерөнхий зохицуулалтын газрын дарга нарын бүрэлдэхүүн томилогдсон байна. Даатгуулагчийг төлөөлж 2016 онд томилогдсон нэг гишүүнийг чөлөөлсөн болон улируулан томилсон ямар нэгэн шийдвэр гараагүй байна.

1.41. ГБХНХЯ-ны чиг үүргийг НДЕХ-ийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан бөгөөд үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг ЗГ-ын 2023 оны 441 дүгээр тогтоолоор баталсан байна.

1.42. ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/46 дугаар тушаалаар яамны бүтэц, орон тоо, бүтцийн нэгжийн чиг үүргийн хуваарийг баталсан боловч газар, хэлтсийн чиг үүргийг нарийвчилсан байдлаар батлаагүй байна.

1.43. НДЕГ-ын чиг үүргийг НДЕХ-ийн 37 дугаар зүйлийн 37.13 дахь хэсэг, ЗГ-ын 2023 оны 469 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-д тусгасан. ХНХС-ын 2024 оны А/19 дүгээр тушаалаар “Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т НДЕГ болон түүний газар, хэлтсийн үндсэн чиг үүргийг ерөнхий байдлаар баталсан байна.

Дүрслэл 3: НДЕГ-ын дотоод болон дэргэдэх газруудын батлагдсан бүтэц, орон тоо /2024 он/



1.44. ХНХС-н 2024 оны А/19 дүгээр тушаалаар НДЕГ-ын дотоод бүтцийг 7 газар 5 хэлтэстэй, НДЕГ-ын дэргэд БНСУ дахь НДТ, Мэдээллийн технологийн төв, Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл, Маргаан хянан шийдвэрлэх төв зөвлөлийг ажиллуулахаар, ХНХС-ын 2024 оны А/45 дугаар тушаалаар нийгмийн даатгалын төв болон орон нутгийн орон тооны дээд хязгаарыг 1,485 байхаар баталсан байна.

1.45. Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны батлагдсан орон тоог гүйцэтгэлтэй нь харьцуулан харуулбал:

Хүснэгт 7: Нийгмийн даатгалын байгууллагын орон тооны мэдээлэл /2024.6 сарын байдлаар/

Байгууллагын нэр	Бүтэц, орон тоог баталсан шийдвэр	Батлагдсан орон тоо	Ажиллаж байгаа албан хаагчдын тоо	Сул орон тоо
НДЕГ	НДЕГ-ын даргын 2024 оны А/53 дугаар тушаал	93	88	5
Аймаг, дүүргийн НДГ	НДЕГ-ын даргын 2024 оны А/51, А/52 дугаар тушаал	1345	1220	125
Мэдээллийн технологийн төв	НДЕГ-ын даргын 2024 оны А/41 дүгээр тушаал	19	13	6
БНСУ дахь НДТ	ХНХС-ын 2024 оны А/107 дугаар тушаал	8	8	-
Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл	НДЕГ-ын даргын 2024 оны А/44 дүгээр тушаал	8	3	5
Нийт				141

Эх сурвалж: НДЕГ

1.46. Дээрх мэдээллээс харахад нийгмийн даатгалын байгууллага нийт 141 орон тоо дутуу ажиллаж байна. НДЕГ-ын 2024 оны А/11 дүгээр тушаалаар Маргаан хянан шийдвэрлэх төв зөвлөлийн орон тооны бус 9 гишүүн тус тус томилогдон ажиллаж байна.

НДЕГ-ын албан хаагчдын тоо, үйл ажиллагааны зардал, сая төгрөг

2020	2021	2022	2023	2024.06
89 албан хаагч 2,069.4 сая.төг	89 албан хаагч 1,974.8 сая.төг	85 албан хаагч 2,108.2 сая.төг	87 албан хаагч 2,774.7 сая.төг	88 албан хаагч 1,030.9 сая.төг

Аймаг, дүүргийн НДГ -ын албан хаагчдын тоо, үйл ажиллагааны зардал, сая төгрөг

2020	2021	2022	2023	2024.06
1306 албан хаагч 21,920.6 сая.төг	1285 албан хаагч 21,712.4 сая.төг	1243 албан хаагч 22,710.4 сая.төг	1240 албан хаагч 35,757.9 сая.төг	1220 албан хаагч 22,830.5 сая.төг

Эх сурвалж: НДЕГ

1.47. НДЕГ 2020-2023 онд жилд дунджаар 2,231.8 сая төгрөгийн, аймаг, дүүргийн НДГ 25,525.4 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажилласан байна.

1.48. НДЕХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1-т Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоонд “.... аймаг, **нийслэл**, дүүргийн нийгмийн даатгалын газар..... аас бүрдэнэ” гэж заасан ба Нийслэлийн нийгмийн даатгалын газрыг ЗГ-ын 2024 оны 138 дугаар тогтоолоор татан буулгасан байна.

1.49. Аймаг, дүүргийн НДГ-т нийт 755 албан хаагч байцаагчаар ажиллаж байгаа ба 17 аймгийн 31 суманд улсын байцаагчгүй байгаа нь эдгээр сум тус бүрийн 1,1-3,7 мянган хүн амд нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн, шуурхай авах боломж хязгаарлагдмал байна.

1.50. Олон улсын туршлага (Канад, Япон, Итали, Норвег)-аас үзэхэд нийгмийн даатгалын сангийн сайн засаглал нь захиргааны болон хөрөнгө оруулалтын менежментийн байгууллагын тогтолцоог тусад нь ажиллуулдаг байна. Менежментийн байгууллага улс төрийн болон аливаа хөндлөнгийн нөлөөллөөс ангид хараат бусаар, мэргэжлийн түвшинд сангийн удирдлага, менежментийн үйл ажиллагааг оролцогч талуудын ашиг сонирхолд нийцүүлэн явуулна. Сангийн үйл ажиллагааны үндсэн зорилгод нийцүүлэн хөрөнгийг засгийн газрын хөрөнгөөс хатуу тусгаарладаг байна.

1.51. Нийгмийн даатгалын сангийн бодлогод чухал байр суурь эзлэх хөрөнгийг удирдах, менежмент хийх мэргэжлийн байгууллагын тогтолцоо буюу Олон нийтийн хяналтын зөвлөл,

Мэргэжлийн хороог хуулиар бий болгосон байна. Эдгээр зөвлөлийг НДҮЗ-ийн 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолоор байгуулсан байна.

1.52. ХНХС-ын 2024 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан НДЕГ-ын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг болон албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтуудад тусгагдсан зорилго, зорилт, чиг үүргээс үзэхэд НДБ-ын дотоод үйл ажиллагаа болон НДС-ийн үйл ажиллагаанд хамаарах чиг үүрэг нэг нэгжид холилдон орсон, тухайн нэгжид хамааралгүй чиг үүрэг туссан, байвал зохих чиг үүрэг тусаагүй байна. Тухайлбал,

- НДЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д заасан “Нийгмийн даатгалын байгууллага” хэмээх хуулийн этгээдийн дотоод зохион байгуулалтын бодлого, үйл ажиллагаа ба 4.1.8-д заасан “Нийгмийн даатгалын сан”-г удирдан зохион байгуулах бодлого, үйл ажиллагаа тусдаа зохицуулагдаагүй;
- Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогыг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг тооцох шалгуур үзүүлэлтийг боловсруулах, тооцоо хийх, үр дүнд суурилсан төлөвлөлт хийх зэрэг бодлогын чанартай чиг үүрэг тусаагүй;
- НДЕХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.2-т заасан НДБ-ын үйл ажиллагаа нь ил тод байх зарчим, 37 дугаар зүйлийн 37.14.11-т заасан нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт болон хөрөнгө оруулалтын мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах чиг үүрэг тусаагүй;
- Байгууллагын албан хаагчдын сургалт, хөгжлийг сайжруулах үйл ажиллагаа нь ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа Захиргаа, удирдлагын газарт холилдон орсон;
- НДС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих, тэтгэврийн нөөц сан бүрдүүлж хуримтлал бий болгох, сангийн өр авлагыг барагдуулах зэрэг сангийн үйл ажиллагааг голлон эрхэлдэг Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газарт байгууллагын өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа холилдон орсон;
- Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газарт БНСУ-д ажиллаж амьдарч буй Монгол Улсын иргэдийг нийгмийн даатгалд даатгуулах, тэдэнд Нийгмийн даатгалын хууль тогтоомж, эрх зүйн туслалцаа үзүүлэх гэсэн хамааралгүй ажил орсон;
- Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа техник, хэрэгсэл, дотоод сүлжээ, хэрэглээний болон бусад программын хэвийн ажиллах нөхцөлөөр хангах зэрэг байгууллагын үйл ажиллагаа нь Үйлчилгээний хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газрын чиг үүрэгт туссан.

1.53. НДЕХ-ийн 37 дугаар зүйлийн 37.10-т зааснаар БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвд Нийгмийн даатгалын тасаг үйл ажиллагаа явуулж байгаа ба ХНХС-ын 2024 оны А/107 дугаар тушаалаар төвийн зохион байгуулалтын бүтэц, дүрмийг шинэчлэн баталсан. Дүрэмд зааснаар Төвийн даргыг Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, ажилтнуудыг төвийн дарга томилж, чөлөөлөх ба Нийгмийн даатгалын тасгийг НДЕГ-аас мэргэжил арга зүйгээр хангана. Ажилтан томилогдон ажиллах хугацаа 2 жил байх бөгөөд томилолтын хугацааг нэг удаа 2 жилээр сунгаж болно. 2024 оны 09 дүгээр сарын байдлаар Нийгмийн даатгалын тасгийн 8 албан хаагчийн 2 нь томилолтын хугацаа хэтэрсэн байна.

БНСУ дахь НДТ-ийн албан хаагчдын тоо, үйл ажиллагааны зардал, сая төгрөг

2020	2021	2022	2023	2024.06
8 албан хаагч	8 албан хаагч	8 албан хаагч	8 албан хаагч	8 албан хаагч
738.9 сая.төг	746.0 сая.төг	819.1 сая.төг	1,026.2 сая.төг	518.6 сая.төг

Эх сурвалж: НДЕГ

1.54. БНСУ дахь Нийгмийн даатгалын тасаг 2020-2023 онуудад жилд дунджаар 832.5 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажилласан ба үүний 70.1 хувийг цалин, нэмэгдэл урамшууллын зардал эзэлж байна.

Эрүүл мэндийн даатгал

1.55. Эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ЭМДҮЗ, Ажлын алба, ЭМЯ, ЭМДЕГ, аймаг, дүүргийн ЭМДХ зэрэг байгууллагууд үйл ажиллагаа явуулж байгаа ба удирдлага, зохион байгуулалт, эрх, чиг үүрэг, хариуцлагыг ЭМДТХ болон холбогдох дүрэм, журмаар зохицуулсан байна.

1.56. Эдгээр байгууллагуудад 2024 оны хагас жилийн байдлаар 223 албан хаагч ажиллаж байгаа ба 2023 оны жилийн эцсийн байдлаар 10.7 тэрбум төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

1.57. Үйл ажиллагааны зардал (ЭМЯ-наас бусад) ЭМД-ын сангаас санхүүжиж байгаа ба 91.5 хувь нь ЭМД-ын байгууллагын үндсэн үйл ажиллагаа буюу ЭМД-аар тусламж үйлчилгээ худалдан авах, нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг хийх, ЭМБ-уудад хяналт, шалгалт, чанарын үнэлгээ хийх, ЭМД-ын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй ЭМДЕГ болон аймаг, дүүргийн ЭМДХ-т хамаарч байна.

1.58. ЭМДТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-т ЭМДҮЗ нь Нийгмийн даатгалын тухай хууль/хуучин нэрээр/-ийн 27 дугаар зүйл заасан Үндэсний зөвлөл байна гэж заасан нь НДҮЗ-өөс тусдаа ЭМДҮЗ байгуулагдаж үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэсгүй байна.

1.59. ЭМДҮЗ-д даатгуулагчийг төлөөлж ШУА-ийн хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, МҮЭХ болон Төмөр замчдын ҮЭХ, ажил олгогчийг төлөөлж сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны ерөнхийлөгч, ХӨСҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүний бүрэлдэхүүн томилогдсон байна.

1.60. ЭМДҮЗ нь 2020 онд 11, 2021 онд 4, 2022 онд 10, 2023 онд 6, 2024 оны эхний хагас жилд 6 удаа нийт 37 удаагийн хуралдаанаар 99 асуудлыг дунджаар 77.7 хувийн ирцтэйгээр хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргасан байна. Улиралд хоёроос доошгүй хуралдах хуулийн хэрэгжилт хангалтгүй, гуравны хоёроос доошгүй ирцтэй байх шаардлагыг 2022 оны 8 дугаар хуралдаан хангахгүй байхад уг хурлаас гарсан шийдвэрээр тогтоол гаргасан байна. (Ажлын албаны даргад урамшуулал олгох тухай)

1.61. ЭМДҮЗ-ийн дэргэд ажиллах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэгтэй Техникийн хорооны гишүүдийн урамшууллыг 2024 оны төсвийн төсөлд тусган оруулсан ч хасагдаж батлагдсан тул тус хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон байна.


1.62. ЭМДТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-т ЭМЯ-ыг ЭМД-ын байгууллагын тогтолцооны нэг хэсэг байхаар заасан боловч чиг үүргийг тусгайлан тусгаагүй байна. ЗГ-ын 2021 оны 231 дүгээр тогтоолоор ЭМЯ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц орон тооны хязгаарыг шинэчлэн баталж, ЭМД-тай холбоотой Бодлого төлөвлөлтийн газар (Стратеги удирдлагын хэлтэс), Санхүү, эдийн засгийн газар (Санхүү даатгалын хэлтэс)-тай байхаар тусгаж, ажлын байрны үндсэн чиг үүргийг ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/130 дугаар тушаалаар баталсан байна.

1.63. ЭМДЕГ-ын чиг үүргийг ЭМДТХ-ийн 16 дугаар зүйл, “Эрүүл мэндийн даатгалын байгууллагын дүрэм”-д баталсан ба ЭМС-ын 2020 оны А/556 дугаар тушаалаар агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт ЭМДЕГ болон түүний газар, хэлтсийн үндсэн чиг үүргийг, ЭМДЕГ-ын 2022 оны А/26 дугаар тушаалаар агентлагийн газар хэлтсийн нарийвчилсан чиг үүргийг баталсан байна.

1.64. ЭМДҮЗ-ийн 2020 оны 17 дугаар тогтоол, ЭМС-ын 2020 оны А/556 дугаар тушаалаар тус газрын бүтцийг баталсан байна. ЗГ-ын 2020 оны 176 дугаар тогтоолоор ЭМДЕГ-ын орон

тоог 170 байхаар баталсан бол ЭМДЕГ-ын даргын 2024 оны А/11 дүгээр тушаалаар ЭМДЕГ-ын дотоод бүтцийг 5 газар 7 хэлтэстэй, 170 орон тоо, 21 аймаг 2 дүүрэгт 115 орон тоо нийтдээ 285 орон тоо баталсан байна.

Дүрслэл 4: ЭМДЕГ-ын дотоод бүтэц, орон тоо, /2024 он/



1.65. ЭМДЕГ-ын даргын 2024 оны А/11 дүгээр тушаалаар батлагдсан нийт 285 орон тооноос 2024 оны 06 дугаар сарын байдлаар ЭМДЕГ-т 129 албан хаагч, аймаг, дүүргийн ЭМДХ-т 70 албан хаагч томилогдон ажиллаж байна.

1.66. ЭМДЕГ-т 41 орон тоо, аймаг, дүүргийн ЭМДХ-т 45 орон тоо сул байгаа ба ЭМДЕГ-ын Худалдан авалт, гэрээлэлтийн газар, Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газар, аймаг, дүүргийн ЭМДХ-үүдэд нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг хийх, ЭМБ-уудад хяналт, шалгалт, чанарын үнэлгээ хийх, чанар, төлбөрийн хяналтад дүн шинжилгээ хийж тайлагнах, ЭМД-ын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн албаны нөөцөд бүртгэлтэй эмч мэргэжилтэй иргэн ховор байдаг шалтгаанаас сул орон тоо нөхөгдөхгүй байна. Үүнтэй холбоотойгоор дээрх хяналтын үйл ажиллагаа хязгаарлагдаж, түүвэрлэлт хийн нийт эх олонлогт тархаах байдлаар хяналтыг хэрэгжүүлж байна.

1.67. ЭМДТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-т зааснаар ЭМД хариуцсан байцаагч нь ЭМБ-ын тогтолцооны нэг хэсэг бөгөөд ЭМДЕГ-ын 2024 оны А/32 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн ажиллах дүрэм” шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан 79 албан хаагчийн эрхийг цуцлан, 97 албан хаагчид улсын байцаагчийн эрх олгосон байна.

1.68. ЭМД-ын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ЭМД-ын байгууллагуудын хувьд ЭМД санг оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн байдлаар удирдах, менежмент хийх, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх замаар санг арвижуулах, тогтвортой байдлыг хангах тогтолцоо бий болоогүй байна.

1.69. ЭМДЕГ-ын 2022 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан газар, хэлтсийн чиг үүргийг судлан үзэхэд дараах чиг үүрэг тусаагүй байна.

1. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогыг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг тооцох шалгуур үзүүлэлтийг боловсруулах, тооцоолол хийх, шаардлагатай хүний болон санхүүжилтийн нөөц бүрдүүлэх, үр дүнд суурилсан төлөвлөлт хийх, эрсдэлийг удирдах зэрэг бодлогын чанартай чиг үүрэг;
2. Даатгуулагчийн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоо биелүүлж байгаа эсэхийг судлах, ЭМД-ын бодлого эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр төрөл, чанарт нөлөөлж буй байдлыг судлах, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа болон ЭМД-ын уялдааг хангах бодлогын чиг үүрэг;

ЭМДЕГ-ын албан хаагчдын тоо, үйл ажиллагааны зардал, сая төгрөг

2020	2021	2022	2023	2024.06
105 албан хаагч 4,507.3 сая.төг	154 албан хаагч 6,390.0 сая.төг	130 албан хаагч 11,834.6 сая.төг	124 албан хаагч 8,7012.9 сая.төг	129 албан хаагч 5,733.5 сая.төг

Аймаг, дүүргийн ЭМДХ-ийн албан хаагчдын тоо, үйл ажиллагааны зардал, сая төгрөг

2020	2021	2022	2023	2024.06
55 албан хаагч 207.6 сая.төг	69 албан хаагч 908.7 сая.төг	72 албан хаагч 1,148.2 сая.төг	71 албан хаагч 1,795.8 сая.төг	70 албан хаагч 1,266.2 сая.төг

Эх сурвалж: ЭМДЕГ

1.70. ЭМДЕГ 2020-2023 онуудад жилд дунджаар 7,686.2 сая төгрөгийн, 21 аймаг, 2 дүүргийн ЭМДХ 1,015.0 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажилласан ба зардлыг эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт тусган хэрэгжүүлж байна. Даатгуулагчаас эрүүл мэндийн санхүүгийн эрсдэлийг бууруулах зорилгоор төлж байгаа шимтгэлийг байгууллагын үйл ажиллагааны зардалд зарцуулж байгаа нь оновчгүй байгаа тул улсын төсвөөс санхүүжүүлэх нь зүйтэй байна.

1.71. ЭМДХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “Эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь аймаг, дүүргийн **нийгмийн даатгалын хэлтэс**..... -аас бүрдэнэ” гэж заасан байна. Уг тогтолцоонд аймаг, дүүргийн “**эрүүл мэндийн даатгалын хэлтэс**”-ийг оруулахаар зохицуулаагүй байна.

Нийгмийн даатгалын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх санхүү болон хүний нөөц тэгш, хүртээмжтэй хуваарилагдаагүй байна.

1.72. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд үндсэн үйл ажиллагааг эрхэлж буй 21 аймаг, 9 дүүргийн НДГ-ын үйл ажиллагааны цар хүрээг Монгол Улсын хүн ам, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо хэмжээ, түүний тархалтын байдлыг авч үзэхэд дараах байдалтай байна.

1.73. Монгол Улсад 2023 оны жилийн эцсийн байдлаар 3.4 сая хүн ам, 225.9 аж ахуйн нэгж бүртгэлтэй байна. Үүнээс хөдөлмөрийн насны 1.8 сая иргэний 70.2 хувь нь нийгмийн даатгалд хамрагдаж, үйл ажиллагаа явуулж буй 94.2 мянган аж ахуйн нэгжийн 61.8 хувь нь НДШ төлсөн байна.

1.74. Улсын хэмжээнд нийгмийн даатгалын чиглэлээр үндсэн үйлчилгээ үзүүлж буй 21 аймаг, 9 дүүргийн НДГ-т 2023 оны жилийн эцсийн байдлаар нийтдээ 1240 албан хаагч ажиллаж, үйл ажиллагаандаа 35,757.9 сая төгрөг зарцуулан, 1,311.4 мянган даатгуулагч иргэн, 58.5 мянган шимтгэл төлөгч аж ахуйн нэгж байгууллагаас 4.2 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлж, 745.2 мянган иргэнд 4.0 их наяд төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгосон байна.

1.75. НДБ-ын нэг албан хаагчид ногдох үйл ажиллагааны зардал орон нутаг, нийслэлд ялгаагүй 28.0 сая төгрөг байгаа бол нэг албан хаагчид ногдох тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо орон нутагт 460, нийслэлд 898, НДШ төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын тоо орон нутагт 22, нийслэлд 99 байна.

1.76. Аймаг, дүүргийн НДГ-ын бүтэц орон тооны тархцыг тухайн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын харилцаанд орох талуудын тархацтай харьцуулан шинжилгээ хийхэд хүн амын 48.3 хувь, даатгалд хамрагдвал зохих хүн ам буюу хөдөлмөрийн насны хүн амын 48.1 хувь, шимтгэл төлбөл зохих аж ахуйн нэгж, байгууллага буюу үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 72.8 хувь, тэтгэвэр, тэтгэмж авагчдын 48.1 хувь нь нийслэлд хотод байршсан бол орон тооны 32.2 хувь, үйл ажиллагааны зардлын 32.3 хувь нь нийслэлийн 9 дүүргийн НДГ-т хуваарилагдсан байна.


Хүснэгт 8 : Монгол Улсын хүн ам, үйл ажиллагаа явуулж буй ААНБ, НДГ-ын албан хаагчдын байршсан байдал /хувь/

	Хүн ам	Хөдөлмөрийн насны хүн ам	Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ	Тэтгэвэр, тэтгэмж авагчид	НДГ-ын албан хаагчид, /2023 он/	Батлагдсан орон тоо, /2024 он/	Үйл ажиллагааны зардал, /2023 оны гүйцэтгэл/	Үйл ажиллагааны зардал, /2024 оны төсвийн хуваарь/
Орон нутаг	51.7	51.9	27.2	51.9	67.8	67.6	67.7	68.2
Нийслэл	48.3	48.1	72.8	48.1	32.2	32.4	32.3	31.8

Эх сурвалж: ҮСХ, ТЕГ, НДЕГ

1.77. НДЕХ хэрэгжиж эхэлснээс хойш буюу НДЕГ-ын даргын 2024 оны А/51, А/52 дугаар тушаалаар батлагдсан шинэ бүтэц орон тооны тархац болон үйл ажиллагааны зардлын төсвийн хуваарилалт нь дээрх 2023 оны байдлаарх тархацтай ялгаагүй байна. Шинээр батлагдсан орон тооны хувьд НДБ-ын нэг албан хаагчид ногдох хүн амын тоогоор нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол дүүргийн НДГ, аж ахуйн нэгж, байгууллагын тоогоор Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн НДГ-т илүү ачаалалтай ажиллахаар байна.

Дүрслэл 5: НДГ-ын нэг албан хаагчид ногдох хөдөлмөрийн насны хүн ам, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо /2024 он/



Монгол Улсад 2023 оны жилийн эцсийн байдлаар ЭМД-д хамрагдсан 3.2 сая хүн, ЭМД-аар тусламж, үйлчилгээ үзүүлж буй гэрээт 2350 эрүүл мэндийн байгууллага байна.

1.78. Улсын хэмжээнд ЭМД-ын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий эрүүл мэндийн даатгалын байгууллага болох 21 аймаг, 2 дүүргийн ЭМДХ болон ЭМДЕГ-т 199 албан хаагч

ажиллаж, үйл ажиллагаандаа орон нутагт 1,795.8 сая төгрөг, ЭМДЕГ 8,012.9 сая төгрөг зарцуулан, ЭМД-ын санд 222.5 мянган иргэнээс 29.1 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, гэрээт 2,350 ЭМБ-уудаар үйлчлүүлсэн 2.7 сая иргэний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд 1,8 их наяд төгрөг олгогдсон байна.

1.79. ЭМД-аар үзүүлж буй тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд хяналт тавих, хяналтын зохицуулалт хийх үүрэг бүхий аймаг, дүүргийн ЭМДХ, ЭМДЕГ-ын Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газрын 100 албан хаагчид 2023 онд Лавлагаа шатлалын тусламж үйлчилгээний 11.2 сая тохиолдлын нэхэмжлэл хүлээн авснаас 430 мянга гаруй тохиолдолд (3.8 хувь) нарийвчилсан хяналтыг гүйцэтгэсэн нь нэг албан хаагчид сард дунджаар 400 тохиолдол ногдож байна. ЭМДЕГ-ын даргын 2024 оны А/11 дүгээр тушаалаар батлагдсан дээрх чиг үүрэг бүхий 57 сул орон тоог нөхвөл нарийвчилсан хяналт хийх нэхэмжлэлийн тоог өсгөх боломж бүрдэхээр байна.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасгийн үйл ажиллагааны зардал нь төвлөрүүлсэн орлогын 35.2 хувийг эзэлж байна.

1.80. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хооронд 2006 оны 05 дугаар сарын 08-ны өдөр “Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр” байгуулж, 2007 оноос хэрэгжиж эхэлсэн байна.

1.81. БНСУ-ын Хууль зүйн яамны харьяа Гадаадын иргэн, харьяатын газраас 2023 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн байдлаар гаргасан статистик мэдээгээр БНСУ-д Монгол Улсын 51,595 иргэн оршин сууж байна.

1.82. Үүнээс хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн тоо 4186, байнгын оршин суугч 760, оршин суугч 1197, оюутан 7931, хэлний бэлтгэлд суралцагч 5874, солонгос иргэнтэй гэр бүл болсон 2023, гэр бүлийн визтэй 3917 түр хугацааны буюу аяллын визтэй иргэд 17817 байгаагаар тус тус бүртгэгдсэн байна.

1.83. Тус тасаг нь нийт 8 орон тоогоор ажиллаж, үйл ажиллагааны зардалд 2023 онд 1,026.1 сая төгрөг зарцуулж, нийгмийн даатгалын санд 2,918.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Энэ нь үйл ажиллагааны зардал орлогод эзлэх 35.2 хувь байгаа нь тус тасгийн үр ашиг бага байгааг харуулж байна.

Нийгмийн даатгалын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн систем нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна

1.84. Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн гэрээний¹³ санхүүжилттэй хэрэгжүүлж байгаа “Хүнс тэжээл, нийгмийн хамгааллын төсөл”-ийн хүрээнд ХНХЯ, НДЕГ “Ай Ти Зон” ХХК-тай “Нийгмийн даатгалын мэдээллийн системийг хөгжүүлж, нэвтрүүлэх” ажлын гэрээг 2019 оны 7 дугаар сарын 30-ны өдөр нийт 979,728.8 ам.доллараар гүйцэтгэхээр байгуулсан байна. Уг ажлыг 2 жилийн хугацаанд хөгжүүлж, зүгшрүүлэхээр гэрээнд заасан ч одоог хүртэл бүрэн дуусаагүй байна.

¹³ Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд 2014 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан “Хүнс, тэжээл, нийгмийн халамжийн төсөл: Нэмэлт санхүүжилт” нэртэй 2019-2038 он хүртэл эргэн төлөгдөх нөхцөлтэй 12,960,000 мянган ам.долларын зээлийг **нийгмийн даатгалын мэдээллийн технологийг бэхжүүлэх замаар нийгмийн даатгалын үйлчилгээг үр ашигтай, ил тод байдлаар хүргэхэд зорилготой** гэрээг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийг дуустал байгуулсан. Тус төслийг хэрэгжүүлэх нэгжийг Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн 180 дугаар тушаалаар байгуулсан байна.


1.85. Гэтэл гэрээнд заасан ажлуудыг бүрэн дуусаагүй байхад холбогдох талууд ажлыг гүйцэтгэсэн талаарх акт үйлдэн баталгаажуулж 2020 онд гүйцэтгэгчид санхүүжилтийн 95 хувийг шилжүүлсэн байна. Улмаар НДЕГ-ын даргын 2023 оны А/193 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын мэдээллийн системийн хөгжүүлэлт дуусаж, шинэ программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбоотой аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад зөвлөгөө мэдээлэл өгөх үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулж бүрэн дуусаагүй системийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлсэн байна.

1.86. Бүрэн дуусаагүй системийг хэрэглээнд нэвтрүүлсэн нь иргэн, ААНБ-дад хүндрэл учруулсан байна. Системд гарч буй хүндрэл, бэрхшээлийг засах арга хэмжээг гүйцэтгэгчтэй хамтран ажиллаж байна. Системийг бүрэн ашиглалтад оруулах талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

1.87. Аудитын явцад сарын хугацаанд цахим хэлбэрээр нийгмийн даатгалын талаар санал асуулга авахад нийт 9,423 иргэн, 28,971 ААНБ хамрагдсан. Мөн орон нутаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын нийт 303 албан хаагчаас санал асуулга авсан. Санал асуулгын дүнг харуулбал:

Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагч нараас авсан санал асуулга


Санал асуулга: Шинээр нэвтрүүлсэн нийгмийн даатгалын програм хангамж нь таны ажлыг хөнгөвчилж чадаж байна уу ?



Санал асуулгад оролцогчдын 75 хувь нь систем ажлыг хөнгөвчилж чадахгүй байгаа гэж хариулсан байна.

“Ажлыг хөнгөвчилж чадахгүй байгаа” гэж хариулсан 75% буюу 227 албан хаагчид дараах шалтгаанаар программ нь ажлыг хөнгөвчилж чадахгүй байна гэж үзсэн байна.

Дүрслэл 6: Ажил хөнгөвчлөхгүй байгаа шалтгаан



Бусад гэж өгсөн саналд сумдын нийгмийн даатгалын байцаагч нар системийг ашиглах эрхгүй байгаа нь ажлыг хөнгөвчилж чадахгүй байгаа талаар дурдсан байна.

Иргэн, ААНБ-аас авсан санал асуулга

Санал асуулга: Нийгмийн даатгалын цахим систем ашиглахад хүндрэлтэй байдаг уу?


Дүрслэл 7: НД-ын цахим систем ашиглахад гарч буй асуудал /ААНБ, иргэн/



1.88. Дээрх санал асуулгын дүнгээс харахад нийгмийн даатгалын цахим систем нь ААНБ-д илүү хүндрэлтэй байна.

1.89. Иргэдийн дийлэнх хувь нь систем ашиглахад хүндрэл гардаггүй гэж хариулсан дараах шалтгаантай байна.


Дүрслэл 8: Иргэдийн ашиглаж байгаа цахим систем



Иргэд нийгмийн даатгалын системээс бусад системийг илүү ашигладаг байна.

1.90. НДБ-аар үйлчлүүлсэн иргэдийг ангилан харуулбал:

Дүрслэл 9: Нийгмийн даатгалын байгууллагаас үйлчилгээ авсан иргэдийн тоо, 2020-2023




Эх сурвалж: НДЕГ

1.91. Дээрх үзүүлэлтээс харахад нийт үйлчлүүлэгчдийн дийлэнх нь НДБ-д биеэр ирж үйлчлүүлж байна.

1.92. Иргэд, даатгуулагч, харилцагчдад лавлагаа, мэдээлэл өгөх зориулалттай Call Pro үйлчилгээг 2024 оны 06 дугаар сараас эхлэн 21 аймаг, 9 дүүрэгт нэвтрүүлсэн байна. Уг үйлчилгээний талаар НДБ-ын албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авахад дараах үр дүн гарч байна.


Санал асуулга: Call Pro үйлчилгээг нэвтрүүлсэн нь таны ажлыг хөнгөвчилж иргэдэд үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай болгож чадсан уу?

Дүрслэл 10: Call Pro үйлчилгээний талаарх албан хаагчдын сэтгэгдэл



Ажил хөнгөвчлөхгүй байгаа шалтгааныг дараах байдлаар тайлбарласан байна.

Дүрслэл 11: Ажил хөнгөвчлөхгүй байгаа шалтгаан



1.93. НДЕГ болон ЭМДЕГ-ын мэдээллийн системийн өгөгдөлд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна.

Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн систем

ЭМД-ийн мэдээллийн системээс 2024 оны 1 – 9 сарын өгөгдлийг авч дүн шинжилгээ хийхэд нийт 11 төрлийн шимтгэлийг давтагдахгүй тоогоор 3,122,575 иргэн төлсөн байгаа бөгөөд хүүхэд гэсэн төрлөөр хамгийн их буюу 1,267,362 иргэн, цалин гэсэн төрлөөр 802,644 иргэн, тэтгэвэр гэсэн төрлөөр 550,387 иргэн, амьжиргааны түвшин доогуур гэсэн төрлөөр 438,131 иргэн байна.

Нийт ЭМДС-аас 1,409,109,292,742.0 төгрөгийн 19,431,658 үйлчилгээг давтагдсан тоогоор авсан байна. Нийт 39 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Даатгуулагчийн авсан үйлчилгээнд дараах асуудал гарч байна. Тухайлбал:

- Хамгийн өндөр үнийн дүнтэй буюу 6,666,724,920.0 төгрөгийн 3 үйлчилгээг авсан нэг иргэн байна. Энэ нь цахим жороор олгосон хөнгөлөлттэй эмийн дүнг алдаатай нэхэмжилсэнтэй холбоотой байна. Уг дүнг нэхэмжлэхийн хяналтаар 10,500 төгрөгөөр олгохоор тооцсон байна.

- Регистрийн дугаар бүртгүүлээгүй иргэдэд 37,439 удаагийн үйлчилгээнд 1,917,100,283 төгрөг нэхэмжилснээс 1,891,440,551 төгрөг олгохоор тооцсон байна. Уг асуудлыг ЭМДЕГ “Нийслэлийн түргэн тусламжийн төв дээр алсын болон ойрын дуудлагаар үйлчилгээ авсан иргэдийг AA00000000 регистрийн дугаар дээр бүртгэдэг” гэж тайлбарласан.
- Регистрийн дугааргүй хоосон утга нь дээр 675,000.0 төгрөгийн 943 үйлчилгээг авсан гэж бүртгэсэн ба 883 тусламж үйлчилгээ нь “нэг иргэний” эмнэлгийн үзлэг бөгөөд гүйцэтгэл боддоггүй тусламж үйлчилгээ, үлдсэн 60 нь ямар төрлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэдэг нь тодорхойгүй байна.

ЭМДС-аас үзүүлж буй үйлчилгээнээс нэг иргэн хэдэн төрлийн үйлчилгээнд хамрагдсаныг шинжлэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 9 : Нэг иргэний авсан үйлчилгээний тоо

Үйлчилгээний тоо	Иргэдийн тоо
63	1
57	1
55	2
54	5
.....
3	299,558
2	414,733
1	582,608
Нийт	2,506,408

ЭМДС-аас үзүүлж байгаа 39 нэр төрлийн үйлчилгээнээс нэг иргэн хамгийн ихдээ 63 удаа үйлчилгээ авсан байна.

Дээрх байдлаас харахад эрүүл мэндийн даатгалын мэдээллийн систем нь бусад байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд шүүлтүүр хийдэггүйгээс алдаатай мэдээлэл бүртгэдэг байна. Мөн залилан гарах эрсдэлээс сэргийлж чадахгүй байна.

Иймд ЭМД-ийн мэдээллийн системд байгаа дээрх өгөгдлүүдэд дотоод аудит хийж, хариу мэдэгдэх албан шаардлагыг ЭМЯ-д өгөхөөр шийдвэрлэв.

Эх сурвалж: ЭМДЕГ

Нийгмийн даатгалын мэдээллийн систем

НД-ийн мэдээллийн системээс 2019-2023, 2024 оны эхний хагас жилийн байдлаар өгөгдөл авч дүн шинжилгээ хийхэд 1,518,298 иргэн байгаа бөгөөд ажил олгогчоос 9,069.0 тэрбум төгрөг, даатгуулагчаас 7,709.3 тэрбум төгрөг, нийт 16,778.4 тэрбум төгрөгийн шимтгэл төлсөн байна. Харин НДЕГ-аас нийт шимтгэлийн дүнг 16,784.6 тэрбум төгрөг гэж зөрүүтэй мэдээлэл ирүүлсэн байна. Даатгуулагчийн НДШ төлөлтийн мэдээлэлд дараах асуудал гарч байна. Тухайлбал:

- Хамгийн өндөр буюу 3,913,068,652.8 төгрөгийн шимтгэл төлсөн нэг иргэн байна. Гэвч тус иргэний мэдээлэл НДЕГ-аас ирүүлсэн өгөгдөл мэдээлэлд 4,126,187,435.2 төгрөгөөр бүртгэгдсэн байна.
- Дараагийн өндөр төлөлттэй иргэн нь гадаадын иргэн байгаа бөгөөд 2,350,128,080.6 төгрөгийн шимтгэл төлсөн байна. Гэвч тус иргэний мэдээлэл НДЕГ-аас ирүүлсэн өгөгдөл мэдээлэлд 2,552,827,052.1 төгрөгөөр бүртгэгдсэн байна.
- 500 сая төгрөгөөс дээш шимтгэл төлсөн 107 иргэн байгаагаас 61 иргэн нь гадаадын иргэн, 46 нь Монгол Улсын иргэн байна. Монгол Улсын иргэдийн төрсөн оныг авч үзэхэд 1956-1988 оныг хамаарч байна.
- Албан журмаар шимтгэл төлж байгаа тохиолдолд даатгуулагч ажил олгогчоос өндөр шимтгэл төлсөн 5 иргэн байна.

Хүснэгт 10: НДС-аас тэтгэвэр, тэтгэмжийг хамт авдаг иргэдийн мэдээлэл

	Тэтгэвэр/ Тэтгэмж/ Ажилгүйдэл	Тэтгэвэр/ Тэтгэмж / ҮОМШӨ	Тэтгэвэр/ Ажилгүйдэл/ ҮОМШӨ
2019	100	101	0
2020	99	77	1
2021	131	51	0
2022	145	82	1
2023	156	76	1
2024.06	14	34	
Нийт	645	421	3

- 2024 оны эхний хагас жилийн байдлаар тэтгэвэр авдаг иргэн НДС-аас үргэлжлүүлэн төлдөг ч ЭМДС-д шимтгэл төлдөггүй 294 иргэн байна.
- НДС-аас 2019 оноос 2024 оны эхний хагас жилийн хугацаанд нэг иргэн хамгийн ихдээ 159,841,165.0 төгрөг авсан байна.

1.94. Дээрх мэдээллүүдээс харахад НДС-аас зарим иргэд харьцангуй өндөр дүнтэй болон олон удаагийн үйлчилгээ авсан байна. Мөн зарим иргэд хэт өндөр НДС төлсөн (ажил олгогчийн төлөх шимтгэл багтсан) байна.

БҮЛЭГ 2. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс даатгуулагчийн ирээдүйд учрах эрсдэлийг бууруулах боломжгүй нөхцөл байдалд хүрсэн байна

НДС-ийн хөрөнгийг үр ашигтай, зохистой удирдаагүй байна

2.1. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлд нийгмийн даатгалын төрөл тус бүр бие даасан сантай, сан нь банканд данстай байхаар заасан байна.

2.2. Нийгмийн даатгалын сангийн орлого нь ажил олгогчийн, даатгуулагчийн төлсөн шимтгэл, сангийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулсны хүү, нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд ногдуулсан алданги, улсын төсвөөс олгосон хөрөнгө болон бусад эх үүсвэрээс бүрддэг бөгөөд дараах байдлаар орлого төвлөрүүлж зарцуулсан байна.

Хүснэгт 11 : Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлага /тэрбум төгрөг/

Нийгмийн даатгалын сангийн төрөл	2019	2020	2021	2022	2023
Нийт орлого	2,954.6	2,355.5	3,720.0	4,737.2	5,880.3
Тэтгэвэр	2,071.1	1,595.4	2,360.7	3,013.2	3,620.2
Тэтгэмж	157.5	111.4	180.1	236.9	306.0
ҮОМШӨ	214.8	145.5	129.2	208.8	282.7
Ажилгүйдэл	41.5	25.9	61.9	53.6	62.7
Эрүүл мэнд	469.6	477.4	1,069.4	1,514.4	1,583.8
Нийт зарлага	2,413.2	2,878.2	3,773.7	4,897.0	5,639.0
Тэтгэвэр	1,839.2	2,174.9	2,300.6	3,119.6	3,653.5
Тэтгэмж	126.2	147.7	172.8	175.1	217.5
ҮОМШӨ	52.9	34.2	34.4	40.7	54.1
Ажилгүйдэл	44.0	94.9	57.8	80.3	111.0
Эрүүл мэнд	351.0	426.4	1,542.5	1,572.6	1,785.4

Эх сурвалж: НДЕГ, ЭМДЕГ

2.3. Дээрх үзүүлэлтээс харахад нийгмийн даатгалын сангийн 2020 - 2022 оны зарлага орлогоос хэтэрсэн байна.

2.4. Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлагын зөрүүг авч үзвэл:

Хүснэгт 12: Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлагын зөрүү /тэрбум төгрөг/


Нийгмийн даатгалын сангийн төрөл	2019	2020	2021	2022	2023
Нийт зөрүү	541.40	-522.70	-53.70	-159.80	241.3
Тэтгэвэр	231.90	-579.50	60.10	-106.40	-33.3
Тэтгэмж	31.30	-36.30	7.30	61.80	88.5
ҮОМШӨ	161.90	111.30	94.80	168.10	228.6
Ажилгүйдэл	-2.50	-69.00	4.10	-26.70	-48.3
Эрүүл мэнд	118.60	51.00	-473.1	-58.2	-201.6

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.5. Энэ үзүүлэлтээс харахад сүүлийн 2 жилд “тэтгэмж, ҮОМШӨ”-өөс бусад сангийн зарлага орлогоос хэтэрсэн байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайд сүүлийн 3 жил зарлага орлогоос хэтэрсэн байна. (Тайлангийн төгсгөлд сан тус бүрээр тайлбарлав)

2.6. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагад сан тус бүрийн эзлэх хувийг харуулбал:

Дүрслэл 12: НДС-ийн орлогод эзлэх хувь



Дүрслэл 13: НДС-ийн зарлагад эзлэх хувь



2.7. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагад тэтгэврийн даатгалын сан ихэнх хувийг эзэлж байна.

2.8. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/183 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ыг баталсан байна. Энэ журмын 3.1-д “Аймаг, дүүргийн НДГ нь НДС-ийн төвлөрсөн орлогын харилцах дансанд ажил олгогч, даатгуулагчийн төлсөн НДШ, шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэн, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг бууруулсан болон нуусан орлогод тооцсон алданги, торгуулийн орлогыг НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд төвлөрүүлнэ” гэж заасан байна.


2.9. Уг төвлөрсөн орлогыг нийгмийн даатгалын холбогдох дансанд хуваарилах, сан тус бүрийн харилцах дансанд шилжүүлэх, олгох гүйлгээг НДЕГ-т дараах албан хаагчид хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- Төв сан хариуцсан мэргэжилтэн -1
- Санхүү, бүртгэл хөрөнгө оруулалтын газрын дарга -1
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга -1

Дээрх 3 албан хаагч нийгмийн даатгалын төв сангийн орлого, зарлагын гүйлгээг хариуцан гүйцэтгэдэг ба энэ үйл явцад байгууллагын Дотоод аудит, мониторингийн газар мөн НДҮЗ-ийн ажлын албанаас хяналт тавьдаггүй байна. Энэ нь залилан үүсэх эрсдэлийг дагуулж байна.

2.10. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Агентлагийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан ч нийгмийн даатгалын салбарын байгууллагуудын үйл ажиллагааны зардалд 2023 оны 12 дугаар сар хүртэл дараах байдлаар сангийн хөрөнгөнөөс зарцуулсан байна.

Дүрслэл 14: Үйл ажиллагааны зардалд зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/



Эх сурвалж: НДЕГ

2.11. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Нийгмийн даатгал нь албан журмаар болон сайн дураар даатгуулах гэсэн хэлбэртэй байна” гэж заасан бөгөөд албан журмаар болон сайн дураар даатгуулагч иргэдийн тоог харьцуулан харуулбал:

Дүрслэл 15: Даатгуулагчдын тоо



Эх сурвалж: НДЕГ

2.12. НДТХ-ийн /хуучин нэрээр/ 32 дугаар зүйлийн 32.1.2-т заасан “Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс”-д НДШ ногдуулахаар заасан байна.

2.13. Энэ заалтыг НДЕХ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2.-т “Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс” гэж тусгасан нь иргэд, олон нийтийн дунд шинээр тусгасан заалт мэтээр ойлгон шүүмжлэлтэй хандаж, маргаан дагуулсан байна. Уг заалтыг хүчингүй

болгуулахаар одоогийн байдлаар нийт 13,881 хүний гарын үсгийг цуглуулсан байна. Аудитын явцад ААН-ээс авсан санал асуулгад нийт 156 ААН дээрх хуулийн заалтыг болиулах, дарамт болдог талаар санал ирүүлсэн.

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн удирдлага

2.14. Нийгмийн даатгалын хуримтлалын сангийн хөрөнгийг Нийгмийн даатгалын тухай хууль (хуучин нэрээр) 11 дүгээр зүйлийн 11.3-т "Засгийн газрын бонд, Монгол банкнаас гаргасан үнэт цаас худалдаж авах, Арилжааны банканд байршуулах замаар хөрөнгийг нэмэгдүүлж болно" гэснийг шинэчлэн баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 -д "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно" гэж тусгагдсан байна. Үүнд:

- Засгийн газрын үнэт цаас,
- Монгол банкны үнэт цаас,
- Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж,
- Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламж

Мөнгөн хадгаламж

2.15. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс арилжааны банканд чөлөөт үлдэгдлийг байршуулахтай холбоотойгоор 2009, 2013, 2018, 2024 онуудад "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам" баталсан байна.

2.16. Эдгээр журамд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл хуримтлалын сангаас арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тусгасан байна.

Хүснэгт 13: Арилжааны банканд мөнгөн хадгаламж байршуулах шалгуур үзүүлэлт

Журам	Мөнгөн хадгаламж байршуулахад харгалзах үзүүлэлт		
2009 оны 17 дугаар тогтоол	3.2.1 Хадгаламжийн хүүгийн хувь хэмжээ нь тухайн үеийн Засгийн газрын бондын хүү, Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү болон арилжааны банк хоорондын захын хүүгийн дундаж хувь хэмжээнээс доошгүй байх	3.2.2 Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангаар үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол хангасан	3.2.3 Мөнгөн хадгаламжийн үлдэгдлийн дээд хэмжээ нь тухайн арилжааны банкны нийт активын 10 хувиас хэтрэхгүй байх
2013 оны 35 дугаар тогтоол	3.2.1. Хадгаламжийн хүүгийн хувь хэмжээ нь тухайн үеийн Засгийн газрын бондын хүү, Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү болон арилжааны банк хоорондын захын хүүгийн дундаж хувь хэмжээнээс доошгүй байх	3.2.2.Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангаар үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол хангасан байх	3.2.3.Мөнгөн хадгаламжийн үлдэгдлийн дээд хэмжээ нь тухайн арилжааны банкны нийт активын 20%-с хэтрэхгүй байх
2014 оны нэмэлт өөрчлөлт	2014 оны 11 сарын 24-ний өдрийн 29 дүгээр тогтоол 2013 оны журам 4.5-д "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл хуримтлалын сангаас арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах		
	2014 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 22 дугаар тогтоол 2013 оны журам 3.2.3 дах заалтыг "Мөнгөн хадгаламжийн үлдэгдлийн дээд хэмжээ нь мөнгөн хадгаламж		

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

	хөрөнгийн хүүгийн хэмжээг тухайн үеийн Монгол банкны бодлогын хүүгийн түвшинтэй уялдуулан тогтоох" гэсэн заалтыг нэмсүгэй.		байршуулах үеийн тухайн улирлын арилжааны банкны нийт активын 25 хувиас хэтрэхгүй байх" гэж өөрчилсүгэй.		
2018 оны 08 дугаар тогтоол	3.1. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн хүүгийн доод хэмжээг тухайн үеийн Монгол банкны бодлогын хүү , банкуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүгийн дундаж хэмжээтэй уялдуулан Засгийн газрын бондын хүү, Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү болон арилжааны банк хоорондын захын хүүгийн дундаж хэмжээнээс доошгүй байхаар НДЕГ-ын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.		3.3.1.Сүүлийн нэг жил санхүүгийн тайлангаар Монгол банкнаас тогтоосон “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол хангасан байх.		Мөнгөн хадгаламжийн хэмжээ нь тухайн банкны нийт активын 15 хувиас хэтрэхгүй байх.
2024 оны 254 дүгээр тогтоол	6.4.2.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоосон мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээнээс багагүй хүүг санал болгосон байх;	6.4.1.сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлангаар Монгол банкнаас тогтоосон "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-д заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх	6.4.3.Монгол банкнаас " банкны системд нөлөө бүхий банк " гэдгийг тогтоосон шийдвэр байх. НДЕХ-н 13.1.4-т заасан мөнгөн хадгаламжийн хэмжээ нь тухайн банкны өөрийн хөрөнгийн 15 хувиас ихгүй байна.		

Эх сурвалж: НДҮЗ-ийн тогтоол

2.17. Журмын өөрчлөлтөөс харахад мөнгөн хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ тухайн банкны нийт активын 20%-с хэтрэхгүй байсныг 25% болгож өсгөсөн байна. Энэ нь нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг өөрийн хөрөнгө багатай банкнуудад их хэмжээгээр байршуулах боломжийг бүрдүүлсэн байна.

2.18. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн харгалзаж үзээгүйгээс Капитал, Чингис хаан зэрэг банкнуудад хадгаламж байршуулж, сангийн хөрөнгийг алдахад хүргэсэн байна. Капитал, Чингис хаан банкнуудад 2012-2019 онд байршуулсан хадгаламж тус бүрээр шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг тулган үзэхэд 2012-2015 онд банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн харгалзаж үзээгүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс харна уу)

2.19. Зарим мөнгөн хадгаламжийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлттэй холбоотой баримт материал НДЕГ-ын архивд байхгүй байна

Капитал банк	Капитал банк нь 2024 оны 10 дугаар сарын байдлаар НДС-д 67.2 тэрбум, ЭМДС-д 77.4 тэрбум нийт 144.6 тэрбум төгрөгийг төлөх үлдэгдэлтэй байна.
---------------------	---

2.20. Монгол банкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А/96 дугаар тушаалаар "Капитал банк"-ийг албадан татан буулгахаар шийдвэрлэж, мөн өдрийн А/97

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

дугаар тушаалаар банкны эрх хүлээн авагч томилогдсон бөгөөд дампуурах үед НДС-д 104.2 тэрбум, ЭМДС-д 136.1 тэрбум, нийт 240.3 тэрбум төгрөг эрсдэлд орсон байна. Үүнд:

Хүснэгт 14: Капитал банкныг татан буулгах үеийн НДС-н хөрөнгө /тэрбум төгрөг/

Сангийн нэр	Тэтгэврийн даатгалын сан	Тэтгэмжийн даатгалын сан	ҮОМШӨ-ний даатгалын сан	ЭМД-ын даатгалын сан	Ажилгүйдлийн даатгалын сан	Нийт дүн
НДЕГ	1.4	2.2	62.0	0.2	38.5	104.2
ЭМДЕГ				136.1		136.1
Нийт дүн	1.4	2.2	62.0	136.3	38.5	240.3

Эх сурвалж: НДЕГ, ЭМДЕГ

Нийгмийн даатгалын санд хамаарах асуудал:

2.21. НДС-аас 2007-2019 онд Капитал банканд дараах байдлаар мөнгөн хөрөнгө байршуулсан байна.

Хүснэгт 15: НДС-ийн Капитал банк дахь мөнгөн хөрөнгө, 2007-2019, /төгрөг/

№	Он	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	Үүнээс	
			Хадгаламж	Харилцах
1	2007	5,227,586,299.45	5,000,000,000.00	227,586,299.45
2	2008	14,758,790,737.65	14,000,000,000.00	758,790,737.65
3	2009	17,848,663,605.31	10,000,000,000.00	7,848,663,605.31
4	2010	16,176,733,048.07	10,000,000,000.00	6,176,733,048.07
5	2011	24,738,550,831.54	10,000,000,000.00	14,738,550,831.54
6	2012	31,409,763,882.03	26,000,000,000.00	5,409,763,882.03
7	2013	126,353,197,375.40	105,000,000,000.00	21,353,197,375.40
8	2014	209,487,284,256.75	190,000,000,000.00	19,487,284,256.75
9	2015	238,061,977,090.05	185,000,000,000.00	53,061,977,090.05
10	2016	224,114,557,745.06	180,000,000,000.00	44,114,557,745.06
11	2017	228,174,467,579.16	20,000,000,000.00	208,174,467,579.16
12	2018	105,303,585,814.82	2,400,000,000.00	102,903,585,814.82
13	2019.03.31	105,090,492,323.73	287,390,000.00	104,803,102,323.73
Нэхэмжилсэн дүн		104,206,699,902.46		

Эх сурвалж: НДЕГ

2.22. “Капитал банк”-ны эрх хүлээн авагчаас 2019 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А/69 дүгээр тушаалаар НДЕГ-ын нэхэмжлэлийн шаардлагыг Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.8 дахь хэсэгт зааснаар “Засгийн газарт төлөх төлбөр, албан татвар”-т хамруулсан байна.

2.23. Дээрх шийдвэрийг үндэслэн НДЕГ-аас 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 1/2181 дугаартай албан бичгээр Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд “Капитал банк”-ны эрх хүлээн авагчийн 2019 оны А/69 дүгээр тушаалын Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамааралтай заалтыг хүчингүй болгож Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.5 дахь хэсэгт зааснаар “Даатгагдаагүй хадгаламжийн төлбөрт” хамааруулан бүртгэхийг хүссэн нэхэмжлэл гаргасан байна.

2.24. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 128/ШШ2020/0181 дугаартай шийдвэрээр 104.206.699.902.46 төгрөгийн хадгаламжийг Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.5-д заасан “Даатгагдаагүй хадгаламжийн төлбөр”-т хамруулан бүртгэхийг хариуцагч “Капитал банк” ХХК дахь банкны эрх хүлээн авагчид даалгасан байна.

2.25. НДЕГ-аас 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 1/972 дугаартай албан бичгээр Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэлийн шаардлага нэмэгдүүлэх тухай албан бичгээр Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлд заасан дарааллыг үл харгалзан, тэргүүн ээлжид төлөх үүргийг Капитал банкны эрх хүлээн авагчид даалгаж, Иргэний хуулийн 216 дугаар зүйлийн 216.2 дахь хэсэгт зааснаар “үүрэг гүйцэтгэх дараалал”-ыг шүүхийн журмаар тогтоолгохыг хүссэн байна.

2.26. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 182/ШШ2020/02419 дугаартай Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4-т “Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн тохиолдолд зохигч давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй” гэж захирамжилсан байна.

2.27. НДҮЗ-ийн 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 35 дугаар тогтоолоор “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангаас арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам”-ыг баталж, журмын 4.3-т “НДЕГ нь энэхүү журмын хавсралтаар батлагдсан Мөнгөн хадгаламжийн гэрээний дагуу хадгаламжийн дүн, хугацаа, хүү тооцох аргачлал, талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээг цуцлах нөхцөл зэргийг тусгасан банк тус бүртэй байгуулах мөнгөн хадгаламжийн гэрээний төслийг **Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргад танилцуулж, зөвшөөрөл авсны үндсэн дээр гэрээ байгуулна**” гэж заасан байна.

2.28. Гэвч НДЕГ-ын Капитал банканд байршуулсан мөнгөн хадгаламжийн гэрээний жагсаалтад 2013, 2015, 2016 онуудын НДҮЗ-ийн даргаас НДЕГ-т гэрээ байгуулах эрх олгох зөвшөөрлийн баримт бичиг нь НДЕГ-ын архив болон НДҮЗ-ийн ажлын албанд байхгүй байна.

2.29. Энэ асуудлыг одоогийн байдлаар хууль, хяналтын байгууллага шалгаж байгаа тул аудитын баг уг асуудалд хязгаарлалт хийлээ.

Хүснэгт 16: Капитал банкны НДС-д төлж барагдуулах хөрөнгийн үлдэгдэл /төгрөг/

Огноо	Эхний үлдэгдэл	Барагдуулсан		Эцсийн үлдэгдэл
		Мөнгөн хөрөнгөөр	Хөрөнгөөр	
2019.04.09	104,206,699,902.46	-	-	104,206,699,902.46
2020 он	104,206,699,902.46	826,698,702.46	-	103,380,001,200.00
2021 он	103,380,001,200.00	7,223,399,404.35	22,156,602,695.65	73,999,999,100.00
2022 он	73,999,999,100.00	1,744,823,850.05	2,905,176,149.95	69,349,999,100.00
2023 он	69,349,999,100.00	1,183,043,963.95	- 33,044,863.95	68,200,000,000.00
2024.10	68,200,000,000.00	999,997,600.00	-	67,200,002,400.00

Эх сурвалж: НДЕГ

2.30. Одоогийн байдлаар Капитал банкны үлдэгдэл **67.2** тэрбум төгрөгөөс ҮОМШӨ-ний даатгалын сангийн 62.0 тэрбум, ажилгүйдлийн даатгалын сангийн 5.2 тэрбум төгрөг байна.

2.31. НДЕГ нь Капитал банк дахь банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн **104.2** тэрбум төгрөгөөс 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 11.88 тэрбум төгрөг нь мөнгөн хэлбэрээр, 25.02 тэрбум төгрөгийн 78 ширхэг үл хөдлөх хөрөнгө хүлээн авснаар 36.89 тэрбум төгрөгийн төлбөр барагдсан байна.

Хүснэгт 17: НДС-ийн нэхэмжилсэн төлбөрт хүлээн авсан хөрөнгө /сая төгрөг/

Хөрөнгийн төрөл	Тоо	Мөнгөн дүн
Газар, гаражтай газар	10	1,932.8
Орон сууц	28	5,220.4
Зоорь агуулах, үнээний зориулалттай ферм	14	580.0

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

Хувийн сууц, газар	4	75.4
Үйлдвэр, үйлчилгээ, оффисын зориулалттай хөрөнгө	10	11,977.3
Орон сууцнаас бусад /орон нутагт/	12	5,242.8
Нийт дүн	78	25,028.7

Эх сурвалж: НДЕГ

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл сангийн авлагад авсан хөрөнгийг худалдан борлуулах журмаар салбарын албан хаагчдад давуу байдал олгосон байна

2.32. ТӨБЗГ-ын 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 06 дугаар хуралдааны тэмдэглэлд “Хүлээн авсан хөрөнгийг Нийгмийн даатгалын сангийн эргэлтийн хөрөнгийн борлуулах зориулалттай үндсэн хөрөнгө дансанд бүртгэж, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдан борлуулж, орлогыг Нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх нь зүйтэй” гэжээ.

2.33. МУЗГ-ын 2022 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлд Капитал банкнаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын сангийн нэхэмжилсэн өр төлбөрт банкны эрх хүлээн авагчаас санал болгож буй хөрөнгийг тооцож шилжүүлэн авах, шилжүүлэн авсан хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулж холбогдох санд төвлөрүүлэх арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай зохион байгуулж ажиллахыг ХНХС, ЭМС, ХЗДХС, СаС нарт даалгасан байна.

2.34. Гэтэл НДҮЗ-ийн 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар тогтоолоор баталсан Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журмын 6.37-д “**НДЕГ нь нийгмийн даатгалын сангийн авлагад тооцон авсан орон сууцыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын албан хаагчид болон иргэн, хуулийн этгээдэд банкны зээлээр болон бэлэн мөнгөөр худалдан борлуулах ажлыг зохион байгуулж болно. Энэ тохиолдолд дуудлага худалдаа зохион байгуулахгүйгээр шийдвэрлэнэ**”¹⁴ гэж заасныг үндэслэн НДЕГ-ын 6 албан хаагч гэрээ байгуулан орон сууц худалдаж авсан байна.

2.35. Дээрх тогтоол нь салбарынхаа албан хаагчид болон мэдээлэлд ойр албан тушаалтнуудад давуу байдал олгосон, хуулиас давсан шийдвэр бөгөөд сангийн хөрөнгийг арвижуулах боломжийг алдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 5 дугаар зүйл болон тус хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдахад Засгийн газрын, төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын, бусад эд хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн шийдвэрээр гагцхүү дуудлага худалдаагаар худалдаж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

2.36. Банкны эрх хүлээн авагчаас хүлээн авсан 78 хөрөнгөөс 13.6 тэрбум төгрөгийн 18 ширхэг хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

Хүснэгт 18: Борлуулагдаагүй үлдсэн хөрөнгө /сая төгрөг/

Д/д	Төрөл	Хүлээн авсан хөрөнгө		Борлуулсан хөрөнгийн мэдээлэл			Үлдэгдэл хөрөнгө	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	КБЭХ авагчийн үнэ	Борлуулсан үнэ	Тоо	Мөнгөн дүн
1	Газар, авто зогсоол	10	1,932.78	9	1,921.50	1,982.80	1	11.28

¹⁴ НДҮЗ-ийн 2023 оны 07 дугаар сарын 5-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор тус журмын 6.37 дахь хэсгийг “НДЕГ нь нийгмийн даатгалын сангийн авлагад тооцон авсан орон сууцыг иргэн, хуулийн этгээдэд банкны зээлээр болон бэлэн мөнгөөр худалдан борлуулах ажлыг зохион байгуулж болно” гэж өөрчлөн найруулсан байна.

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

2	Орон сууц	28	5,220.40	26	4,942.01	5,070.65	2	278.40
3	Зоорь, агуулах, үнээний ферм зориулалттай	14	580.00	14	580.00	640.00	0	-
4	Хувийн сууц, газар	4	75.40		-		4	75.40
5	Үйлдвэр, үйлчилгээ, оффисын зориулалттай хөрөнгө	10	11,977.35	1	243.53	255.41	9	11,733.82
6	Орон сууцнаас бусад хөрөнгө	12	5,242.80	10	3,720.11	3,830.50	2	1,522.69
Нийт дүн		78	25,028.73	60	11,407.15	11,779.36	18	13,621.59

Эх сурвалж: НДЕГ

2.37. Худалдан борлуулсан болон түрээсэлсэн хөрөнгөөс түүвэрлэн үзэхэд дараах байдалтай байна.

- Булган аймаг, Булган сум, 5-р баг, Төв эмийн сангийн байр, 2 давхар 618 м.кв барилгыг “Булган эм хангамж” ХХК түрээсэлж байгаа ба тус компанийн хувьцаа эзэмшигч “Монгол Эм Импекс Концерн” ХХК байна. Түрээсийн гэрээг 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр байгуулж, 1 сарын төлбөрийг 3,708,000.00 төгрөг байхаар тохиролцсон ч, 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр гэрээний үнийн дүнд өөрчлөлт оруулж 1 сарын төлбөрийг 1,380,000.00 төгрөг болгосон байна.
- Дуудлага худалдаагаар борлуулсан гэх Дорнод аймаг, Хэрлэн сум, 7-р баг, Гаалийн газрын баруун талд байрлах барилгыг “Монгол Эм Импекс Концерн” ХХК дуудлага худалдаа нээсэн үнээс 1.0 сая төгрөгөөр илүү үнээр худалдаж авсан ба дуудлага худалдаа хууль журмын дагуу болсон гэдэг нь нотлох баримтаар дэмжигдэхгүй байна.
- "Энхтайван найрамдлын ордон"-ыг 2022 онд "Монгол оркестр" ХХК-д түрээслүүлсэн ч НДЕГ-т 99.7 сая, ЭМДЕГ-т 136.6 сая нийт 236.3 сая төгрөгийн түрээсийн төлбөрийн авлагыг барагдуулаагүй байна. Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 182/ШШ2024/01068 дугаартай шүүхийн шийдвэрийн дагуу эрэн сурвалжлагдаж байсан “Монгол оркестр” ХХК-ийн эзэмшигч нас барсан нь улсын бүртгэлийн лавлагаагаар тогтоогдож байх тул эрэн сурвалжлах ажиллагааг зогсоосон байна. Энэ нь уг авлага барагдахгүй байх нөхцөлийг үүсгэсэн байна.
- СБД-ийн 20-р хороо, Сэлбэ /14020/ 18-р хэсэг гудамж, 1801 тоотод байрлах 3240 м.кв, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийг түрээслэгч “Эрхэт Монгол” ХХК-тай 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр №ТГ-10/22 дугаартай гэрээ байгуулан 1 сарын 2,200,000.00 төгрөгөөр түрээсэлсэн байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан түрээсийн төлбөрийн доод хязгаараас 22 дахин бага байна.



Энэ нь НДҮЗ-ийн 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр баталсан “Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийн хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам”-ын 5.9-д “Хөрөнгийг түрээслүүлэхэд түрээсийн төлбөрийн хэмжээг зах зээлийн тухайн үеийн үнэ болон бусад холбогдох үзүүлэлтүүдийг харгалзан тогтоож, гэрээнд тусгана” гэж заасантай нийцэхгүй байна.

2.38. НДҮЗ-ийн Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээн авсан дээрх хөрөнгүүдийн түрээсийн гэрээний биелэлтэд хяналт хийх, НДЕГ-ын Дотоод аудит, мониторингийн газар чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс дээрх зөрчлүүд гарсан байна.

Эрүүл мэндийн даатгалын санд хамаарах асуудал:

2.39. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолын дагуу ЭМС-ын эрхлэх асуудлын хүрээнд ЭМДЕГ-ыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр байгуулж, арилжааны банканд харилцах, хадгаламж хэлбэрээр байршиж байсан 444.4 тэрбум төгрөг, Засгийн газрын бонд 31.2 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг Нийгмийн даатгалын ерөнхий газраас шилжүүлэн хүлээн авсан байна.

2.40. Эдгээр мөнгөн хөрөнгөний нэг хэсэг болох Капитал банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн 136.1 тэрбум төгрөгийн авлага 2024 оны 9 дугаар сарын 25-ны байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 19: Капитал банкны ЭМДС-д төлж барагдуулсан хөрөнгө /төгрөг/

Сангийн нэр	Нэхэмжилсэн дүн	Мөнгөн хэлбэрээр /барагдуулсан/	Хөрөнгө хэлбэрээр	Нийт үлдэгдэл
Эрүүл мэндийн даатгал	136,113,246,755.60	12,032,422,531.33	46,680,786,124.27	77,400,038,100.00

Эх сурвалж: ЭМДЕГ

Эрүүл мэндийн даатгалын сангийн авлагад тооцон хүлээн авсан хөрөнгийн (үл хөдлөх) дүн - 46,7 тэрбум төгрөгийн 52 объект. Үүнээс: 31,0 тэрбум төгрөгийн 46 объектыг ЭМДЕГ дангаараа, 15,7 тэрбум төгрөгийн 6 объектыг НДЕГ-тай хамтран эзэмшиж байна.

2.41. ЭМДҮЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах” журмыг баталсан байна.

Журмын 6.37-д ЭМДЕГ нь сангийн авлагад тооцон авсан орон сууцыг **Эрүүл мэндийн даатгалын албан хаагчид болон иргэн, хуулийн этгээдэд** банкны зээлээр болон бэлэн мөнгөөр худалдан борлуулах ажлыг зохион байгуулж болно. Энэ тохиолдолд дуудлага худалдаа зохион байгуулахгүйгээр шийдвэрлэнэ” гэсэн дээр дурдсан НДҮЗ-ийн тогтоолтой агуулга адилхан тогтоол баталсан байна.

Тус тогтоолыг үндэслэн мэдээлэлд ойр болон салбарын албан хаагчид дуудлага худалдаа зохион байгуулахгүйгээр шууд гэрээ байгуулан **18** албан хаагч орон сууц худалдан авсан байна.

2.42. Банкны эрх хүлээн авагчаас хүлээн авсан хөрөнгөнөөс 2022 онд Өвөрхангай аймаг дахь үл хөдлөх хөрөнгийг худалдан авах саналыг 2 этгээдээс ирүүлснээс хамгийн өндөр үнэ санал болгосон “Монгол эм импекс концерн” ХХК-ийг ялагчаар тодруулж, 988.3 сая төгрөгөөр борлуулсан байна. Мөн Орхон аймгийн Баян-Өндөр сум 8 дугаар баг Бүрэнбүст, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар баг, Ховд аймаг Жаргалант сум Магсаржав багт байрлах зэрэг 3 объектыг “Монгол эм импекс концерн” ХХК-тай гэрээ байгуулан худалдахаар болсон байна.

Капитал банкны эрх хүлээн авагчаас цаашид хийж гүйцэтгэх ажиллагаа нь дараах байдалтай байна. Үүнд:

Банкны нэр дээрх 57 байршилд 114 ширхэг 70.9 тэрбум төгрөгийн үнэлгээний дүн бүхий үл хөдлөх хөрөнгө, үүнээс 64.3 тэрбум төгрөгийн дүн бүхий 3 ширхэг хөрөнгө нь одоо болтол шүүхийн байгууллагаар маргаантай байна,

Чанаргүй зээл, авлага нийт 57.7 тэрбум төгрөг шүүхийн шатанд байна,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр 164 тооны 46.5 тэрбумын албадан төлүүлэх ажиллагааг гүйцэтгүүлж, өр төлбөрийг барагдуулна.

2.43. Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээн авсан хөрөнгийг худалдан борлуулсан болон түрээсэлсэн үйл явцад гарсан зөрчлийг арилгаж, дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Чингисхаан банк

Чингис хаан банк нь 2024 оны 10 дугаар сарын байдлаар НДС-д **95.3** тэрбум, ЭМДС-д **30.6** тэрбум нийт **126.9** тэрбум төгрөгийг төлөх үлдэгдэлтэй байна.

Нийгмийн даатгалын санд хамаарах асуудал:

2.44. Чингисхаан банканд НДҮЗ-ийн шийдвэрээр 2012 оноос эхлэн байршуулсан мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 20: Чингисхаан банканд байршуулсан мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Он	Харилцах дансны үлдэгдэл	Хадгаламжийн дансны үлдэгдэл	Нийт мөнгөн хөрөнгийн дүн
2012	97.30	13,000.00	13,097.30
2013	6,295.11	18,000.00	24,295.11
2014	11,205.64	43,000.00	54,205.64
2015	15,624.01	48,000.00	63,624.01
2016	12,152.54	48,000.00	60,152.54
2017	48,246.86	77,590.00	125,836.86
2018	26,423.42	70,120.00	96,543.42
2019	38,502.22	57,180.00	95,682.22
2020	104,387.51		104,387.51
2021	100,549.46		100,549.46
2022	96,105.88		96,105.88
2023	94,916.88		94,916.88
2024.10	94,916.88		94,916.88

2024 оны байдлаар нийт 94.9 тэрбум төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй байна.

Эх сурвалж: НДЕГ

2.45. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг гаргуулах тухай нэхэмжлэл гарган, 2020-10-22 өдрийн 181/ШШ2020/02624 дугаар шүүгчийн захирамжаар нэхэмжлэлийг бүрэн хангаж, “Чингис хаан банк”-аас **101.7 тэрбум** төгрөгийг гаргуулж, Нийгмийн даатгалын ерөнхий газарт олгохоор шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 21: Чингисхаан банкнаас нэхэмжилсэн хөрөнгийн бүтэц /сая төгрөг/

Үзүүлэлт		Мөнгөн дүн, эзлэх хувь
Чингис хаан банкнаас нэхэмжилсэн дүн		101,768.2
Үүнээс	2012-2020 онуудад санд бодогдсон хүүгийн орлого	52,629.0
	Хүүгийн орлогын эзлэх хувь	51.7%
	Сангийн үндсэн мөнгө	49,139.2

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

Сангийн үндсэн мөнгөний эзлэх хувь	48.3%
------------------------------------	-------

Эх сурвалж: НДЕГ

2.46. Чингисхаан банк нь 2020 оны 8, 9, 10 дугаар сарын хүүгийн орлого 2.3 тэрбум төгрөгийг НДС-ийн харилцах дансанд шилжүүлсэн ч 12 дугаар сард буцаан татсан байна. Иймд тус газар нь 2021 онд Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүүгийн орлого 2.3 тэрбум төгрөгийн нэхэмжлэл гаргаснаар тус шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 181/ШШ2024/00464 шүүгчийн захирамжаар “Чингис хаан банк”-аас **1.8 тэрбум** төгрөгийг гаргуулж, Нийгмийн даатгалын ерөнхий газарт олгохоор шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 22: Чингисхаан банкны НДС-д төлж барагдуулах хөрөнгийн үлдэгдэл /төгрөг/

Огноо	Эхний үлдэгдэл	Барагдуулсан		Хүүгийн авлага	Эцсийн үлдэгдэл
		Мөнгөн хөрөнгөөр	Хүүгийн орлого		
2020.10.22	101,768,202,443.61	200,000,400.00			101,568,202,043.61
2021	101,568,202,043.61	1,042,455,770.00	23,715,616.50		100,549,461,890.11
2022	100,549,461,890.11	4,443,586,644.21			96,105,875,245.90
2023	96,105,875,245.90	1,189,000,000.00			94,916,875,245.90
2024.10.31	94,916,875,245.90	1,366,148,155.83		1,801,879,117.00	95,352,606,207.07

Эх сурвалж: НДЕГ

2.47. Нийт нэхэмжилсэн **103.57¹⁵** тэрбум төгрөгөөс 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийтдээ 8.2 тэрбум төгрөгийн /үүнээс 2024 онд 1.3 тэрбум төгрөг/ төлбөр төлөгдөж, 95.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас ҮОМШӨ-ний даатгалын сангийн 90.76 тэрбум, ажилгүйдлийн даатгалын сангийн 0.2 тэрбум, тэтгэмжийн даатгалын сангийн 4.39 тэрбум төгрөг байна.

Эрүүл мэндийн даатгалын санд хамаарах асуудал:

2.48. ЭМДЕГ нь Чингисхаан банкнаас нэхэмжилсэн 30.8 тэрбум төгрөгөөс 2024 оны 07 дугаар сарын 1-ний өдөр 200.0 сая төгрөгийг банк хоорондын гүйлгээ хийж барагдуулсан байна. Одоогийн байдлаар Чингисхаан банкнаас ЭМДЕГ-т төлөх төлбөр 30.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 23: Чингисхаан банкны ЭМДС-д төлж барагдуулах хөрөнгийн үлдэгдэл /төгрөг/

Сангийн нэр	Нэхэмжилсэн дүн	Мөнгөн хэлбэрээр барагдуулсан	Нийт үлдэгдэл
ЭМДС	30,895,734,362.96	200,000,000.00	30,695,734,362.96

Эх сурвалж: ЭМДЕГ

2.49. Чингисхаан банкны хувьцаа эзэмшигч “Ньюстандарт финанс” ХХК нь 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр гадаадын хөрөнгө оруулалттай “Баянмөнх техник дэвшил ХО” ХХК-тай “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулж, тус банкны энгийн хувьцааг худалдахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авахаар холбогдох баримт бичгийг Монгол банканд хүргүүлсэн тухай мэдээллийг гэрээ байгуулсан талуудаас НДЕГ-т ирүүлсэн ч одоог хүртэл шийдэгдээгүй хүлээгдэж байна.

2.50. Монгол банкнаас 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А-6/464 дугаар албан бичгээр БНХАУ-ын хөрөнгө оруулагчийн зүгээс албан ёсоор нэмэлт мэдээлэл, баримт бичиг ирүүлээгүй хэвээр байгаа талаар мэдэгдсэн байна.

2.51. Чингисхаан банкнаас НДЕГ-т 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн ГЗ/237 дугаартай албан бичгээр цаашид санд учирсан хохирлыг барагдуулах талаар мэдээлэл хүргүүлсэн байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад тухайн банканд төлөгдөх нийт

¹⁵ Чингисхаан банкнаас нэхэмжилсэн дүн болон хүүний авлага нийлсэн дүн

61.0 тэрбум төгрөгийн дүн бүхий 52 зээлдэгчид холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгааг дурдсан байна.

НДС-ийн хөрөнгө байршиж байгаа арилжааны банкнуудын үлдэгдэл

2.52. НДС-ийн хөрөнгө байршиж байгаа арилжааны банкнуудын харилцах дансны үлдэгдэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар дараах байдалтай байна.

Хүснэгт 24: Арилжааны банканд байршиж байгаа НДС-ийн үлдэгдэл /сая төгрөг/

№	Банкны нэр	Төвлөрсөн харилцахын үлдэгдэл	НДС-ийн төрөл					Дүн
			Тэтгэвэр	Тэтгэмж	ҮОМШӨ	Эрүүл мэнд	Ажилгүйдэл	
1	Голомт банк	38,460.5	46,769.2	43,210.6	67,373.8	0.0	266.2	196,080.4
2	Капитрон банк	1,401.7	4,279.8	8,942.9	27,284.2	0.0	473.5	42,382.1
3	Төрийн банк	10,520.5	167,057.6	72,669.5	189,752.6	0.0	1,230.1	441,230.3
4	Төрийн сан	70,508.9	10,192.3	81,720.5	92,647.6	9,575.7	20.5	264,665.6
5	ХААН банк	71,926.2	274,952.1	12,708.9	151,946.9	0.0	2,396.9	513,931.0
6	Хас банк	1,775.5	894.2	6,289.2	236.8	0.0	15.1	9,210.8
7	Худалдаа хөгжлийн банк	34,861.3	44,233.5	18,216.3	39,812.8	0.0	230.1	137,354.0
8	Чингис хаан банк	0.0	0.0	4,389.1	88,998.7	0.0	1,050.5	94,438.2
9	Солонгос үрий банк	0.0	16.5	0.0	0.0	0.0	0.0	16.5
10	Солонгос Кеб банк	0.0	4.7	0.0	0.0	0.0	0.0	4.7
11	Солонгос Шинхан банк	0.0	2.3	0.0	0.0	0.0	0.0	2.3
12	Солонгос Күкмин банк	2.7	0.4	0.0	0.0	0.0	0.0	3.2
13	Богд банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-
Нийт дүн:		229,457.3	548,402.8	248,147.2	658,053.5	9,575.6	5,682.8	1,699,319.4

Эх сурвалж: НДЕГ

Арилжааны банканд байгаа НДС-ийн хөрөнгө 2024 оны эхний хагас жилийн байдлаар 1.6 их наяд төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй байна.

Бусад банк болон найдваргүй авлага	2000 оноос өмнө 7 банктай холбоотой 5.4 тэрбум төгрөг төлөгдөөгүй, 2003, 2005 онд нийт 0.5 тэрбум төгрөгийг найдваргүй авлагаар тооцон хүчингүй болгосон байна.
---	---

2.53. НДЕГ-ын дансанд бүртгэлтэй 2000 оноос өмнө үүссэн 7 банктай холбоотой 5.4 тэрбум төгрөгийн хүрээнд НДЕГ нь холбогдох төрийн байгууллагуудад албан хүсэлтүүд явуулж байсан хэдий ч одоог хүртэл ямар нэгэн арга хэмжээ авагдаагүй, Монгол банкнаас 2017 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн А-1/1299 дугаартай албан бичгээр хуульд заасан дарааллын дагуу банкны нийт өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэн үлдсэн хөрөнгийг тухайн банкны активд хааж, банктай холбоотой бүх үйл ажиллагаа бүрэн дуусгавар болсныг мэдэгдсэн байна.

2.54. НДЕГ-аас 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Чиглэл хүсэх тухай” 01/201 дугаартай албан бичгээр Сангийн яаманд дээрх авлагыг холбогдох газруудаас ирсэн албан бичиг, татан буугдсан тухай шийдвэрүүдийг үндэслэн хааж болох эсэх талаар зөвлөмж өгөхийг хүсэж хандсан боловч 2024 оны 09 дүгээр сарын байдлаар хариу ирүүлээгүй байна.

Хүснэгт 25: Татан буугдсан банктай холбоотой хөрөнгийн дүн /төгрөг/

№	Банкны нэр	Мөнгөн дүн	Татан буугдсан огноо	Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаалын дугаар
1	Монгол бизнес банк	200,000,000.0	1998.09.29	418
2	Азийн хөгжлийн банк	19,566,800.0	1999.09.07	428
3	Экспорт импортын банк /Экзим/	753,219,260.5	1999.12.27	650
4	Ардын банк	824,487,505.1	1996.12.13	359
5	Монгол даатгал банк		1996.12.13	360
6	ХОТШ банк	1,582,192,540.6	1999.12.24	646
7	Сэргээн босголтын банк	2,066,646,185.7	1999.12.24	647
	Нийт	5,446,112,291.9		

Эх сурвалж: НДЕГ

2.55. Эдгээр 7 банктай холбоотой 5.4 тэрбум төгрөг нь 2023 оны байдлаар 40.8 тэрбум төгрөгийн ханштай (Хэрэглээний үнийн ерөнхий индексийг ашиглан тооцсон) байна. Тодруулбал уг авлага барагдаагүй удсанаас үнэ цэний алдагдалд орсон байна.

2.56. Архивын ерөнхий газраас дээрх татан буугдсан 7 банктай холбоотой баримт, материал татаж үзэхэд НДС-ийн хөрөнгөтэй холбоотой баримт материал байхгүй байна.

2.57. Мөн НДҮЗ-ийн 2003 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоор 239 байгууллагын 303,496,664.55 төгрөг, 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй зарим аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан, дампуурсан, төлбөр хариуцагч нь нас барсан гэх үндэслэлээр 81 ажил олгогчтой холбоотой 214,262,257.34 нийт **517,758,921.89** төгрөгийн шимтгэлийн авлагыг найдваргүйд тооцож хүчингүй болгосон байна.

2.58. Нийгмийн даатгалын байгууллага нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /2003/-ийн 24.2-т “Иргэний хуулийн 32.3-т заасны дагуу татан буулгах комисс тухайн хуулийн этгээдийг татан буулгасан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас багагүй, зургаан сараас илүүгүй хугацаа өнгөрсний дараа уг хуулийн этгээдийг татан буулгаж дууссан тухай холбогдох бүртгэх байгууллагад мэдэгдэнэ”, Иргэний хуулийн 32.4-т “Татан буулгах комиссоос нэхэмжлэгчдийн өргөдөл хүлээн авах хугацаа нь хуулийн этгээдийг татан буугдсан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас багагүй, зургаан сараас ихгүй байна” мөн Компанийн тухай хуулийн 27.2-т “Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах журам, хугацааг нийтэд мэдээлнэ. Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах тухайг нийтэд мэдээлснээс хойш 2 сараас багагүй, 6 сараас ихгүй байна” гэж заасан байх тул 2005 онд зар мэдээнд орсон үед нийгмийн даатгалын байгууллагаас өр төлбөр барагдуулахаар нэхэмжлэл гаргах боломжтой байсан байна.

Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулсан байдал:

2.59. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангаас арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулсан хөрөнгийн хүүгийн хэмжээг Монгол банкны бодлогын хүүтэй харьцуулан харуулав.

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

Хүснэгт 26: Бодлогын хүү, гэрээний хүүгийн зөрүү /сая төгрөг/

Банкны нэр	Гэрээний нийт дүн	Гэрээ тус бүрийн дүн	Гэрээ байгуулсан огноо	Хугацаа /сар/	Хадгаламжийн хүү	Арилжааны банкнуудын жигнэсэн дундаж хүү	Монгол банкны бодлогын хүү	Хүүгийн зөрүү
Капитрон банк	12,020,0	10,000,0	2019-02-04	12	14	12.04	11	3
		620,0		12	7.00	12.04	11	-4.00
		1,400,0		6	12.60	12.04	11	1.60
Кредит банк	29,000,0	13,000,0	2019-05-30	12	14.00	14.5	11	3.00
		6,000,0	2019-06-20	12	14.00	14.5	11	3.00
		10,000,0	2019-11-06	12	14.00	14.5	11	3.00
Төрийн банк	128,000,0	40,000,0	2019-02-13	12	14	12.86	11	3.00
		41,000,0		12	7.00	12.86	11	-4.00
		47,000,0		6	12.60	12.86	11	1.60
Голомт банк	2,550,0	950,0		12	7	9.87	11	-4.00
		1,600,0		6	12.6	9.87	11	1.60
Тээвэр хөгжлийн банк	45,000,0	10,000,0	2019-10-11	12	14.4	8.97	11	3.40
		35,000,0	2019-10-16	12	14.4	8.97	11	3.40
Улаанбаатар хотын банк	33,900,0	1,600,0		12	7.00	11.23	11	-4.00
		2,300,0		6	12.60	11.23	11	1.60
		30,000,0	2019-02-13	12	14	11.23	11	3.00
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	5,030,0	5,000,0	2018-10-11	12	13.2	10.41	11	2.20
		30,0		12	7	10.41	11	-4.00
Хаан банк	170,000,0	40,000,0	2019-02-13	12	14	11.93	11	3.00
		66,000,0		12	7.00	11.93	11	-4.00
		64,000,0		6	12.60	11.93	11	1.60
Худалдаа хөгжлийн банк	1,600,0	1,000,0		6	12.60	11.05	11	1.60
		600,0		12	7.00	11.05	11	-4.00
Чингис хаан банк	57,180,0	15,000,0	2018-10-31	12	13.3	14	11	2.30
		8,000,0	2018-12-25	12	14	14	11	3.00
		23,590,0	2018-12-26	12	14	14	11	3.00
		5,000,0	2018-12-29	12	14	14	11	3.00
		5,500,0	2019-02-21	12	14	14	11	3.00
		40,0		12	7.00	14	11	-4.00
		50,0		6	12.60	14	11	1.60
Нийт	484,280.0							

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.60. Дээрх үзүүлэлтээс харахад Капитрон, Төрийн, Голомт, Улаанбаатар хотын, Худалдаа хөгжлийн, Чингис хаан банкнуудад нийт 110.8 тэрбум төгрөгийг бодлогын хүүгээс 4 хувиар бага байршуулсан байна. Уг хөрөнгийг хамгийн багадаа бодлогын хүүтэй тэнцүү хувиар байршуулахад **12.19** тэрбум төгрөгийн хүүгийн орлого олох боломжийг алдсан байна.

2.61. Монгол банкны бодлогын хүүгээс бага хүүгээр байршуулсан зарим шалтгаан нь Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.24-т “Тэтгэврийн зөрүүг ойртуулах, зээлийн хүүг бууруулах бодлого баримтална” гэж заасан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2017 онд 84.0 тэрбум, 2018 онд 29.5 тэрбум, 2019 онд 228.2 тэрбум, 2020 онд 694.7 тэрбум төгрөгийг НДЕГ-аас тэтгэврийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт хөрөнгө байршуулахаар арилжааны банкнуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, мөнгөн хадгаламж байршуулсан байна.

2.62. Энэ үйл ажиллагаа нь НДТХ-н /хуучин нэрээр/ 11-р зүйлд зааснаас бусад хэлбэрээр сангийн хөрөнгийг ашиглаж байгаа учир 1 удаагийн шинж чанартай гэнэтийн шийдвэрүүд нь сангийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна.

2.63. Мөн Чингис хаан банканд 2014 - 2020 онд нийт 56 удаагийн мөнгөн хадгаламж байршуулахад 24 -т, Капитал банканд нийт 72 удаагийн мөнгөн хадгаламж байршуулахдаа 48 тохиолдолд нь Монгол банкны бодлогын хүүгээс доогуур байршуулсан байна. (Дэлгэрэнгүй хавсралт №2-оос харна уу)

2.64. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд 2014-2020 онуудад хадгаламж хэлбэрээр байршуулснаар нийт 400.5 тэрбум төгрөгийн хүүгийн орлого төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 27: Арилжааны банкны хадгаламжийн хүүгийн орлого /сая төгрөг/

Банк	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Голомт банк	3,076,7	3,590,3	4,616,4	7,510,0	2,425,5	11,345,2	228,9
Капитал банк	17,732,5	21,264,5	16,515,7	24,659,8	10,469,6	38,1	-
Капитрон банк	751,2	1,472,7	1,962,5	3,541,2	2,341,3	3,260,6	243,9
Төрийн банк	7,439,8	8,369,8	5,494,9	3,866,8	1,772,8	12,266,3	11,487,8
Улаанбаатар хотын банк	10,075,1	14,349,7	12,620,2	23,917,0	14,354,8	10,436,4	847,5
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	906,3	1,312,1	2,775,9	6,987,0	4,567,7	1,003,8	5,4
Хаан банк	1,229,9	1,004,2	577,8	1,655,9	3,885,8	12,687,7	15,573,8
Худалдаа хөгжлийн банк			2,161,9	7,443,7	6,383,2	44,6	80,3
Чингис хаан банк	4,345,2	4,759,5	4,716,9	10,530,9	9,120,6	9,063,1	113,4
Тээвэр хөгжлийн банк					1,322,2	6,139,4	2,033,9
Кредит банк						1,736,7	2,082,2
Нийт	45,557,0	56,122,9	51,442,5	90,112,4	56,643,8	68,022,3	32,697,3
Бүгд дүн				400,598.2			

Эх сурвалж: НДЕГ

2.65. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөнөөс 2020-2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2 их наяд 475 тэрбум төгрөгийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд хадгаламж хэлбэрээр байршуулах боломжтой талаар НДЕГ-с тооцоолол хийн төслөө Монгол банк, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Хүснэгт 28: Хадгаламж хэлбэрээр байршуулах боломжтой байсан чөлөөт үлдэгдэл (тэрбум төгрөг)

2020-2024.06 байдлаар НДЕГ-с арилжааны банканд байршуулах боломжтой байсан сангийн чөлөөт үлдэгдэл						
	Мөнгөн дүн	Хугацаа (сар)	Бодлогын хүү (min)	Хүүгийн орлого	Нийт	Хүү орох хугацаа
2020	950.0	12	9	85.5	1035.5	Сар бүрийн эцэст
2021	220.0	12	6	13.2	233.2	Сар бүрийн эцэст
2022	560.0	12	6.5	36.4	596.4	Сар бүрийн эцэст
2023	530.0	12	13	68.9	598.9	Сар бүрийн эцэст
2024.06	215.0	6	11	11.8	226.8	Сар бүрийн эцэст
	2,475.0			215.8	2,690.8	

Эх сурвалж: НДЕГ

2.66. НДЕГ-аас 2020 оны “Хүсэлт гаргах тухай” 1/457, 2021 оны “Хүсэлт хүргүүлэх тухай” 1/269, 2022 оны “Хүсэлт хүргүүлэх тухай” 04/423, 2023 оны “Хүсэлт хүргүүлэх тухай” 01/349 дугаар албан бичгээр тухайн онуудын эхний улиралд хадгаламж хэлбэрээр байршуулах

хөрөнгийн санал, тооцоолол, шийдвэрийн төслийг НДҮЗ-ийн ажлын албанд хүргүүлсэн байна.

2.67. НДҮЗ-өөс санал, тооцооллыг Сангийн яам, Монгол банканд санал авахаар хүргүүлсэн боловч 2020 онд Сангийн яам, Монгол банк, 2021, 2022 онд Сангийн яамнаас зөвшөөрөөгүй тул тухайн онуудад хөрөнгийн дээд хэмжээг батлаагүй байна. НДҮЗ 2023 онд санал тооцоолол хүргүүлээгүй байна.

2.68. Монгол банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болон бусад санхүүгийн үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэхийг харгалзан үзэж арилжааны банкийг сонгож сангийн чөлөөт хөрөнгийг мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулахыг дэмжиж буйгаа илэрхийлжээ. Гэвч Сангийн яам “Арилжааны банканд хадгаламж байршуулах нь хүүгийн орлого өндөр авч байгаа ч гарч буй эрсдэл өндөр байна. Иймд дахин эрсдэл үүсэхээс сэргийлж мөнгөн хөрөнгийг арилжааны банканд байршуулахыг дэмжих боломжгүй” гэж албан бичгээр удаа дараа илэрхийлсэн байна.

2.69. Хамтарсан шийдвэр батлагдаагүйн улмаас тухайн онуудад нийт **215.8** тэрбум төгрөгийн хүү авах боломж алдагдсан байна.

Бонд

2.70. Монгол Улсын Засгийн газраас 2010-2015 онд гаргасан бондод НДС-аас нийт 424.7 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулж 50.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлого төвлөрүүлсэн байна. Бондын хүүгийн орлого нь банканд хадгаламж хэлбэрээр байршуулсан хүүгийн орлогоос бага дүнтэй ч эрсдэлгүй байдгаараа онцлогтой байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №3-аас харна уу)

2.71. Монгол Улсын Засгийн газраас 2019-2022 онд бонд гаргаагүй ба 2023 онд “Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-р сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат бонд, Монгол банкны үнэт цаас худалдан авах доод хэмжээг 300.0 тэрбум төгрөгөөр баталсан байна.

2.72. Энэ хүрээнд ХНХС-аас СаС-д бонд худалдан авах хүсэлт хүргүүлсэн ч хариу ирүүлээгүй тул Засгийн газрын бонд худалдан аваагүй байна.

Үнэт цаас

2.73. Нийгмийн даатгалын тухай хуулийн (хуучин нэрээр) 10¹⁶-т НДС-ийн хөрөнгөөр Монгол банкны үнэт цаас худалдан авч болохоор заасан ч Монгол банкны Ерөнхийлөгчийн 2020 оны 6-р сарын 17-ны өдрийн А-205 тоот тушаалаар баталсан “Төв банкны үнэт цаасны журам”-аар төв банкны үнэт цаасны арилжаанд зөвхөн банк оролцож болохоор зохицуулснаас уг заалт хэрэгжихгүй байна. Өөрөөр хэлбэл НДЕГ тус арилжаанд орох эрхгүй байна.

2.74. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журмыг 2024 онд шинэчлэн баталж сангийн хөрөнгийг дараах зүйлд хөрөнгө оруулахаар тусгасан байна. Үүнд:

- Засгийн газрын үнэт цаас худалдан авах;
- Монгол банкны үнэт цаасны арилжаанд оролцох;
- Төрийн сангийн нэгдсэн дансанд хугацаатай мөнгөн хадгаламж байршуулах;

¹⁶ Хуримтлалын сангийн хөрөнгийг Засгийн газрын бонд болон Монгол банкнаас гаргасан үнэт цаас худалдан авах, арилжааны банканд байршуулах замаар нэмэгдүүлж болно.

- Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банкны системд нөлөө бүхий арилжааны банк (цаашид “арилжааны банк” гэх)-д хугацаатай хадгаламж байршуулах замаар хөрөнгө оруулж сангийн хөрөнгийг өсгөн нэмэгдүүлж болохоор тусгасан байна.

2.75. Одоогийн байдлаар НДҮЗ, НДЕГ нь сангийн хөрөнгийг өсгөн нэмэгдүүлэх чиглэлээр Монгол банкны үнэт цаас худалдаж аваагүй, Төрийн сангийн дансанд хугацаатай мөнгөн хадгаламж байршуулаагүй байна.

2.76. ЗГ-ын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-ын 2.1.3-д “Төрийн сангийн нэгдсэн дансанд хугацаатай мөнгөн хадгаламж байршуулах” гэж тусгасан нь Төсвийн тухай хуульд заасан төрийн сангийн чиг үүрэгтэй нийцэхгүй байгаагаас Төрийн сангийн дансанд хугацаатай мөнгөн хадгаламж байршуулах боломжгүй байна. Тодруулбал:

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- 4.1.40-д “төрийн сангийн үйл ажиллагаа” гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг”,
- 4.1.41-д “төрийн сангийн нэгдсэн данс” гэж Засгийн газрын нэгдсэн зохицуулалт бүхий төсвийн ерөнхий данс болон Монгол Улсын нэгдсэн төсөвт хамаарах бүх төсвийн захирагчийн Монгол банканд байрших мөнгөн хөрөнгийн харилцах дансыг хэлнэ” гэж заасан учир Төрийн сангийн нэгдсэн дансанд сангийн хөрөнгийг зөвхөн харилцах дансанд байршуулах боломжтой ба хугацаатай хадгаламжаар байршуулж хүү тооцох эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Эдгээр арга хэрэгслээс гадна одоогийн байдлаар сангийн хөрөнгийг өсгөн нэмэгдүүлэх үйл ажиллагаа хийгдээгүй байна.

Ажиллах хүчин нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд бүрэн хамрагдаагүй байна.

2.77. Нийгмийн даатгалд 2023 оны байдлаар давхардаагүй дүнгээр 961.1 мянган албан журмын даатгуулагч, 78.0 мянган сайн дурын даатгуулагч, нийт 1.1 сая даатгуулагч хамрагдсан нь нийт ажиллах хүчний¹⁷ 88.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 29: Нийт ажиллах хүч, даатгуулагчдын харьцаа

Он	Ажиллах хүч	Нийт даатгуулагчдын тоо	Үүнээс:		Даатгуулагчдын ажиллах хүчинд эзлэх хувь
			Албан журмаар	Сайн дураар	
2020	1,250,608	979,437	830,410	181,159	78.3%
2021	1,225,373	1,006,154	834,814	206,957	82.1%
2022	1,265,211	1,012,355	925,511	176,593	80.0%
2023	1,285,103	1,063,002	961,105	178,183	82.7%

Эх сурвалж: НДЕГ-ын мэдээллийн систем өгөгдөл, 1212.mn

2.78. Энэ үзүүлэлтээс харахад даатгуулагчдын ажиллах хүчинд эзлэх хувь жилээс жилд өссөн байна.

2.79. Манай улсын идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ийн дунджаар 70 хувь нь нийгмийн даатгалд бүртгэлтэй байна. Мэдээллийг харуулав.

¹⁷ Ажиллах хүч гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

Хүснэгт 30: ААНБ-ын мэдээлэл /мянган ААНБ/

	Улсын бүртгэлд бүртгэлтэй ААНБ-ын тоо	Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо	Нийгмийн даатгалд бүртгэлтэй ААНБ-ийн тоо	Нийгмийн даатгалд хамрагдсан хувь
2019	159.3	63.1	48.2	76
2020	173.4	66.7	49.3	74
2021	189.6	73.1	52.8	72
2022	207.9	86.5	55.5	64
2023	225.9	94.2	58.7	62
Дундаж хувь				70.0

Эх сурвалж: УБЕГ, ТЕГ, НДЕГ

2.80. Нийгмийн даатгалын багц хууль 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжсэнээр малчин, туслах малчин, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хувийг төрөөс төлүүлэх боломжтой болсон байна.

2.81. Ажиллах хүчинд даатгуулагчдын эзлэх хувийг өсгөх, албан журмын болон сайн дурын даатгуулагчийн хамралтыг нэмэгдүүлэхэд нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах нь чухал байна.

ААНБ-ын НДШ-ийн өр	ААНБ-ын НДШ-ийн өр хагас их наяд төгрөгт хүрч 448,434 даатгуулагч хохирсоор байна.
---------------------------	--

2.82. ААНБ-ын НДШ-ийн өр дараах байдалтай байна.

Хүснэгт 31: ААНБ-ын НДШ-ийн өрийн мэдээлэл /сая төгрөг/

Он	Оны эхний үлдэгдэл		Тухайн онд шинээр үүссэн		Нийт барагдуулсан		Өр, авлагын эцсийн үлдэгдэл	
	ААН тоо	Өрийн хэмжээ	ААН тоо	Өрийн хэмжээ	ААН тоо	Барагдуулсан	ААН тоо	Өрийн хэмжээ
2019	14110	116,620.72	29935	964,049.08	29131	932,863.00	14813	137,855.45
2020	14504	137,855.45	41255	953,786.51	31472	894,553.14	24175	196,609.76
2021	24188	196,609.76	41255	1,226,040.67	36733	1,124,142.38	28723	297,053.93
2022	28723	297,555.99	40408	1,095,445.18	33941	1,038,804.89	32494	353,973.74
2023	31482	353,971.90	27370	477,927.16	21964	437,514.87	29067	399,464.23

Эх сурвалж: НДЕГ

2.83. Дээрх шимтгэлийн өр нь 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар **541,883.86** сая төгрөгт хүрсэн байна. Үүнд **43,377** ажил олгогч, **448,434** даатгуулагч хамааралтай байна. Өөрөөр хэлбэл нийт **448,434** даатгуулагчийн эрх ашиг хөндөгдөж байна. Уг өрийг ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр ангилан харуулбал:

Хүснэгт 32: НДШ-ийн өртэй ААНБ-ын мэдээлэл /сая төгрөг/

Д/д	Хариуцлагын хэлбэр	Ажил олгогчийн тоо	Даатгуулагчийн тоо	НДШ-ийн өрийн хэмжээ	Нийт өрд эзлэх хувь
1	Төрийн өмчит үйлдвэрийн газар	105	10965	8,650.67	1.60
2	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	134	4731	3,554.58	0.66
3	Хувьцаат компани	4499	46405	57,902.27	10.69


Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

4	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	29780	244697	399,884.88	73.80
5	Хоршоо	401	814	600.20	0.11
6	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	240	1620	870.90	0.16
7	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	144	616	646.40	0.12
8	Төсөвт байгууллага	1390	86106	27,246.85	5.03
9	Төрийн бус байгууллага	1594	8364	7,127.13	1.32
10	Бусад	5090	44116	35,399.98	6.53
	Нийт	43377	448434	541,883.86	100.00

Эх сурвалж: НДЕГ

Дээрх үзүүлэлтээс харахад хувийн хэвшлийн ААН-дийн НДШ-ийн өр дийлэнх хувийг эзэлж байна. НДШ-ийн өртэй ААН-ийг үйл ажиллагааны чиглэл, салбараар ангилан харуулбал:

Дүрслэл 16: НДШ-ийн өртэй ААН-ийн салбарын ангилал /хувь/



Барилга, уул уурхайн салбарын ААН-үүд нийт өрийн 25.3 хувийг эзэлж байна.

Эх сурвалж: НДЕГ

2.84. ААНБ-ын НДШ-ийн өр буурахгүй байгааг НДЕГ-аас дараах байдлаар тайлбарлаж байгаа ч яг ямар шалтгаанаас ААНБ-ууд өрөө барагдуулахгүй байгаа талаар нарийвчилсан судалгаа, тооцоо байхгүй байна.

- Цар тахлын улмаас ААНБ-ын үйл ажиллагаа нь доголдсон, санхүүгийн хүндрэл үүссэн;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон цалингийн сан жил бүр нэмэгдсэн;
- Бэлэн мөнгөний эрэлт багассан;
- Аж ахуйн нэгжүүд өөр хоорондоо өр, авлага үүсгэсэн;

2.85. НДШ-ийн хамгийн их өртэй 89 ААН-ийг түүвэрлэн авч үзэхэд нийт 123.4 тэрбум төгрөгийн өртэй буюу нийт өрийн 23 хувийг эзэлж байна. Аудитын баг эдгээр ААН-ийн татвар төлөлтийн талаарх мэдээллийг холбогдох татварын байгууллагаас гаргуулан авч үзэхэд албан татварын 3.8 тэрбум төгрөгийн өртэй буюу НДШ-ийн өрнөөс 30 дахин бага байна.

2.86. Энэ нь ААН-үүд НДШ-ээс илүү албан татварыг төлдгийг харуулж байна. Нөгөө талаар нийгмийн даатгалын байгууллага ААНБ-ын НДШ-ийг төлүүлэх, өр үүсгэхгүй байхад хангалтгүй ажиллаж байна.

Ажилгүйдлийн даатгалын сангийн орлогоос давсан зарлагыг хэрхэн нөхөх талаар зохицуулалт байхгүй байна

2.87. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг даатгуулагч 0.2 хувь, ажил олгогч 0.5 хувиар төлөхөөр тусгасан байна. Тус сангийн орлого зарлагын мэдээллийг харуулав.

Хүснэгт 33: Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2020	2021	2022	2023
Орлого	25,941.2	61,940.1	53,575.5	62,721.0
Зарлага	94,911.0	57,754.0	80,335.1	111,016.9
Зөрүү	- 68,969.8	4,186.1	- 26,759.6	- 48,295.9
Тэтгэмж олгосон хүний тоо	21,386	26,156	30,516	30,088
Харилцах, хадгаламжийн үлдэгдэл	42,614.6	59,015.2	38,287.2	5,168.7

Эх сурвалж: НДЕГ

2.88. Энэ үзүүлэлтээс харахад тус сангийн зарлага нь орлогоосоо давсан, сангийн чөлөөт үлдэгдэл 2023 онд 2020 оноос 8 дахин буурсан үзүүлэлттэй байна. Нөгөө талаар ажилгүйдлийн тэтгэмж авч буй иргэдийн тоо өссөн байна.

2.89. Тус сангийн хувьд 2020-2023 онд зарлага өссөнд дараах 2 хүчин зүйл голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Цалингийн нэмэгдэл
- Татан буугдсан ААНБ-ын тоо

Хүснэгт 34: Сарын дундаж цалингийн өсөлт /мянган төгрөг/

Салбар	2020	2021	2022	2023
Улсын дундаж	1,220.60	1,279.40	1,503.80	1,881.79
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	949.6	1,002.80	1,152.30	1,463.88
Уул уурхай, олборлолт	2,877.40	2,997.80	3,601.90	4,587.18
Боловсруулах үйлдвэрлэл	1,163.90	1,227.70	1,443.80	1,733.01
Цахилгаан, хий, агааржуулалт	1,558.90	1,603.30	1,815.20	2,245.08
Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	977.1	1,019.30	1,183.60	1,530.92
Барилга	1,273.90	1,227	1,431	1,818.49
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	1,001.70	1,063.10	1,257.40	1,479.80
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1,203.40	1,287	1,646.20	2,100.11
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	730.2	801.7	968.6	1,170.74
Мэдээлэл, холбоо	1,196.80	1,317.60	1,728.40	1,936.98
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1,453.70	1,515.80	1,927.80	2,261.52
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1,378.30	1,401.40	1,743.60	2,072.46
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1,648.30	1,665.20	1,656.50	2,072.56
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1,084.40	1,162.50	1,264.70	1,561.45
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1,093.20	1,140.70	1,290.50	1,825.80
Боловсрол	1,013	1,045.20	1,211.60	1,515.10
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1,108.60	1,277.50	1,474.60	1,786.89
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	844	873.4	971.4	1,368.60
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1,019.10	1,098	1,278.30	1,567.84
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	906.8	1,042.90	1,205	1,743.27
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1,822.70	1,994.10	4,826.30	4,455.89

Эх сурвалж: ҮСХ

2.90. Дээрх үзүүлэлтээс харахад цалингийн дундаж өсөлт 2020-2023 онуудад 1,220,600.0-1,881,790.0 төгрөг үүнээс салбаруудыг харьцуулж харахад уул уурхайн салбарын дундаж цалингийн өсөлт 2,877,400.0-4,587,180.0 төгрөг болж өсөн нэмэгдсэн нь голлох шалтгаануудын нэг болж байна.

2.91. Ковид цар тахалтай холбоотой эдийн засгийн хямралаас шалтгаалан ААНБ-ууд татан буугдсан, мөн орон тоогоо цомхотгох болсон нь зардал нэмэгдэх суурь шалтгааны нэг болсон байна.

Хүснэгт 35: Татан буугдсан ААНБ-ын тоо

Улсын бүртгэлийн мэдээллийн санд татан буугдсан бүртгэлтэй хуулийн этгээдийн тоо		
Д/д	Огноо	Тухайн жилд
1	2024-06 сарын 30-ны байдлаар	268
2	2023	575
3	2022	618
4	2021	491
5	2020	711
6	2020 он хүртэл	13435
Нийт		16098

Ажилгүйдлийн даатгалын сангийн орлогоосоо давсан зарлагыг хэрхэн нөхөх, удирдах талаар зохицуулалт, бодлого байхгүй байна.

Эх сурвалж: УБЕГ

2.92. Аудитын явцад сарын хугацаанд цахим хэлбэрээр нийгмийн даатгалын талаар санал асуулга авахад нийт 9,423 иргэн хамрагдсан байна. Санал асуулгын дүнг харуулбал:

Санал асуулга: НДС-аас тэтгэмж авахад хүндрэл, бэрхшээл гарч байсан уу?

Дүрслэл 17: НДС-аас тэтгэмж авахад гарч буй асуудал



Ажил олгогч НДС-ийг хугацаанд нь төлөөгүйгээс ажилтан хохирох тохиолдол гарч байна.

ҮОМШӨ-ний даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг үр ашигтай удирдах шаардлагатай байна

2.93. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг ажил олгогч 0.5, 1.5, 2.5 хувиар төлөхөөр заасан байна. Тус сангийн орлого зарлагын мэдээллийг харуулав.

Хүснэгт 36: ҮОМШӨ даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	2020	2021	2022	2023
Орлого /гүйцэтгэл/	145,482.4	129,237.9	208,836.2	282,706.0
Зарлага /гүйцэтгэл/	34,227.2	34,415.8	40,656.7	54,133.6
Зөрүү	111,255.2	94,822.0	168,179.5	228,572.3
Харилцах, хадгаламжийн үлдэгдэл	380,753.6	201,803.6	362,057.5	577,874.3

Эх сурвалж: НДЕГ

2.94. ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого, зарлага, харилцах, хадгаламжийн үлдэгдэл сүүлийн жилүүдэд өссөн байна. Тус сангийн үлдэгдэл 2021 онд өмнөх оноос буурсан нь дараах хүчин зүйлээс хамаарсан байна.

2.95. УИХ-аас коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлыг даван туулах, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр **“Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай”** хуулийг 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр баталсан байна. Тус хуулийн 4¹⁸ дүгээр зүйлд сан хооронд хөрөнгө шилжүүлэн зарцуулж болно гэж заасан байна. Энэ заалтын дагуу ЗГ-ын 2020 оны 140 дүгээр тогтоолоор *“Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”*-ыг баталсан байна.

2.96. Эдгээр хууль, журмын дагуу ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд 2020 онд 435.4 тэрбум төгрөг, 2021 онд 271.2 тэрбум төгрөг нийт 706.6 тэрбум төгрөг шилжүүлсэн ба 2024 оны байдлаар сан хооронд шилжүүлсэн хөрөнгийг буцаан төвлөрүүлээгүй, өглөг авлага үүссэн байдалтай байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хууль /хуучин нэрээр/-ийн 11 дүгээр зүйлийн 2¹⁹-т “Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

2.97. **“Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль”**-ийн үйлчлэл цаг хугацааны хувьд дууссан тул хүчингүй болгох, сан хооронд үүссэн өглөг, авлагыг барагдуулах арга хэмжээ авах шаардлага тулгарч байна.

2.98. Тус сангийн чөлөөт үлдэгдэл жилээс жилд өсөж байгаа бөгөөд уг хөрөнгийг үр ашигтай удирдаж, санхүүгийн хэрэгсэлд ашиглах шаардлагатай байна.

2.99. НДТХ²⁰-д (хуучин нэрээр) ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг ажил мэргэжил харгалзахгүйгээр тухайн ажил олгогчийн үйл ажиллагааны чиглэлээр ногдуулж байсныг шинэчлэн найруулсан НДЕХ²¹-д ажил мэргэжлийн жагсаалтыг үндэслэн тохирох хувь хэмжээгээр ногдуулдаг болсон байна.

2.100. ҮОМШӨ-ний даатгалын сангаас 2 төрлийн тэтгэвэр, 6 төрлийн тэтгэмжүүд олгогдож байна. Тэтгэмж нь нэг удаагийн шинж чанартай учраас сангийн зарлагад эзлэх хувь харьцангуй бага байна. Мэдээллийг харуулав.

Хүснэгт 37: ҮОМШӨ-ний сангийн тэтгэмжийн зарлага /сая төгрөг/

№	Тэтгэмж, төлбөрийн төрөл	2020		2021		2022		2023	
		Хүний тоо	Үнийн дүн	Хүний тоо	Үнийн дүн	Хүний тоо	Үнийн дүн	Хүний тоо	Үнийн дүн
1	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	1,099	929.02	709	689.4	1,166	1,275.1	1,520	1,820.6

¹⁸ “2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1,2,3,4,5 дахь хэсэгт заасан сан хооронд хөрөнгө шилжүүлэн зарцуулж болно

¹⁹ 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 12.2-т “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, нэгтгэх, зориулалт бусаар ашиглахыг хориглоно” гэж заасан.

²⁰ 15.5 ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос 2.8 хүртэл хувиар ялгавартай тогтоох бөгөөд ялгавартайгаар шимтгэл төлөх ажил олгогчийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан Засгийн газар тогтооно.

²¹ 18.2 хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага, эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлөөс хамааралтайгаар ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос ялгавартай тогтоох бөгөөд шимтгэл төлөх ажил мэргэжлийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээ, хэрэглэх журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

2	Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбоотой	15	18.9	9	7.6	9	7.6	8	8.3
3	Рашаан сувиллын зардал	2,071	577.4	831	237.7	2,053	1,115.2	1,910	1,060.0
4	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлбөр	-	687.0	-	740.5	-	1,105.2	-	1,071.9
5	ҮОМШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл	3,876	1,562.3	3,724	1,670.4	3,568	1,502.4	3,472	1,779.4
6	Бусад зардал (үйл ажиллагааны зардал, банкны үйлчилгээний хөлс г.м)	-	2,691.6	-	3,779.9	-	4,724.3	-	12,593.7
Нийт дүн		7,061	6,466.2	5,273	7,124.9	6,796	9,729.8	6,910	18,333.9

Эх сурвалж: НДЕГ

Хүснэгт 38: ҮОМШӨ-ний сангийн тэтгэврийн зарлага /сая төгрөг/


№	Тэтгэврийн төрөл	2020		2021		2022		2023	
		Хүний тоо	Үнийн дүн	Хүний тоо	Үнийн дүн	Хүний тоо	Үнийн дүн	Хүний тоо	Үнийн дүн
1	Тахир дутуугийн	3,876	24,840.0	3,724	24,429.1	3,568	27,509.2	3,472	31,794.6
2	Тэжээгчээ алдсаны	496	2,921.0	476	2,861.8	463	3,417.7	454	4,005.1
Нийт дүн		4,372	27,761.0	4,200	27,290.9	4,031	30,926.9	3,906	35,799.7

Эх сурвалж: НДЕГ

2.101. Аудитын явцад сарын хугацаанд цахим хэлбэрээр нийгмийн даатгалын талаар санал асуулга авахад нийт 9,423 иргэн хамрагдсан байна. Санал асуулгын дүнг харуулбал:

Санал асуулга: ҮОМШӨДС-аас тэтгэмж авахад хүндрэл, бэрхшээл гарч байсан уу?

Дүрслэл 18: ҮОМШӨДС-аас тэтгэмж авахад гарч буй асуудал



Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчинд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт болон мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалтад ороогүйгээс тус сангаас тэтгэмж авч чадаагүй тохиолдол гарч байгаа нь жагсаалтыг бодит нөхцөл байдалтай нийцүүлэх шаардлага байгааг харуулж байна.

Тэтгэвэртэй холбоотой зарим шийдвэрүүд даатгалын сан 7.3 их наяд төгрөгөөр буурахад нөлөөлсөн байна

2.102. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд тэтгэврийн даатгалын шимтгэлийг даатгуулагч болон ажил олгогч тус бүр 8.5 хувиар төлөхөөр заасан байна. Тус сангийн орлого зарлагын мэдээллийг харуулав.

Хүснэгт 39: Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага /сая төгрөг/

Үзүүлэлт		2020	2021	2022	2023
Орлого	Төлөвлөгөө	1,557,944.5	2,059,001.2	2,783,118.9	3,566,228.9
	Гүйцэтгэл	1,595,369.8	2,360,740.4	3,013,194.3	3,620,203.0
Зөрүү (+илүү; -дутуу)		- 37,425.3	- 301,739.1	- 230,075.4	- 53,974.0
Зарлага	Төлөвлөгөө	2,194,662.5	2,332,608.6	3,144,702.1	3,775,998.3
	Гүйцэтгэл	2,174,916.9	2,300,641.3	3,119,594.1	3,653,519.7
Зөрүү (+дутуу; -илүү)		19,745.6	31,967.2	25,108.0	122,478.6
Сангуудын	Ашиг		60,099.0		
	Цэвэр алдагдал	- 579,547.1		- 106,399.8	- 33,316.7

Эх сурвалж: НДЕГ

2.103. Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал буурч байгаа хэдий ч санг удирдах хэтийн тооцоололгүй, эрсдэлийг хэрхэн удирдах нь тодорхойгүй байна.

2.104. Монгол Улсын Засгийн газар НДС-аас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр 2020-2024 оны хооронд нийт 5 удаагийн тогтоол шийдвэр гаргасан нь тэтгэврийн даатгалын санд 2,268.8 тэрбум төгрөгийн ачаалал үзүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 40: Тэтгэвэр нэмэгдүүлэхтэй холбоотой шийдвэр, санхүүжилт /тэрбум төгрөг/

Д/д		Хууль тогтоомж	Тогтоолын огноо	Тухайн жилд зарцуулах хөрөнгө	Жилд зарцуулах хөрөнгө
1	2020	ЗГ-24	2020.01.22	150.6	164.3
2		Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хууль	2019.11.13	21.6	21.6
3	2022	ЗГ-63	2022.02.01	637.4	695.2
4	2023	ЗГ-238	2023.06.21	200.1	400.3
5		ЗГ-239	2023.06.21	194.4	388.7
6	2024	ЗГ-120	2024.03.20	449.0	598.7
Нийт					2,268.8

Эх сурвалж: НДЕГ

2.105. Засгийн газраас баталсан дээрх тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдэж өгөөгүй байна. Мөн УИХ-аас баталсан холбогдох хуулиуд тэтгэврийн даатгалын санд дараах байдлаар нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 41: Тэтгэвэртэй холбоотой гарсан шийдвэр, түүний үр нөлөө /сая төгрөг/

№	Хууль, хуулийн зүйл, заалт	Сангийн орлого		Сангийн зарлага		Алдагдал
		Хүний тоо (мян.хүн)	Хөрөнгийн хэмжээ	Хүний тоо (мян.хүн)	Хөрөнгийн хэмжээ	
1	Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нөхөн тооцох тухай хууль, 2012 он	607.8	37,947.3	324.1	1,898,669.2	1,860,721.9

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

2	Эдийн засгийн ил тод байдлын тухай хууль, 2015 он	16.6	15,572.0			
3	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль, 2020 он	34.4	76,367.4	20.6	205,711.6	129,344.2
4	Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хууль, 2019 он (50.0 мян.төг)			35.9	81,670.3	81,670.3
5	Нийгмийн даатгалын хуулиудын нэмэлт, өөрчлөлт	Шимтгэлийн хувь хэмжээг бууруулсан, (2008 онд 5 хувь)				2,432,000.0
6		Шимтгэлийн хувь хэмжээг бууруулсан, (2020 онд 2 хувь)				308,400.0
7		Малчдын тэтгэвэрт гарах насыг наашлуулсан (5 жил), 2023 он		32.2	167,093.8	167,093.8
8		Эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацааг хүүхдийн тоогоор нэмэгдүүлсэн, 2020 он (1.6 жил)		41.2	72,686.2	72,686.2
Нийт			129,886.7			5,051,916.4

Эх сурвалж: НДЕГ

2.106. Тэтгэврийг нөхөн тооцох, шимтгэлийн хувь хэмжээг бууруулах зэрэг гэнэтийн шийдвэрүүд нь тус сангийн алдагдлыг нэмэгдүүлж 5.0 их наядад хүргэсэн байна.

2.107. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн дагуу аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст нийтдээ 4,165 ажил олгогч 61.9 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлс түүнтэй адилтгах орлогоо ил болгож, 16,686 даатгуулагчийн 15.6 тэрбум төгрөгийн НДШ төлж, 7.7 тэрбум төгрөгийн алдангиас чөлөөлөгдсөн байна.

2.108. Дээрх 4165 ажил олгогчийн 623 нь нийгмийн даатгалын байгууллагад шинээр бүртгүүлсэн ба тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Энэ хуулийн 6.1-д заасан хувь хүн, хуулийн этгээдэд холбогдох мэдээлэл, тэдний мэдүүлсэн санхүүгийн болон албан татварын, нийгмийн даатгалын шимтгэлийн шинээр гаргасан тайлан, нөхөн мэдүүлсэн гаалийн мэдүүлэгт тус тус тусгасан албан татвар ногдох орлого, орлогоос бусад албан татвар ногдох зүйл, нийгмийн даатгалын шимтгэл ногдох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, тэдгээрийн эх үүсвэр, хэмжээ, үнэ, өртгийг нууцлах бөгөөд нотлох баримт болгон ашиглахыг хориглоно” гэж заасан тул нийт тэтгэврийн санд ямар хэмжээний ачаалал үзүүлж байгааг тодорхойлох боломжгүй байна.

2.109. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа нийт иргэдийн дунджаар 81.2 хувь нь өндөр насны тэтгэвэр авч байгаа иргэд байна. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд заасан хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр авч байгаа иргэдийн тэтгэврийг улсын төсвөөс олгож байна. Үүнд:

Хүснэгт 42: Тэтгэвэр авагчдын тоо

Үзүүлэлт	2020	2021	2022	2023
НД-ын сангаас тэтгэвэр авагч	418,011	435,800	453,928	465,089

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

Өндөр насны тэтгэвэр авагчид	332,875	353,238	372,029	382,755
Тахир дутуугийн	65,904	63,049	62,223	62,511
Тэжээгчээ алдсаны	19,232	19,513	19,676	19,823
Цэргийн албан хаагчийн тэтгэвэр	19,064	19,693	20,708	21,266

Эх сурвалж: НДЕГ

Хүснэгт 43: Тэтгэвэрт зарцуулсан хөрөнгийн дүн /сая төгрөг/

Үзүүлэлт	2020	2021	2022	2023
Зарцуулсан хөрөнгө	1,997,252.2	2,114,350.5	2,828,362.8	3,342,475.4
Өндөр насны тэтгэвэр авагчид	1,663,904.2	1,789,629.8	2,408,000.9	2,887,231.4
Тахир дутуугийн	255,803.4	247,660.2	316,677.4	341,829.7
Тэжээгчээ алдсаны	77,544.6	77,060.5	103,684.5	113,414.3
Цэргийн тэтгэвэр	153,771.6	162,738.1	201,801.0	273,058.2

Эх сурвалж: НДЕГ

Тэтгэврийн нөөц сан, мөнгөжүүлсэн орлогын талаарх асуудал

2.110. Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансыг үе шаттай мөнгөжүүлж, мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байхаар Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар хуульчилсан.

2.111. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т “Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байна” гэж заасан байна.

2.112. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т Тэтгэврийн нөөц сан дараах эх үүсвэрээр бүрдэхийг хуульчилсан байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн ажил олгогч, даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийн эх үүсвэр;
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу улсын төсөвт шилжүүлсэн орлогоос Засгийн газрын тогтоосон хэмжээгээр;
- Улсын төсвөөс олгох бусад орлого

2.113. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн ажил олгогч, даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн явц 2024 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 212.2 тэрбум төгрөгийг тэтгэврийн нөөц санд байршуулсан байна.

2.114. Дээрх мөнгөжүүлсэн орлогыг хуульд зааснаар дараах байдлаар хөрөнгө оруулж болохоор болсон байна. Үүнд:

- Засгийн газрын үнэт цаас;
- Монгол банкны үнэт цаас;
- Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж;
- Арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламж.
- Тухайлсан хуулиар зохицуулсан эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн санхүүжилтэд

2.115. Эдгээр санхүүгийн хэрэгсэлд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 9.6-д заасны дагуу 2030 оноос хөрөнгө оруулахаар байна.

Тэтгэмжийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг үр ашигтай удирдах шаардлагатай байна

2.116. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд тэтгэмжийн даатгалын шимтгэлийг даатгуулагч 0.8, ажил олгогч 1 хувиар төлөхөөр заасан байна. Тус сангийн орлого, зарлагын мэдээллийг харуулав.

Хүснэгт 44: Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага /сая төгрөг/

Үзүүлэлт	2020	2021	2022	2023
Орлого	111,393.9	180,122.2	236,919.2	305,979.7
Зарлага: үүнээс	147,740.8	172,751.9	175,127.9	217,482.3
Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны	20,228.4	30,379.6	27,429.3	32,637.2
Жирэмсэн болон амаржсаны	109,897.9	119,324.9	121,039.1	147,691.0
Оршуулгын	12,885.3	16,221.0	14,219.5	28,298.4
Зөрүү	-36,346.9	7,370.3	61,791.3	88,497.4

Эх сурвалж: НДЕГ

2.117. Дээрх үзүүлэлтээс харахад сүүлийн жилүүдэд тус сангийн үлдэгдэл өссөн байна. Энэ нь тус сангаас тэтгэмж авагч иргэдийн тоо жилээс жилд буурч байгаатай холбоотой байна. Тус сангаас тэтгэмж авсан иргэдийн тоог харуулбал:

Дүрслэл 19: Тэтгэмж авсан иргэдийн тоо, төрлөөр




Эх сурвалж: НДЕГ

2.118. Тус сангийн чөлөөт үлдэгдэл жилээс жилд өсөж байгаа бөгөөд уг хөрөнгийг үр ашигтай удирдаж, санхүүгийн хэрэгсэлд ашиглах шаардлагатай байна.

2.119. Аудитын явцад сарын хугацаанд цахим хэлбэрээр нийгмийн даатгалын талаар санал асуулга авахад нийт 9,423 иргэн хамрагдсан байна. Санал асуулгын дүнг харуулбал:

Санал асуулга: ХЧТА-ны тэтгэмж авахад хүндрэл, бэрхшээл гарч байсан уу?

Дүрслэл 20: ХЧТА-ны тэтгэмж авахад гарч буй асуудал



Ажил олгогч НДШ-ийг НДС-д хугацаанд нь төлөөгүйгээс ажилтан хохирох тохиолдол гарч байна.

ЭМДС-ийн өр төлбөр 182.5 тэрбум төгрөгт хүрсэн байна

2.120. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д даатгуулагчийн төрлөөс хамааран ЭМДШ-ийг 1, 2, 4 хувиас доошгүй байдлаар жил бүр ЗГ батлахаар заасан байна. Үүний дагуу ЗГ-аас жил бүр ЭМДШ-ийн хувь хэмжээг баталсан байна.

2.121. Монгол Улсын Төсвийн тухай хуулиар жил бүр улсын төсвөөс болон гадаадын зээл тусламжийн хүрээнд эрүүл мэндийн салбарт оруулах хөрөнгө оруулалт, урсгал төсвийн хэмжээг ЭМС-ын багцын төсөвт, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого болон төр хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг ЭМД-ын сангийн төсөвт тус тус баталдаг байна.

2.122. ЭМДС-ийн орлого, зарлагын гүйцэтгэлийг харуулав.

Хүснэгт 45: ЭМДС-ын орлого, зарлага /сая төгрөг/

№	Төсвийн үзүүлэлт	2021	2022	2023
Батлагдсан төсөв орлого		951,266.50	1,450,723.50	1,603,474.70
1	Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл	388,469.02	487,150.00	616,566.51
2	Төрөөс ЭМД-ын шимтгэл хариуцах иргэдийн шимтгэл	83,951.30	163,708.63	228,117.40
3	Төр хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт	496,465.20	540,429.88	687,445.30
4	Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	17,001.30	25,171.10	29,391.70
5	Бусад орлого	10,065.51	2,615.44	2,288.78
6	Нэмэлт санхүүжилт	73,500.00	295,335.14	20,000.00
Орлогын гүйцэтгэл		1,069,452.33	1,514,410.19	1,583,809.69
Батлагдсан төсөв зарлага		1,210,702.30	1,481,369.20	1,603,474.70
1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт	1,339,250.68	1,141,970.13	1,615,339.72
	Үүнээс: Ковидын тусламж, үйлчилгээнд	543,036.00	126,236.40	-
2	Эмийн үнийн хөнгөлөлт	68,948.75	80,758.15	99,506.51
3	Нийгмийн даатгалын байгууллагад олгох	1,100.00	1,100.00	-
4	Үйл ажиллагааны урсгал зардал	7,537.70	13,259.50	10,285.82
5	Эрсдэлийн сан	-	40,000.00	40,000.00
6	Бусад	51,762.13	232.56	313.94

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

7	Нэмэлт санхүүжилт Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	73,893.11	295,335.10	20,000.00
Зарлагын гүйцэтгэл		1,542,492.37	1,572,655.44	1,785,445.99

Эх сурвалж: ЭМДЕГ

2.123. 2023 оны байдлаар ЭМДС-ийн нийт орлогын 43.3 хувийг төр хариуцах тусламж, үйлчилгээ, 15.8 хувийг төр хариуцах иргэдийн шимтгэл, 38.9 хувийг ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэлээс тус тус бүрдүүлжээ. ЭМДС-ийн зарлагын 91.5 хувийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал эзэлж байгаа бол үйл ажиллагааны зардал нь 0.57 хувийг эзэлж байна.

2.124. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д ““Эрүүл мэндийн даатгал” гэж төр, иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж, эрүүл мэндийн даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг” гэж заасан ч ЭМДС-нд иргэдийн төлсөн шимтгэлээс Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд зарцуулж байна. Энэ нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Агентлагийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

2.125. ЭМД-д даатгуулсан болон эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан иргэдийн мэдээллийг харуулав.

Хүснэгт 46: ЭМД-д даатгуулсан болон үйлчилгээ авсан иргэдийн тоо

Төрөл	2021	2022	2023
Даатгуулсан иргэдийн тоо			
Шимтгэлийг ажил олгогч хариуцан төлөх иргэдийн тоо	565,910	749,326	788,986
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн;	121,965	133,921	145,867
Малчин;	51,314	51,988	57,117
Гадаадын иргэн, харьяалалгүй хүн;	536	567	667
0-18 насны хүүхэд;	1,186,573	1,312,073	1,329,131
Тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн;	581,623	561,008	538,558
Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;	439,412	268,884	263,645
Хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/;	81,821	97,033	86,357
Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч;	13,518	14,312	18,815
Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч;	9,418	6,809	6,021
Ял эдэлж байгаа ялтан;	4,997	4,581	5,055
Нийт даатгуулагчийн тоо	3,057,086	3,200,502	3,240,219
Эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан иргэдийн тоо			
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан иргэний тоо	1,783,580	2,011,541	2,671,734
Анхан шатны тусламж, үйлчилгээ	289,130	360,466	568,744
Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	1,413,584	1,738,671	1,973,676
Амбулатори	1,106,745	1,404,034	1,673,865
Өдрийн эмчилгээ	25,979	53,512	86,942
Хэвтүүлэн эмчлэх	304,128	527,906	543,798
Уламжлалт анагаах ухаан	38,870	115,425	188,275
Сэргээн засах	59,479	156,218	183,066
Түргэн тусламж	102,673	277,033	303,365
Яаралтай тусламж	239,422	525,666	591,950

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

Эмийн үнийн хөнгөлөлт	508,837	572,568	645,852
Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг	97,166	147,423	357,387

Эх сурвалж: ЭМДЕГ

2.126. Дээрх үзүүлэлтээс харахад ЭМД-д даатгуулсан нийт иргэдийн дунджаар 67.8 хувьтай тэнцэх хэмжээний иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч байна.

2.127. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч байгаа иргэдийг даатгуулагчийн төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 47: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч байгаа иргэдийн тоо, үйлчилгээний мэдээлэл /сая төгрөг/

Даатгуулагчийн төрөл	Даатгуулагчийн тоо		Үйлчилгээний тоо		Үйлчилгээний дүн	
Бүгд	3,122,575	100.0%	19 431 658	100.0%	1,409,109.2	100.0%
Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн	550,387	15.9%	7 879 375	40.5%	642,097.5	45.6%
0-18 насны хүүхэд	1,267,362	36.6%	4 211 570	21.7%	248,964.1	17.7%
Амьжиргааны түвшин доогуур иргэн	438,131	12.6%	1 793 799	9.2%	117,975.9	8.4%
Бусад	1,210,118	34.9%	5 546 914	28.5%	400,071.7	28.4%

Эх сурвалж: ЭМДЕГ

2.128. Дээрх үзүүлэлтээс харахад “Тэтгэврээс өөр орлогогүй иргэн, 0-18 насны хүүхэд, амьжиргааны түвшин доогуур иргэд” нь нийт даатгуулагчийн 65.1, нийт үйлчилгээний 71.4, нийт санхүүжилтийн 71.7 хувийг эзэлж байна.

2.129. Эдгээр иргэд нь ЭМДТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2.3-т заасны дагуу ЭМДШ-ээ улсын төсвөөс төлүүлдэг байна. Улсын төсвөөс ЭМДШ-ийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 1-2 хувиар тооцон ЭМДС-д төлдөг байна.

Тодруулбал: Улсын төсвөөс ЭМДШ-ийг төлдөг (сард 6,600-13,200 төгрөг төлдөг) иргэд эрүүл мэндийн байгууллагаар хамгийн их үйлчлүүлж, ЭМДС-ийн хөрөнгийн дийлэнх нь эдгээр иргэдэд зарцуулагдаж байна.

2.130. ЭМДС-ийн өрийн мэдээллийг харуулав.

Хүснэгт 48: ЭМДС-ийн өрийн ангилал /сая төгрөг/

№	ЭМДС-н өрийн ангилал	2018	2019	2020	2021	2022	2023	2024.08
1	Улсын Эмнэлгийн үйлчилгээ	58.2	55.4	55.4	50,949.6	60,401.2	174,829.1	136,723.8
2	Хувийн эмнэлэг	21.7	-	-	12,339.8	-	17,962.8	7,438.4
3	Сувилал	-	12.1	-	2,811.8	-	474.3	1,037.8
4	Эм	12.0	22.3	5.9	7,233.2	0.2	5,708.6	-
5	Элэг бүтэн С эм	27.7	-	-	236.6	-	-	-
6	Элэг бүтэн С тоолох	1,946.5	-	-	452.2	-	-	-
7	Лаборатори-Урьдчилан сэргийлэх	3.0	3.3	-	1,096.3	-	-	-
8	Элэг бүтэн В, С эрт илрүүлэг	-	-	-	11.7	-	-	-

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

9	Элэг бүтэн В, С баталгаажуулах шинжилгээ	-	-	-	0.2	-	-	-
10	Өрхийн эмнэлэг	-	-	-	23.2	0.4	4,248.2	5,276.7
11	Элэг бүтэн В эм	1.2	-	-	312.3	-	-	-
12	Байгууллагад төлөх өглөг	-	-	-	14,982.2	-	308.5	-
14	СЭМТ	-	10.2	-	0.7	0.1	2,511.5	-
15	Гемодиализийн өглөг	-	-	-	2,260.7	-	-	-
16	Ковид-19 хэвтэн өглөг	-	-	-	126,499.1	-	-	-
17	Ковид-19 вакцин өглөг	-	-	-	3,147.2	-	-	-
18	Ковид-19 өрхийн санхүүжилтийн өглөг	-	-	-	22,643.3	-	-	-
19	Ковид-19 сорьц авах ПГУ-5000	-	-	-	1,808.5	-	-	-
20	Ковид-19 сорьц шинжлэх-50000	-	-	-	17,730.7	-	-	-
21	Өрхийн ЭМТ нэг иргэний санхүүжилт	-	-	-	-	-	1,754.7	-
22	Сумын ЭМТ нэг иргэний санхүүжилт	-	-	-	-	10.3	629.1	-
23	Төр хариуцах эм	-	-	-	-	-	1,864.3	4,600.0
24	Эрт илрүүлэг	-	-	-	-	96.6	5,824.5	1,812.8
25	Сумын ЭМТ хэвтэн ТҮ	-	-	-	-	38.8	2,193.6	19,429.2
26	Бусад	2,554.4	2,554.1	2,554.4	125.8	18.5	12.4	6,262.6
Нийт дүн		4,624.8	2,657.3	2,615.7	264,665.0	60,565.9	218,321.7	182,581.3

Эх сурвалж: ЭМДЕГ

2.131. ЭМДС-ийн тэнцэл 2021 оноос хойш алдагдаж 2024 оны 08 сарын байдлаар 182.5 тэрбум төгрөгт хүрсэнд дараах хүчин зүйлүүд нөлөөлсөн байна. Үүнд:

- Дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахлын үеийн өвчлөлийг Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар тарифыг баталж ЭМДС-аас санхүүжүүлсэн,
- 2022 онд “Ковид-19” цар тахлын Омикрон хувилбарын дэгдэлт улирлын томуугийн өвчлөл хүндрэлтэй байсан тул хэвтэн эмчлүүлэгчдийн ор хоногийн тоо хэмжээ өссөн.

2.132. ЭМД-ын байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын харилцагч байгууллагууддаа үүсгэсэн өр төлбөр болон ЭМДС-аас авах авлагын мэдээллийг 2024 оны 9 дүгээр сарын байдлаар харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 49: Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлага /сая.төгрөг/

Цалин хөлс, урамшуулал	НДШ-ийн өр	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	Тогтмол зардал	Бусад зардал	Нийт өр төлбөрийн дүн	ЭМДС-аас авах авлага	Зөрүү
------------------------	------------	---------------------------------	----------------	--------------	-----------------------	----------------------	-------

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

22,953.4	23,981.0	130,274.4	216.6	14,421.6	191,847.0	122,741.5	69,105.47
----------	----------	-----------	-------	----------	------------------	------------------	------------------

Эх сурвалж: ЭМЯ

2.133. Дээрх үзүүлэлтээс харахад эрүүл мэндийн байгууллагууд ЭМДС-аас авах авлагаа бүрэн авсан ч нийт **69.1** тэрбум төгрөгийн өртэй үлдэж байна.

2.134. Нөгөө талаар эрүүл мэндийн байгууллагууд эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 130.2 тэрбум төгрөгийн өртэй байгаа нь цаашид эм, эмнэлгийн хэрэгсэл тасалдах эрсдэл үүсгээд байна. Тодруулбал: Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгчид **“өрөө барагдуулсны дараа нийлүүлэлт хийнэ”** гэсэн шаардлагыг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн байна.

2.135. Мөн НДШ-ийн 23.9 тэрбумын өртэй байгаа нь эрүүл мэндийн байгууллагуудын албан хаагчдын нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл тасалдаж үйлчилгээ авч чадахгүй байх зэрэг хүндрэлүүд үүссэн байна.

2.136. Эрүүл мэндийн байгууллагуудаас түүвэрлэн үйл ажиллагаатай нь танилцаж, өр авлагын мэдээллийг харахад дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 50: Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлага /сая төгрөг/

Эрүүл мэндийн байгууллагын нэр	ЭМДС-аас авах авлага	Нийт өр төлбөрийн дүн	Үүнээс		
			Цалин хөлс, урамшуулал	НДШ-ийн өр	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл
Арьсны өвчин судлалын үндэсний төв	154.1	741.8	400.6	263.6	65.8
Геронтологийн төв	11.1	-	-	-	-
Гэмтэл, согог судлалын үндэсний төв	24,216.4	17,726.6	1,078.2	1,734.9	11,300.2
Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	1,557.3	415.9	271.8	100.0	42.8
Уламжлалт анагаах ухааны төв	-	115.8	71.3	44.4	-
Улсын гуравдугаар төв эмнэлэг	18,800.2	12,985.7	-	-	12,544.1
Улсын нэгдүгээр төв эмнэлэг	11,207.7	18,050.5	-	-	17,501.1
Улсын хоёрдугаар төв эмнэлэг	1,942.2	14,759.9	115.1	-	13,858.1
Хавдар судлалын үндэсний төв	25,586.3	14,811.5	605.5	802.1	12,959.3
Халдварт өвчин судлалын үндэсний төв	-	9,880.6	735.5	646.0	8,076.3
Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	3,889.2	12,835.4	1,908.0	3,564.4	6,846.7
Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёр	2,938.6	3,227.8	-	-	2,977.3
Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв	225.2	2,386.2	523.1	746.9	509.4
Өргөө амаржих газар	-	5,365.8	2,334.6	1,215.4	1,596.1
Амгалан амаржих газар	877.2	3,497.7	-	2,607.2	890.5
СХД-ийн Нэгдсэн эмнэлэг	6,207.2	6,458.0	1,600.8	683.0	3,956.9
СХД-ийн Эрүүл мэндийн төв	773.2	1,830.5	297.3	351.0	978.4
ЧД-ийн Эрүүл мэндийн төв	1,016.7	3,035.9	870.8	495.6	1,487.6

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

ХУД-ийн Эрүүл мэндийн төв	799.4	3,307.9	300.8	699.0	2,308.0
Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг	579.7	424.5	40.1	75.7	272.6
Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв	69.4	0.3	-	-	-

Эх сурвалж: ЭМЯ, эрүүл мэндийн байгууллагууд

2.137. Эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлэлтээс харахад дараах асуудлууд байна. Тухайлбал:

- Зарим төрөлжсөн эмнэлгүүд (Гэмтэл, согог судлалын үндэсний төв, Гуравдугаар эмнэлэг гэх мэт) ЭМДС-аас авах авлагаар өрөө барагдуулах боломжтой бол дүүргийн эмнэлгүүд ЭМДС-аас авлагаа бүрэн авсан ч өрөө барагдуулах боломжгүй байна. Энэ нь нэг талаар ЭМД-ын байгууллага эмнэлгүүдийн хүчин чадалд бус өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн гэрээлэлт хийдэг, нөгөө талаар шатлалын эмнэлгүүдийн үзүүлэх үйлчилгээг заагласан шалгуур байхгүйгээс иргэд дүүргийн бус төрөлжсөн эмнэлгийг сонгон үйлчлүүлэх хандлага илүү байгаатай холбоотой байна.

Хүснэгт 51: ЭМД-ын байгууллагаас ЭМБ-дад хуваарилсан ЭМТҮ-ний тоо, санхүүжилтийн дүн /сая төгрөг/

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	2023		2024	
		ЭМТҮ-ний тоо	Санхүүжүүлсэн дүн	ЭМТҮ-ний тоо	Санхүүжүүлсэн дүн
1	Нийт	10,864,438	1,237,269	4,137,819	1,353,482
2	Төрийн	9,601,410	977,019	3,508,239	1,065,259
3	Дүүргийн эрүүл мэндийн байгууллага	1,367,338	59,871	431,297	52,260
4	Баянгол ЭМТ	338,666	20,008	91,652	17,735
5	Баянзүрх ЭМТ	462,511	14,098	137,045	11,054
6	Чингэлтэй ЭМТ	307,261	12,447	118,006	12,343
7	Сонгинохайрхан ЭМТ	258,900	13,317	84,594	11,129
8	Лавлагаа шатлалын эмнэлэг	1,076,753	249,872	325,102	260,040
9	Улсын гуравдугаар төв эмнэлэг	223,317	72,277	66,449	75,069
10	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	375,214	75,424	98,839	78,314
11	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	203,272	36,772	60,321	39,721
12	Гэмтэл согог судлалын үндэсний төв	274,950	65,399	99,493	66,937
13	Бусад	7,157,319	667,277	2,751,840	752,959
14	Хувийн	1,263,028	260,249	629,580	288,223
15	Бриллиант эмнэлэг	51,672	16,518	14,449	28,671
16	Рехамед эмнэлэг	27,809	15,741	10,232	15,334
17	Баянзүрх эмнэлэг	89,283	11,973	35,393	11,693
18	ЭМЖЖ эмнэлэг	201,598	9,695	87,792	11,507
19	Медвик эмнэлэг	80,829	9,458	46,404	9,668
20	Бусад	811,837	196,866	435,310	211,350

Энэ үзүүлэлтээс харахад лавлагаа шатлал болон хувийн эмнэлгүүдэд илүү санхүүжилтийн дүнтэй ЭМТҮ-г хуваарилсан байна.

Мөн ЭМД-ын байгууллага эрүүл мэндийн байгууллагуудын нэхэмжилсэн дүнгээс хасалт хийж байгаа нь өрийн хэмжээнд тодорхой хувиар нөлөөлж байна. Тодруулбал: ЭМД-ын байгууллага эрүүл мэндийн байгууллагуудын өвчний түүхэд баталсан шалгуурын дагуу хяналт хийн шаардлага хангаагүй өвчний түүхийн санхүүжилтийг хасаж байна.

Дүрслэл 21: ЭМБ-дад олгосон санхүүжилтийн гүйцэтгэл /сая төгрөг/




Дээрх графикаас харахад улсын эмнэлгийн нэхэмжилсэн мөнгөн дүнгийн хасагдал 7 хувьтай байгаа бол хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хасагдал 2.41 хувиар бага буюу нийт нэхэмжилсэн мөнгөн дүнгээс 4.65 хувийн хасагдалтай байна.

Эх сурвалж: ЭМДЕГ

- Өвчний түүхэд хяналт хийж байгаа шалгуур үзүүлэлт нь “бодит нөхцөл байдалтай нийцэхгүй байна” гэсэн үндэслэлээр ЭМД-ын байгууллага, эрүүл мэндийн байгууллагын хооронд үл ойлголцол бий болсон байна. Иймд шалгуур үзүүлэлтийг шинэчлэх шаардлагатай байна.
- Зарим төрөлжсөн эмнэлгүүдийн (хүүхэд, төрөх зэрэг нэр төрлөөр төрөлжсөн) тухайд үйлчлүүлэгчийн онцлогоос хамаарч байгаа тул өрөө барагдуулах боломжгүй нөхцөл байдал үүсэж байна.

2.138. Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь өөрийн харьяаны баг, хорооны иргэдийн тоогоор улсын төсвөөс, иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр ЭМДС-аас санхүүжилт авч байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн авсан санхүүжилтийн мэдээллийг харуулав.

Дүрслэл 22: ӨЭМТ-ийн санхүүжилт /сая төгрөг/



Өрхийн эрүүл мэндийн төв нь төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний дагуу гүйцэтгэж байгаа нөхөрлөл бөгөөд ажил гүйцэтгэх гэрээнд төрөөс авч байгаа санхүүжилтийн зарцуулалтад төрийн аудитын байгууллага аудит хийх асуудлыг тусгаж өгөөгүйгээс зарим төв төрийн аудитад хамрагдахгүй байх нөхцөл үүссэн байна.

Эх сурвалж: ЭМДЕГ


Эрүүл мэндийн байгууллагыг гүйцэтгэлээр санхүүжүүлэх тогтолцоог аудитын багийн уулзсан бүх эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл дэмжиж байсан. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарт анхаарч өрсөлдөх чадварыг идэвхжүүлсэн. Санхүүжилтийн зөв тогтолцоо бий болвол эмнэлгийн ажилчдын цалин хөлс нэмэгдэх боломж бий болсон байна. Гэхдээ эрүүл мэндийн байгууллагыг гүйцэтгэлээр санхүүжүүлж байгаа үйл явцад нөхцөл байдлын судалгаа хийж, зохион байгуулалт, тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлт хийх зайлшгүй шаардлагатай байна.

Аудитын баг эрүүл мэндийн байгууллагуудтай хийсэн уулзалтаар эрүүл мэндийн даатгал болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой яригдсан асуудлыг хавсралт №4-өөр оруулав.

2.139. Аудитын явцад сарын хугацаанд цахим хэлбэрээр нийгмийн даатгалын талаар санал асуулга авахад нийт 9,423 иргэн хамрагдсан байна. Санал асуулгын дүнг харуулбал:

Санал асуулга: Эрүүл мэндийн даатгалд шимтгэл төлснөөр та шаардлагатай тусламж үйлчилгээ хангалттай авч чадаж байна уу?

Дүрслэл 23: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад үүсэж буй асуудал



Иргэд шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад эмнэлгийн хүртээмж, бусад нөхцөл байдлаас шалтгаалан нэмэлт төлбөр төлөх нөхцөл үүсэж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын асуудлаар “Амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх” урт хугацааны зорилт тавьсан ч дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээтэй нийцээгүй, уг зорилтод бүрэн чиглээгүй, голчлон тэтгэврийн шинэчлэл хийх үйл явцад чиглэсэн байна.
2. Хууль тогтоомжид хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгохоор тусгасан заалтууд болон тэтгэврийн хэмжээг нэмсэн ч шаардлагатай санхүүжилтийг шийдээгүй, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх, хувь хэмжээг бууруулах, тэтгэвэрт гарах нөхцөлийг бууруулах зэрэг гэнэтийн шийдвэрүүд гаргасан нь иргэдэд таатай хэдий ч нийгмийн даатгалын санд ачаалал үүсгэж, **7.3** их наяд төгрөгийн алдагдалд оруулсан байна. Энэ нь тус сангийн хөрөнгийг урт хугацаанд зохистой түвшинд байлгах тооцоолол, стратеги байхгүйг харуулж байна.
3. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулахдаа зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг оновчтой тогтоож, харгалзаж үзээгүйгээс нийт **150.0** тэрбум төгрөг банкнуудын дампуурлаас алдагдсан, Чингисхаан банканд байршуулсан **126.9** тэрбум төгрөгийн авлага хүлээлтийн байдалтай, Монгол банкны бодлогын хүүгээс бага хувиар байршуулснаас **12.2** тэрбум төгрөг, хадгаламж хэлбэрээр байршуулаагүйгээс **215.8** тэрбум төгрөгийн хүүгийн орлого олох боломж алдсан, бусад санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шаардлагатай зохицуулалтыг хийгээгүй зэрэг нь сангийн хөрөнгийн зохистой удирдлага, бодлого байхгүйг харуулж байна.
4. Аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулахад үр дүнтэй арга хэмжээ аваагүйгээс **0.5** тэрбум төгрөгийн авлагыг хүчингүй болгосон, одоогийн байдлаар хуримтлагдсан өр **541.8** тэрбум төгрөгт хүрч нийт **448,434** даатгуулагч хохирох эрсдэлтэй байна.
5. Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны онцлог, хүчин чадал зэргийг харгалзан гүйцэтгэлээр санхүүжүүлэх болон улсын төсвөөс төлдөг эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн санхүүжилтийн асуудалд зохицуулалт шаардлагатай болсон байна. Зохицуулалт дутагдалтайгаас одоогийн байдлаар эрүүл мэндийн даатгалын сангийн өр **182.5** тэрбум төгрөгт хүрч цаашлаад эрүүл мэндийн байгууллагуудын өр **191.8** тэрбум төгрөг болж хэвийн үйл ажиллагаанд нь эрсдэл үүсэж болзошгүй байна.
6. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн алдагдлыг бууруулах талаар үр дүнтэй шийдэл гаргаагүй байгаа нь цаашид даатгуулагчийн ирээдүйн санхүүгийн эрсдэлээс хуваалцах боломжгүй болох эрсдэлтэй байна.
7. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэд ажиллах мэргэжлийн хороо, олон нийтийн хяналтын зөвлөлийг хууль хэрэгжиж эхэлснээс хойш 11 сарын дараа байгуулсан, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээний үр нөлөө болон даатгуулагчийн эрсдэлийг хуваалцаж чадаж байгааг судлах зэрэг бодлогын чиг үүрэг орхигдсон, цахим систем нь салбарын ажилтан болон даатгуулагч, ажил олгогчийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байгаа зэргээс тус салбарт нийгмийн

даатгалын үйл ажиллагааг оновчтой хэрэгжүүлэх удирдлагын тогтолцоо бүрдээгүй байна.

8. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь Нийгмийн даатгалын тухай хууль /хуучин нэрээр/-ийн 27 дугаар зүйл заасан Үндэсний зөвлөл байна гэж заасан нь тус зөвлөл Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс тусдаа байгуулагдаж, үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэслэлгүй, Эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас буюу даатгуулагчдын төлсөн шимтгэлийн орлогоос санхүүжүүлж байгаа нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан “Эрүүл мэндийн улмаас даатгуулагчид үүссэн санхүүгийн эрсдэлийг хуваалцах” гэсэн үндсэн зарчимд нийцэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Улсын Их Хуралд толилуулах нь:

1. Нийгмийн даатгалын асуудлаар шийдвэр гаргахдаа бусад салбарын хуулиудын уялдаа болон нийгмийн даатгалын санд үзүүлэх нөлөөллийн тооцоолол, хүндрэлийг харгалзан үзэж, шаардлагатай санхүүжилтийг бүрэн шийдвэрлэх,
2. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуультай уялдуулан өөрчлөлт хийн баталж, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн эрх зүйн чадамжийн талаарх асуудлыг шийдвэрлэх.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Эрүүл мэндийн яаманд:

1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх асуудлыг холбогдох газарт хандаж шийдвэрлүүлэх,
2. Эрүүл мэндийн даатгалын болон эрүүл мэндийн байгууллагуудад өр үүсгэж байгаа шалтгаан нөхцөлийг тодруулж, шаардлагатай зохицуулалт хийх.

Нийгмийн даатгалын ерөнхий газарт:

1. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахад тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэн сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх зохистой арга хэмжээ авч, санд үүсэх эрсдэлийг удирдах урт хугацааны тооцоолол, стратеги боловсруулан мөрдөж ажиллах,
2. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулахдаа зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг оновчтой тогтоож, Монгол банкны зарласан бодлогын хүүгээс бага хувиар байршуулахгүй байх тогтолцоо бий болгох,
3. Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй аж ахуйн нэгж, байгууллагын өрөө барагдуулахгүй байгаа асуудлын шалтгаан нөхцөлийг тодруулж, шаардлагатай арга хэмжээ авч даатгуулагчийн хүлээж буй эрсдэлийг бууруулах,
4. Нийгмийн даатгалын чиглэлээр баримталж буй бодлого, чиглэл, үйл ажиллагаанд нийцүүлэн салбар, нэгжүүдийн чиг үүргийг нарийвчлан тодорхойлж, шаардлагатай тогтолцоог бий болгох,
5. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар, Дотоод аудит, мониторингийн газрын ажилтнуудын хөгжлийн бодлого, түүний үр нөлөөг үнэлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх сургалтад хамруулах,
6. Нийгмийн даатгалын цахим системийг ашиглахтай холбоотой гарч байгаа хүндрэл, бэрхшээлийг албан хаагч, даатгуулагч, ажил олгогч бүрээр нарийвчлан гаргаж, шаардлагатай сайжруулалтыг хийх,
7. Нийгмийн даатгалын төв сангийн орлого, зарлагын гүйлгээнд улирал тутам дотоод аудит хийлгэж, үр дүнг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тайлагнах.

Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт:

1. Дампуурсан банкнуудтай холбоотой авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлж, холбогдох байгууллагуудад хандаж, эцэслэн шийдвэрлэх,

2. Холбогдох хуульд нийцүүлэн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөгч бүрийн шимтгэл төлөлтийн нарийвчилсан мэдээллийг солилцдог байх нөхцөлийг бүрдүүлж асуудлыг шийдвэрлэх.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт:

1. Эрүүл мэндийн даатгалын санд үүссэн өрийн шалтгаан нөхцөлийг тодруулж, шаардлагатай арга хэмжээ авах,
2. Эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ байгуулахдаа тухайн эмнэлгийн үндсэн чиглэл, хүчин чадал, нөөц боломжийг харгалзан үзэж, эмнэлгүүдийн ачааллыг жигдрүүлэхэд анхаарч ажиллах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн санал:



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.ЭНХБОЛД ТАНАА

Тайлангийн төсөлд санал хүргүүлэх тухай

Танай газрын 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 08/2141 дүгээр албан бичгээр ирүүлсэн "Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Тайлангийн төслийн 1 дүгээр бүлгийн 1.21 –ийн "2024 онд" гэснийг "2024 оны 9 дүгээр сарын байдлаар" гэж, "хөнгөлөлт эдэлсэн" гэдэг үгийг "шимтгэлийг төр болон тэтгэмжийн даатгалын сангаас хариуцсан" гэж;

2. Төслийн 1.22-ыг "Цэргийн тэтгэвэр тэтгэмжийг бодох, олгох ажлыг Нийгмийн даатгалын байгууллага гэрээгээр гүйцэтгэж байна." (энэ хүрээнд цэргийн тэтгэврийн асуудал хамаарахгүй гэж үзэж байгаа тул) гэж;

3. Төслийн 1.28-ын "1994" гэснийг "2024" гэж;

4. Төслийн 1.32-ыг Нийгмийн даатгалын тогтолцооны үр нөлөө хүснэгтийн "Иргэд дунджаар 20 жил орлогын 26 хувиар шимтгэл төлж" гэснийг "Даатгуулагч дунджаар 20 жил, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 17 хувиар (ажил олгогч 8.5 хувь, даатгуулагч өөрөө 8.5 хувь) шимтгэл төлж" гэж;

5. Тайлангийн төслийн Бүлэг 2-ын 2.88-ын хүснэгт 32-ын ар талын "Ажилгүйдлийн даатгалын сангийн орлогоосоо давсан зарлагыг хэрхэн нөхөх удирдах талаар зохицуулалт, бодлого байхгүй байна" гэснийг "Ажилгүйдлийн даатгалын сангийн орлогоосоо давсан зарлагыг нөхөх зорилгоор 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлэн эхэлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар тус санд ажил олгогчийн төлөх шимтгэлийг хэмжээг 0.3 хувиар (2023 онд ажилгүйдлийн даатгалын санд ажил олгогч 0.2, даатгуулагч 0.2 хувиар тус тус шимтгэл төлж байсан бол 2024 онд ажил олгогч 0.5, даатгуулагч 0.2 хувиар шимтгэл төлдөг болсон) нэмэгдүүлсэн байна" гэж тус тус өөрчлөх.

6. Тайлангийн төслийн 1 дүгээр бүлгийн 16-ын Хүснэгт 5-ыг засах; (Тухайлбал малчин 0.7 жил тэтгэвэр авдаг гэсэн агуулгын алдаа харагдаж байна)

7. Тайлангийн төслийн 70 дугаар хуудсан дахь “ДҮГНЭЛТ”-ийн 6 дахь хэсгийг зарчмын хувьд дараах үндэслэлээр хүлээн зөвшөөрөхгүй байна. Үүнд:

7.1. “Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах зарим нэгжийг байгуулаагүй” гэсэн дүгнэлтийн хүрээнд

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж байна. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо бүрэлдэж, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны “Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц батлах тухай” А/19 дүгээр тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод зохион байгуулалтын бүтэц, түүний дэргэдэх байгууллагуудыг баталж, батлагдсан бүтцийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газар, түүний дэргэдэх зөвлөл, төв, алба, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дотоод зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталж, албан тушаал, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргад үүрэг болгосон. Энэхүү тушаалын хавсралтаар “Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр” (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг баталсан.

Хөтөлбөрийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого”, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Засгийн газрын 2016 оны “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр тогтоол, 2017 оны “Агентлаг байгуулах тухай” 344 дүгээр тогтоол зэрэг хууль эрх зүйн баримт бичгийг үндэслэн Засгийн газрын 2016 оны “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 4 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн ерөнхий загвар”-ыг удирдлага болгон төрийн албаны залгамж чанар, хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн байдал болон мэргэшсэн төрийн албан хаагчдын туршлага, олон улсын туршлага, хөгжлийн чиг хандлага зэргийг харгалзан боловсруулсан.

Хөтөлбөрийн 2.4-т үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг, 2.5-д үйл ажиллагааны гол зорилтуудыг, 2.6-д үйл ажиллагааны зорилтуудыг, 3.1-д бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримталсан зарчмуудыг тодорхойлж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги болон бүтцийн ерөнхий

тогтолцооны загварыг үндэслэн агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг, албан хаагчдын ажлын байрны үндсэн чиг үүргийг тус тус тодорхойлсон. Эдгээр эрхзүйн баримт бичгийг үндэслэн чиг үүргийн дагуу хуваарилсан агентлагийн бүтцийн 7 нэгж, 5 хэлтэс, дэргэдэх 4 төв, зөвлөл, алба үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн "Шимтгэл хураалт, мэргэжил арга зүйн газар"-ыг шинээр байгуулан ажиллуулж байна. Иймд **"Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах зарим нэгжийг байгуулаагүй"** гэж дүгнэх үндэслэлгүй гэж үзэж байна.

Түүнчлэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35.17-д заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэд ажиллах эрсдэлийн удирдлага, актуар тооцоолол хийх, хөрөнгө оруулалт, аудитын орон тооны бус Мэргэжлийн хороог, мөн хуулийн 13.7-д заасны дагуу сангийн хөрөнгө оруулах үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил, арга зүйгээр хангах үүрэг бүхий орон тооны бус Олон нийтийн хяналтын зөвлөлийг тус тус байгуулаад байна.

7.2. "зарим нэгжүүдийн үйл ажиллагааны нарийвчилсан чиг үүргийг батлаагүй" гэсэн дүгнэлтийн хүрээнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны "Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэгжүүдийн чиг үүргийг шинэчлэн батлах тухай" А/23 дугаар тушаалаар дотоод нэгжийн чиг үүргийг батлан мөрдөж байсан.

2019 оноос эхлэн мөрдөж байгаа Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтад "албан тушаалын тодорхойлолт" гэж тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг баталгаажуулсан баримт бичгийг." гэж заасан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/19 дүгээр тушаалаар үүрэг болгосны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/53 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц орон тоог, А/41 дүгээр тушаалаар Мэдээллийн технологийн төвийн бүтэц орон тоог, А/44 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн бүтэц, орон тоог, А/51 дүгээр тушаалаар Аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог, А/52 дугаар тушаалаар Дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог тус тус шинэчлэн баталж, Нийгмийн даатгалын байгууллагын батлагдсан орон тоо (1485)-ноос төрийн захиргааны 1227 орон тоонд хамаарах 133 албан тушаалын тодорхойлолтод Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 208-215 дугаар тогтоолуудаар зөвшөөрөл өгсний дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны "Албан тушаалын тодорхойлолт батлах тухай" А/101-А/104 дүгээр тушаалуудаар эдгээр албан тушаалын тодорхойлолтыг батлан мөрдөж байна. Албан тушаалын тодорхойлолт бүрд харьяалагдах газар, нэгжийн чиг үүрэг тусгагдсан болно.

Төрийн албаны тухай хуулиар чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод батална гэж заасан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/19 дүгээр тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги,

зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-т агентлагийн зохион байгуулалтын бүтэц, нэгжийн үндсэн үүрэг, чиг үүргийг баталсан тул **“зарим нэгжүүдийн үйл ажиллагааны нарийвчилсан чиг үүргийг батлаагүй”** гэж дүгнэх үндэслэлгүй гэж үзэж байна.

7.3. “хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээний үр нөлөө болон даатгуулагчийн эрсдэлийг хуваалцаж чадаж байгааг судлах зэрэг бодлогын чиг үүрэг орхигдсон” гэсэн дүгнэлтийн хүрээнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт баталсны дагуу хөгжлийн бодлогын баримт бичиг тухайлбал, Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого 2015-2030 зэрэгт нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүргийг тус газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар, эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, санал боловсруулах чиг үүргийг Дотоод аудит, мониторингийн газар, нийгмийн даатгалын сан, үйл ажиллагаанд судалгаа шинжилгээ хийх, нийгмийн даатгалын сангийн дунд болон урт хугацааны хэтийн (актуар) тооцоолол хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх, санал боловсруулах чиг үүргийг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын Судалгаа, актуар тооцооллын хэлтэс тус тус хэрэгжүүлж байна.

Иймд **“хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээний үр нөлөө болон даатгуулагчийн эрсдэлийг хуваалцаж чадаж байгааг судлах зэрэг бодлогын чиг үүрэг орхигдсон”** гэж дүгнэх үндэслэлгүй гэж үзэж байна.

7.4. “шаардлагатай нэгжүүдэд сул орон тоог шийдээгүй” гэсэн дүгнэлтийн хүрээнд.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны “Нийгмийн даатгалын төв болон орон нутгийн байгууллагын орон тооны хязгаарыг батлах тухай” А/45 дугаар тушаалаар нийгмийн даатгалын байгууллагын орон тоог 1485-аар баталсан бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 1349 албан хаагч ажиллаж байна.

Тус газар нь Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбар зөвлөлд Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг болон Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-д тус тус заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын болон дүүргийн Нийгмийн даатгалын газруудын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 2024 оны 06 дугаар сараас хойш хугацаанд нийт 5 удаа хүргүүлж, сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулж байна.

Мөн аймгийн Нийгмийн даатгалын газрууд нь сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн аймаг дахь салбар зөвлөлд тухай бүр өгч сул орон тоог нөхөж байна.

Цалин хөлсний хэмжээ бага, орон нутгийн нэмэгдэл хөлс олгохгүй байсантай холбоотойгоор нийгмийн даатгалын байцаагчид аймаг, сумын Тамгын газарт болон төрийн өөр байгууллагад шилжин ажиллах хөдөлгөөн нэмэгдсэн. Харин 2024 оноос Засгийн газраас орон нутгийн нэмэгдэл хөлс олгохоор шийдвэрлэсэн, цалин, урамшууллын хэмжээ нэмэгдсэн, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгож байгаатай холбоотойгоор цалин хөлс, орлогын хэмжээ нэмэгдсэнээр аймаг, сумын байцаагчийн сул орон тоо нөхөгдөх боломж нэмэгдэж байна.

Нийт 17 аймгийн 31 суманд байцаагчгүй байна. Эдгээр сумын байцаагчийн ажлыг ойролцоо сумын байцаагч, аймгийн Нийгмийн даатгалын газрын мэргэжилтнүүд хавсран гүйцэтгэх, мөн 3 сумын байцаагчийн ажлыг бусад төрийн байгууллагын албан хаагчаар хавсран гүйцэтгүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч, нийгмийн даатгалын үйлчилгээг тухайн сумын иргэд, даатгуулагчдад тасралтгүй үзүүлж байна.

Нийгмийн даатгалын байгууллага нь төрийн албан хаагчийн сул орон тоог нөхөх ажлыг холбогдох хууль, журмын дагуу дээр дурдсанаар тогтоосон хугацаанд гүйцэтгэж ирсэн. Иймд **"шаардлагатай нэгжүүдэд сул орон тоог шийдээгүй"** гэж дүгнэх үндэслэлгүй гэж үзэж байна.

Төрийн албан хаагчийн сул орон тоог нөхөх асуудал нь зөвхөн тухайн байгууллагын асуудал бус, төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа, ажлын ачаалал, ажиллах орчин зэрэг асуудлуудыг хууль эрх зүйн хүрээнд цогцоор нь шийдвэрлэж шийдэгдэх асуудал юм.

7.5."цахим систем нь салбарын ажилтан болон даатгуулагч, ажил олгогчийн хэрэгцээ, шаардлагыг хангахгүй байгаа" гэсэн дүгнэлтийн хүрээнд

Энэхүү дүгнэлтийг түүврийн хэмжээ хэт бага буюу эх олонлог төлөөлөх чадвар бага судалгаанд үндэслэн гаргасан байна.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 50 гаруй байгууллага өндөр хурдны шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбогдсон. Төв, орон нутгийн 31 нэгжид нийт 57 сервер компьютер, 6 өгөгдөл хадгалах төхөөрөмж, 1000 орчим ажлын компьютер, 300 гаруй зөөврийн компьютер болон дагалдах бусад тоног төхөөрөмж, сүлжээний аюулгүй байдлын техник хангамжууд ашиглагдаж байна. 1995 оноос хойших 29 жилийн өгөгдөл мэдээллийг ашиглан үйлчилгээ үзүүлж байгаа ба сүүлийн 23 жилийн мэдээллийг бүртгэлд суурилан үүсгэж, түүнээс өмнөх жилүүдийн мэдээллийг цахим баримтын сан үүсгэн ашиглаж байна. Системийн шинэчлэлийн чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаагүй бөгөөд сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд мэдээллийн технологийн мэргэжилтэн 10 хүний бүрэлдэхүүнтэй нэгж, үүнээс 4 программ зохиогч ажиллаж, 60 гаруй программ хангамжийг өөрийн хүний нөөцөөр хөгжүүлэн нэвтрүүлснээс эрүүл мэндийн даатгалын чиг үүрэг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий

газарт шилжсэнээр 2023 оны байдлаар 45 программ хангамж, мэдээллийн системийг идэвхтэй ашиглаж байсан.

Эдгээр программ хангамж, мэдээллийн систем нь ялгаатай цаг хугацаанд, янз бүрийн технологи дээр хийгдсэн учир бусад төрийн байгууллагуудын мэдээллийн системтэй уялдан ажиллахад тодорхой хүндрэлүүд үүссэн. Мөн эдгээр салангид, олон программ хангамжийн тогтвортой үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээ, хөгжүүлэлт шинэчлэл хийхэд цаг хугацаа их алдаж байсан. Түүнчлэн нийгмийн даатгалын төв, орон нутгийн салбар 40 нэгж (21 аймаг, 9 дүүрэг, сумын 10 тасаг) тус тусдаа сервер компьютер дээр өөр хоорондоо үл хамааралтай мэдээллийн системийг ашиглаж ирсэн бөгөөд мэдээллийг нэгтгэн төвлөрүүлэхийн тулд нэгж бүрт бүрдүүлсэн мэдээллийг нэгтгэж мэдээллийн нэгдсэн сан үүсгэн хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж байсан нь динамик автомат бус шинжтэй тул мэдээллийг түргэн шуурхай нэгтгэх боломжид саад учруулж байсан.

Иймд мэдээллийг түргэн шуурхай нэгтгэх, боловсруулах, төвлөрсөн мэдээллийн сан бий болгож мэдээллийг нэг цэгээс хүргэх, нийгмийн даатгалын үйлчилгээг шуурхай үзүүлэх зорилгоор мэдээллийн системийг орчин үеийн технологи дээр суурилсан төвлөрсөн мэдээллийн сантай, хуулийн өөрчлөлтийг уян хатан зохицуулах боломжтой шинэ систем болгон өөрчлөх шаардлага тавигдсан.

2016-2018 онд Азийн хөгжлийн банкны "Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төсөл"-ийн хүрээнд ITZone ХХК системийг шинэчлэх, хөгжүүлэх ажлыг 2019-2024 онд гүйцэтгэж, төслийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар хамтран хэрэгжүүлсэн.

Шинэ систем нь ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайлан, сайн дурын даатгалын, тэтгэврийн, тэтгэмжийн бүтээгдэхүүн үйлчилгээг хамарсан цогц систем болсон. Энэхүү систем нь банк болон бусад төрийн байгууллагуудад ашиглагдаж байгаа ОРАКЛ өгөгдлийн сан дээр суурилсан, илүү найдвартай, аюулгүйгээс гадна өндөр бүтээмжтэй уян хатан зэрэг давуу талуудтай. Мөн түүнчлэн өгөгдлийн сангийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулалгүйгээр өгөгдлийн төрөл болон бусад зүйлсийг нэмэх боломжтой. Өгөгдлийн хэмжээнээс хамааран багтаамжийг өөрөө тохируулдаг бөгөөд нөөцийг үр дүнтэй ашиглах боломжоор хангадаг. Өгөгдлийн сангийн өгөгдөл нь тусгайлсан сүлжээнд байрлан хадгалагддаг тул найдвартай ажиллахаар зохион байгуулагдсан.

Шинэ системийг бүрэн нэвтрүүлснээр нийгмийн даатгалын үйлчилгээ бүрэн цахимжих, мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт цаг хугацааны хоцрогдолгүй бодит цагийн горим (real time)-оор үүсэж байгаа тул хэрэглэгчид (иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, төрийн болон бусад байгууллагууд) нийгмийн даатгалын үйлчилгээ (тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох, мэдээлэл солилцох, лавлагаа, тодорхойлолт авах зэрэг)-г цаг хугацаа, орон зайнаас үл хамааран шуурхай авах боломж бүрдэх, уян хатан, динамик суурьтай тул хууль тогтоомжийн өөрчлөлт болон хэрэглэгчийн хүсэлтийн дагуу богино хугацаанд системийн хөгжүүлэлтийг хийх боломжтой, ашиглахтай холбоотой үйлчилгээний болон урсгал зардлын төсвийг хэмнэх, зардал

буурах, мэдээллийн аюулгүй байдал сайжрах, мэдээллийн давхардалгүй болж, бүртгэлд суурилсан цахим хяналтын үйл ажиллагаанд шинэ дэвшил гарч, нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын гар ажиллагаа багасч, ажлын ачаалал тэнцвэржиж, иргэдэд зөвлөгөө өгөх, үйлчлэх ажилдаа илүү цаг зарцуулах боломж бүрдэж байна.

Мөн шимтгэл төлөх, тайлагнах, тэтгэвэр, тэтгэмж авах хүсэлтээ цахимаар илгээх, хүсэлтийн шийдвэрлэлийн явц, авах тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, хуваарь ажил олгогч, даатгуулагчдад ойлгомжтой, ил тод, нээлттэй болж байгаа тул нийгмийн даатгалын байцаагч, ажилтнууд ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх нөхцөл бүрдэж байна. Харилцагч ажил олгогчдын хувьд системийн хэрэглээ тогтворжиж, тэдний зүгээс өмнөх системээс сайжирсан, цаашид хөгжүүлэлт хийгээд явахад сайн систем гэсэн санал, талархал ирүүлсээр байгаа болно. Иймд **"цахим систем нь салбарын ажилтан болон даатгуулагч, ажил олгогчийн хэрэгцээ, шаардлагыг хангахгүй байгаа"** гэж дүгнэсэн нь үндэслэлгүй гэж үзэж байна.


"Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт: 6 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн санал:


**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**
14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII байр.
Утас: 26-36-95 Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.moh.gov.mn

2024.11.14 № 2/4765
танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.ЭНХБОЛД ТАНАА**

Танаас ирүүлсэн “Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж холбогдох тайлбар, тодруулгыг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авна уу .

Хавсралт хуудастай


ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Д.ОЧИРБАТ

146243889

**“НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ” СЭДЭВТ
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНД ӨГӨХ САНАЛ**

№	Аудитын тайланд тусгагдсан асуудал	Тайлбар, зарруулга, тайланд тусгах санал
1. ЭМД-ын үйл ажиллагааны зардал		
1	1.71. ЭМДЕГ 2020-2023 онуудад жилд дунджаар 7,682.2 сая төгрөгийн, 21 аймаг, 2 дүүргийн 1,015.0 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажилласан ба зардлыг ЭМДС-ын төсөвт тусган хэрэгжүүлж байна. Даатгуулагчаас эрүүл мэндийн санхүүгийн эрсдэлийг бууруулах зорилгоор төлж байгаа шимтгэлийг байгууллагын үйл ажиллагааны зардалд зарцуулж байгаа нь оновчгүй байгаа тул улсын төсвөөс санхүүжүүлэх нь зүйтэй байна.	Тайлбар: 1. Засгийн газрын тухай хуульд агентлагийг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж заасан бөгөөд дийлэнх агентлагууд нь төрийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа учраас улсын төсвөөс санхүүждэг. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6-т эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны зардал, 20.3-т эрүүл мэндийн даатгалын нийт үйл ажиллагааны зардал тухайн жилийн орлогын 5 хувиас илүүгүй байна гэж тодорхой заасан байдаг. 2024 оны ЭМД-ын сангийн төсвийн тухай хуулиар ЭМД-ын үйл ажиллагааны зардал нь нийт сангийн зардлын 0.8 хувийг эзэлж байгаа нь бага үзүүлэлт бөгөөд эх үүсвэрээс болоод сангийн тэнцэл алдагдах, үйл ажиллагаа доголдох асуудал үүсэхгүй юм.
2	2.121. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “Эрүүл мэндийн даатгал” гэж төр, иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж, эрүүл мэндийн даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа гэж заасан ч ЭМДС-д иргэдийн төлсөн шимтгэлээс ЭМДБ-ын үйл ажиллагааны зардалд зарцуулж байна. Энэ нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Агентлагийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.	2. ЭМД-ын байгууллагын үйл ажиллагааны зардлыг даатгуулагчийн эрүүл мэндийн санхүүгийн эрсдэлээ бууруулахаар төлж байгаа шимтгэлийн орлогоос бүрдсэн ЭМДС-аас санхүүжүүлж байгаа нь оновчгүй талаар дүгнэсэн тайланд нэмэлт тайлбар дурьдвал: • Даатгуулагч нь өвдсөн үедээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг шууд төлөх нь санхүүгийн хүндрэлийг бий болгодог учраас өвдсөн үедээ ашиглах, ирээдүйд гарч болзошгүй санхүүгийн эрсдэлийг бууруулах зорилгоор ЭМД-ын шимтгэлийг төлдөг. Улмаар даатгуулагчийн нийт төлсөн шимтгэл нь хэрэгцээт үедээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан зардлаас нь бага байж болох ч нийт даатгуулагчдаас цутлуулсан шимтгэлийн орлогыг өсгөн үржүүлэх, оновчтой зарцуулах зэрэг сангийн менежментийг хийхэд зайлшгүй үйл ажиллагааны зардал гарна. Олон улсад ЭМДС нь хувийн, улсын, албан журмын, сайн дурын гээд олон хэлбэртэй хэрэгждэг ч үйл ажиллагааны зардлыг шимтгэлийн орлогоос санхүүжүүлдэг. Тухайлбал Нийгмийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоотой хөгжсөн орнууд болох БНСУ, Герман, Япон, Тайланд, Тайвань, Эстон, Австри, Франц, хөгжиж буй орнуудаас Вьетнам, Индонез болон БНХАУ, Энэтхэг зэрэг сүүлд ЭМД-ын тогтолцоонд шилжсэн улсууд шимтгэлийн орлогоос үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлдэг.
3	Дүгнэлт: 7. ЭМДТ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т ЭМДҮЗ нь Нийгмийн даатгалын тухай хууль /хуучин нэрээр/-ийн 27 дугаар зүйлд заасан Үндэсний зөвлөд байна гэж заасан нь тус зөвлөд НДҮЗ-оос тусдаа байгуулагдаж, үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэслэлгүй, ЭМДТХ тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас буюу даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлогоос санхүүжүүлж байгаа нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан “Эрүүл мэндийн улмаас даатгуулагчид үүссэн санхүүгийн эрсдэлийг хуваалцах” гэсэн үндсэн зарчимд нийцэхгүй байна.	
4	Зөвлөмж: Эрүүл мэндийн яаманд: 1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх асуудлыг холбогдох газарт хандаж шийдвэрлүүлэх	Иймд тайланд тусгасан болон Зөвлөмжид тусгасан Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх асуудлыг хасуулах саналтай байна.
5	1.32. ЭМДЕГ нь судалгааны ажил хийх, мөн өөрийн орлогыг бүрэн хянах боломж бүрдүүлэх зорилгоор 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 01/2373 тоот албан бичгээр НДЕГ-т хандсан боловч ЭМДШ төлсөн аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчийн регистрийн дугаар, шимтгэл төлөлтийн мэдээлэл нь нууцад хамаарах тул өгөх боломжгүй, харин нийтийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 6 зүйлийн 6.2.5-д тус тус заасныг үндэслэн	Тайлбар: НДЕГ-аас ажилтны регистрийн дугаараар шимтгэл төлсөн гэдэг ерөнхий мэдээлэл өгөөд үүнд үндэслэж эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулалтыг хязгаар тогтоолгүй гаргаж байгаа. Харин ажилтан хэдэн төгрөгийн шимтгэл төлсөн талаар тухай бүр ногдуулалт хийж эрүүл мэндийн даатгалын санд бүхэл дүнгээр шилжүүлж байгаа нь зохисгүй байна. Даатгуулагч хэр хэмжээний мөнгийг төлсөн, хэдий хэмжээний хэрэгцээ хийж байна зэрэг нь сангийн тэнцлийг хангах тусламж, үйлчилгээний оновчтой багцыг тодорхойлох, актуар тооцоолол хийх хамгийн чухал

	<p>тодорхойлох боломжгүй өгөгдөл болгон нийт дүнгээр гаргах боломжтой гэдгээ илэрхийлсэн байна.</p>	<p>мэдээлэл байхад нууц гэж тайлбарлаж байгаа нь зохисгүй байна. Харин ЭМДЕГ нь хувь хүний нууцын тухай хуульд заасан бүх шаардлагыг хангасан үндэсний дата төвд байрлах найдвартай системтэй, бүх хүмүүсийн өвчний өгөгдлийг хадгалдаг, эмзэг нарийн мэдээлэлтэй ажилладаг мэргэжлийн байгууллага байхад, иргэд цалингаасаа төлсөн шимтгэлийн мөнгөн дүнг нь нууц нэрээр өгөхгүй байгаа нь эргээд ажилтан, албан хаагчид эрүүл мэндийн даатгалд зориулж төлсөн мөнгийг шилжүүлэхгүй өөр зориулалтын бусаар зарцуулж байх өндөр эрсдэлтэй, хардалтыг төрүүлж байна. 2023 онд гэхэд ногдуулалт хийсэн 16 тэрбум төгрөгийг ЭМД-ын санд төвлөрүүлээгүй байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, тухайн хүний цалингийн мэдээллийг шаардаагүй бөгөөд хуулийн дагуу иргэд эрүүл мэндийн даатгалдаа төлсөн мөнгөн дүнгийн мэдээллийг шаардаж байгаа учир энэ дүгнэлт, тайлбар нь учир дутагдалтай байна.</p> <p>Тусгах санал: Энэхүү 1.32 заалтын дор тодруулсан хүснэгтэд дараах дүгнэлтийг нэмүүлэх саналтай байна. Үүнд: ЭМДС-ийн тэнцвэрийг хангахын тулд ЭМДЕГ нь орлого болон зарлагын мэдээнд аль алинд нь нарийвчилсан дүн шинжилгээ хийж, сайжруулах саналыг боловсруулах үүрэгтэй. Даатгуулагчийн шимтгэлийн мэдээлэл нь орлогын 40-өөс дээш хувийг бүрдүүлж буй мэдээлэл тул уг мэдээллийг зайлшгүй авдаг байх нь ЭМДЕГ-ын цаашдын үйл ажиллагаанд чухал тул НДЕГ нь хууль эрх зүйн хүрээнд даатгуулагчийн шимтгэлийн нарийвчилсан мэдээллийг ЭМДЕГ-т өгөх шаардлагатай байна.</p>
6	<p>1.39. НДЕХ-д ЭМДҮЗ-ийн дэргэд Олон нийтийн хяналтын зөвлөл, Мэргэжлийн хороо байгуулан ажиллуулах, НДЕГ-ын дэргэд Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг шилжүүлэн ажиллуулахаар зохицуулсан ч эдгээр ажил удаашралтай байна.</p>	<p>Тайлбар: ЭМДҮЗ-ийн дэргэд Олон нийтийн хяналтын зөвлөл, мэргэжлийн хороо гэж байдаггүй тул залруулах шаардлагатай.</p>
7	<p>1.61. “ЭМДҮЗ-ийн дүрэм”-д Ажлын алба 12 орон тоотой байхаар зохицуулсан ба тус албаны бүтэц, орон тоо, ажлын байрны чиг үүргийг баталсан шийдвэр ЭМДҮЗ-өөс гараагүй байна.</p>	<p>Тайлбар: ЭМДҮЗ-өөс ажлын албаны бүтэц, орон тоо, ажлын байрны чиг үүргийг батлах эрх, үүрэг хуулиар олгогдоогүй. УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл шинжлэх ухааны байнгын хорооны даргын 2018 оны 18 дугаар тогтоолоор ажлын албаны орон тоо, ажлын байрны төрлийг тогтоосон бөгөөд 2019 оны 08 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон. ЭМДҮЗ-ийн ажлын албны даргын 2023 оны А/02 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг батлан мөрдүүлж байна.</p> <p>Иймд тайлангийн 1.61 дэх заалтыг хасах саналтай байна.</p>
8	<p>1.63. ЭМДТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-т ЭМЯ-ыг ЭМД-ын байгууллагын тогтолцооны нэг хэсэг байхаар заасан боловч чиг үүргийг нарийвчлан тусгаагүй байна. ЗГ-ын 2021 оны 231 дүгээр тогтоолоор ЭМЯ-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орно тооны хязгаарыг шинэчлэн баталж, ЭМД-тай холбоотой Бодлого төлөвлөлтийн газар (Стратеги удирдлагын хэлтэс), Санхүү, эдийн засгийн газар (Санхүү даатгалын хэлтэс)-тай байхаар тусгаж, ажлын байрны үндсэн чиг үүргийг ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/130 дугаар тушаалаар баталсан байна.</p>	<p>Тайлбар: ЗГ-ын 2021 оны 231 дүгээр тогтоолоор баталсан ЭМЯ-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталж, үйл ажиллагааны тэргүүдэх чиглэлдээ 2.2.4-д эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчилж, иргэдэд хүртээмжтэй, үр өгөөжтэй зарцуулах арга замыг нэвтрүүлэхээр тусгасан бол стратегийн зорилтод 2.4.5-д эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчилж, иргэдэд хүртээмжтэй, үр өгөөжтэй зарцуулах арга замыг нэвтрүүлэх, эмийн үнийн хөнгөлөлт, үнийн жишгийг тогтоох, цахим бүртгэлийн системийг нэвтрүүлж олон улсын жишигт</p>

		<p>хүргэхээр заасан. Мөн нэгжийн чиг үүрэгт тусган баталсан байдаг.</p> <p>Түүнчлэн Засгийн газрын 2024 оны 40 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн баталсан бөгөөд үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд эрүүл мэндийн салбарын төсөв, хөрөнгө оруулалт, эрүүл мэндийн даатгалын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, санхүүгийн нэгдсэн төлөвлөлт, шаардлагатай тооцоо судалгаа хийх, тэдгээртэй холбоотой хууль тогтоомж, урт, дунд богино хугацааны хөгжлийн б одлого хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангахаар зааж холбогдох чиг үүргийг яамны нэгжүүдэд хариуцуулахаар баталсан.</p> <p>Иймд тайлангийн 1.63 дахь заалтыг хасах саналтай байна.</p>
9	<p>1.65. ЭМДҮЗ-ийн 2020 оны 17 дугаар тогтоол, ЭМС-ын 2020 оны А/556 дугаар тушаалаар тус газрын бүтцийг баталсан байна. ЗГ-ын 2020 оны 176 дугаар тогтоолоор ЭМДЕГ-ын дотоод бүтцийг 5 газар 7 хэлтэстэй, 170 орон тоо, 21 аймаг, 2 дүүрэгт 115 орон тоо нийтдээ 285 орон тоо баталснаас аймаг, дүүргийн ЭМДХ-ийн орон тооны эрх зүйн үндэслэл тодорхойгүй байна.</p>	<p>Тайлбар:</p> <p>ЭМДЕГ буюу төв байгууллагын орон тооны бүтцийг Засгийн газрын тогтоолоор баталсан байдаг. Харин орон нутгийн хэлтсүүдийн орон тоо нь жил бүрийн төсвийн тухай хуулиар СЯ дээр батлагдаж, төсвийн систем дээр хянагддаг. Энэ нь зөвхөн ЭМДЕГ-т хамаарах бус нийт орон нутагт салбар бүхий төрийн байгууллагууд тухайлбал НДЕГ ч мөн энэ байдлаар орон тоо нь хянагддаг.</p>
10	<p>1.69. ЭМД-ын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ЭМД-ын байгууллагуудын хувьд ЭМД санг оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн байдлаар удирдах, менежмент хийх, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх замаар санг арвижуулах тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай мэргэжлийн байгууллагын тогтолцоо бий болоогүй байна.</p>	<p>Тайлбар:</p> <p>ЭМД-ын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ЭМД-ын байгууллагуудын хувьд ЭМД санг оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн байдлаар удирдах, менежмент хийх, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх замаар санг арвижуулах тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай мэргэжлийн байгууллага нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар бөгөөд тогтолцоо бий болоогүй гэдэг дүгнэлт нь ойлгомжгүй байна.</p> <p>Түүнчлэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь талуудын оролцоонд үндэслэн шийдвэр гаргалаг бөгөөд тус чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн байгууллага нь ЭМДЕГ, хөндлөнгийн хяналт хийж дүгнэлт өгөх нь ЭМДҮЗ-ийн дэргэдэх техникийн хороо бөгөөд санхүүжилт, багц, хяналттай холбоотой бүх шийдвэрүүд хуульд заасны дагуу Сангийн яам, Эрүүл мэндийн яамны зөвшөөрөл хяналтын доор явагддаг.</p> <p>Иймд тайланд тусгасан 1.69 дахь заалтыг хасах саналтай байна.</p>
11	<p>1.94 Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн системд дүн шинжилгээ хийхэд:</p> <p>Нийт ЭМДС-аас 1,409,109,292,742.0 төгрөгийн 19,431,658 үйлчилгээг давтагдсан тоогоор авсан байна. Нийт 39 төрлийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна. Даатгуулагчийн үйлчилгээнд дараах асуудал гарч байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> Хамгийн өндөр үнийн дүнтэй буюу 6,666,724,920.0 төгрөгийн 3 үйлчилгээг авсан 1 иргэн байна. 	<p>Тайлбар:</p> <ul style="list-style-type: none"> 1 иргэн 6,6 тэрбумын тусламж, үйлчилгээ авах эсвэл жилд 37439 тохиолдол бүхий тусламж, үйлчилгээ авах боломжгүй тул уг тоо мэдээллийг гаргаж ирсэн дата анализыг эргэн нягтлах, шалтгааныг тодруулж байж тайлагнах шаардлагатай. /ЭМДЕГ/ Эрүүл мэндийн тухай хуулийн 24.4д заасны дагуу яаралтай тусламж, түргэн тусламжийг улсын төсвөөс хариуцдаг. Яаралтай болон түргэн тусламж үзүүлэх явцад тухайн иргэний нэр хаяг тодорхой биш, ухаан алдсан, гэмтэж бэртсэн, өөрийгөө илэрхийлэх чадваргүй иргэд байдаг бөгөөд эдгээр иргэдийн хувьд

	<ul style="list-style-type: none"> Хамгийн их үйлчилгээ авсан иргэн нь 37439 ширхэг үйлчилгээ буюу 1,917,100,283 төгрөгийн үйлчилгээ авсан байна. 	<p>хурууны хээ уншуулах боломжгүй, бичиг баримтгүй тохиолдолд ЭМДҮЗ-ийн холбогдох тогтоолуудын дагуу нэг зохиомол код ашиглаж бүртгэл хийдэг. Энэ нь нэг хүн гэж дүгнэгдсэн байгааг анхаарна уу.</p> <p>Иймд тодруулга авч, нягтлаад холбогдох заалтыг хасах саналтай байна.</p>
12	2.129 ЭМД-ын байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байгаа Эрүүл мэндийн байгууллагуудын харилцагч байгууллагууддаа үүсгэсэн өр төлбөр болон ЭМДС-аас авах авлагын мэдээллийг 2024 оны 9 дүгээр сарын байдлаар харуулбал дараах байдалтай байна.	<p>Залуулга:</p> <p>ЭМД-ын байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байгаа Эрүүл мэндийн байгууллагуудын харилцагч байгууллагууддаа үүсгэсэн өр төлбөрийн мэдээг 2024 оны 9 дүгээр сар, ЭМДС-аас авах авлагын мэдээллийг 2024 оны 8 дүгээр сарын байдлаар харуулбал дараах байдалтай байна. Гэж заруулах.</p>
13	2.125, 2.126-ийн доор байрлах тодруулга: Улсын төсвөөс ЭМДШ-г төлдөг (сард 6600-13200 төгрөг төлдөг) иргэд эрүүл мэндийн байгууллагаар хамгийн их үйлчлүүлж, ЭМДС-ийн хөрөнгийн дийлэнх нь эдгээр иргэдэд зарцуулагдаж байна.	<p>Тайланд нэмэлтээр тусгах санал:</p> <ul style="list-style-type: none"> Энэхүү 2.126 заалтын дор тодруулсан хүснэгт дэх дүгнэлтийг дараах байдлаар өөрчлүүлэх саналтай байна. Үүнд: <p>Улсын төсвөөс ЭМДШ-г төлдөг (сард 6600-13200 төгрөг төлдөг) иргэд эрүүл мэндийн байгууллагаар хамгийн их үйлчлүүлж, ЭМДС-ийн хөрөнгийн дийлэнх нь эдгээр иргэдэд зарцуулагдаж байна. Цаашид ЭМДС-ын тэнцвэрийг хангах хүрээнд төр шимтгэлийг нь хариуцах иргэдийн шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх шавардлагатай байна.</p>
14	2.134. Эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлэлтээс харахад дараах асуудлууд байна. Тухайлбал <ul style="list-style-type: none"> Зарим төрөлжсөн эмнэлгүүд (ГССҮТ, Гуравдугаар эмнэлэг гэх мэт) ЭМДС-аас авах авлагаар өрөө барагдуулах боломжтой бол дүүргийн эмнэлгүүд ЭМДС-аас авлагаа бүрэн авсан ч өрөө барагдуулах боломжгүй байна. Энэ нь нэг төрлөөр ЭМД-ын байгууллага эмнэлгүүдийн хүчин чадалд бус өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн гэрээлэлт хийдэг, ногоо талаар шатлалын эмнэлгүүдийн үзүүлэх үйлчилгээг заагласан шалгуур байхгүйгээс иргэд дүүргийн бус төрөлжсөн эмнэлгийг сонгон үйлчлүүлэх хандлага илүү байгаагаар холбоотой байна. 	<p>Тайлбар:</p> <ul style="list-style-type: none"> ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг баталсан байдаг. Уг журмаар сонгон шалгаруулалтыг тухайн байгууллагын чадамжил суурилан хийхээр журамласан байх бөгөөд чадамж гэдэг нь тухайн ЭМБ нь тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэх хүний нөөц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн чадамж байгаа эсэхэд үндэслэн сонгон шалгаруулж гэрээлэх юм. Энэ нь ЭМДЕГ-ын даатгуулагчийн нэрийн өмнөөс чанартай тусламж, үйлчилгээг худалдан авах чиг үүргээ хангуулах 1 арга хэмжээ юм. ЭМДҮЗ-ийн 2021 оны 13 дугаар тогтоолоор Гэрээний үлгэрчилсэн журам батласан бөгөөд үүнд гэрээнд заах тусламж, үйлчилгээг өмнөх жилийн гүйцэтгэлд бус хүчин чадалд суурилан тооцож гэрээлдэг. ЭМД-ын байгууллагын хувьд бол тусламж, үйлчилгээ худалдан авах бөгөөд эрүүл мэндийн байгууллагын сайн, муу менежментийн асуудалд шууд хамааралгүй юм. Эрүүл мэндийн байгууллагууд нь 2016 оноос эхлээд хагас бие дааж үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин нээгдэж, 2020 оноос эхлээд санхүүгийн хувьд бие даан үйл ажиллагаа явуулж байгаа юм. Хэрэв тухайн эмнэлгийн удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байгаагаас үйлчлүүлэгчээ алдах, чадамжтай эмнэлгүүд нь илүү санхүүжилт авч байгаа нь зүй ёсны асуудал юм. Харин бодлогын хувьд ЭМЯ-ны зүгээс тус асуудалд анхаарч аль шатанд ямар тусламж, үйлчилгээ үзүүлэх вэ? Шатлал хоорондын бодлого ямар байх уу? Аль эмнэлгээр ямар тусламж, үйлчилгээ үзүүлэх вэ гэдэг талаар бодлогыг авч хэрэгжүүлж байна. ЭМД-ын

		<p>тогтолцоо бол үзүүлсэн тусламж, үйлчилгээ худалдан авч байгаа болохоос байгууллагын зардал санхүүжүүлэхгүй байгаа. 2022 онд үүссэн өглөг авлагын асуудал нь КОВИД-19 цар тахлын үед гарсан нэг удаагийн санхүүжилттэй холбоотой бөгөөд үүнээс улбаалж үлдэгдэлтэй байна. Харин үндсэн тусламж, үйлчилгээний хувьд бол орлого болон зарлага нь тэнцэж явж байна.</p> <p>Ийм тайланд тусгасан 2.134 дүгнэлтийг хасах саналтай байна.</p>
15	<p>2.134 Эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлэлт: Хүснэгт 48-ийн дараах тайлбар:</p> <p>Энэ үзүүлэлтээс харахад лавлагаа шатлал болон хувийн эмнэлгүүдэд илүү санхүүжилтийн дүнтэй ЭМТҮ-г хуваарилсан байна. Мөн ЭМДБ нь ЭМБ-уудын нэхэмжилсэн дүнгээс хасалт хийж байгаа нь өрийн хэмжээнд тодорхой хувиар нөлөөлж байна.</p>	<p>Тайлбар:</p> <ul style="list-style-type: none"> ЭМДЕГ нь ямар эмнэлэг, ямар тусламж, үйлчилгээ үзүүлэхийг хуваарилдаггүй, заадаггүй бөгөөд ЭМБ-ууд ямар тусламж, үйлчилгээ үзүүлэх вэ гэдэг хүсэлтээ өөрийн хүчин чадал, хүний нөөц, чадамжиндаа тулгуурлан гаргаж, сонгон шалгаруулалтад хамрагдан гэрээлдэг. Иймд лавлагаа шатлал болон хувийн эмнэлгүүдэд илүү санхүүжилтийн дүнтэй ЭМТҮ-г хуваарилсан гэх тайлбар үндэслэлгүй. Харин тайланд аймаг, дүүргийн НЗ-үүд нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамжгүйгээс ЭМДЕГ-тай гэрээлээгүй байх тул бодлогоор дэмжин зохицуулах асуудлыг үе шаттай хэрэгжүүлж байна. Нэхэмжлэлийн хяналт нь даатгуулагчдад чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх нэг том бодлогын хөшүүрэг юм. Хэрэв чанаргүй тусламж, үйлчилгээ эмнэлэг үзүүлсэн тохиолдолд мөнгө төлөөд байвал үр дүн сайжрахгүй бөгөөд үүнийг сайжруулах зорилго үйл ажиллагааг стратегийн худалдан авалт буюу гүйцэтгэлийн санхүүжилт гэж нэрлэж байгаа юм. <p>Иймд энэ дүгнэлтийг хасах саналтай байна.</p>
16	<p>2.135</p> <p>Дүрслэл 22-ийн тайлбар:</p> <p>ӨЭМТ нь төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний дагуу гүйцэтгэж байгаа нөхөрлөл бөгөөд ажил гүйцэтгэх гэрээнд төрөөс авч байгаа санхүүжилтийн зарцуулалтад төрийн аудитын байгууллага аудит хийх асуудлыг тусгаж өгөөгүйгээс зарим төв төрийн аудитад хармаглахгүй байх нөхцөл бүрдсэн байна.</p>	<p>Тайланд нэмэлтээр тусгах санал:</p> <ul style="list-style-type: none"> Энэхүү 2.135 заалтын дор тодруулсан дараах тайлбарыг тод өнгөөр тодруулан оруулах саналтай. Үүнд: <p>ӨЭМТ нь төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж буй тул төрөөс авсан санхүүжилтийг эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, гэрээт ажлыг чанартай гүйцэтгэхэд зарцуулж буй эсэхэд хяналт тавих шаардлагатай. ЭМЯ, аймаг нийслэлийн ЭМГ нь ӨЭМТ-үүдийн зарцуулалтын тайланг сар, улирал, жилээр авч хяналт тавих шаардлагатай.</p>
17	<p>Зөвлөмж хэсэг;</p> <p>ЭМЯ:</p> <ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх асуудлыг холбогдох газар хандаж шийдвэрлүүлэх 	<p>Тайлбар:</p> <p>Засгийн газрын тухай хуульд агентлагийг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж заасан бөгөөд дийлэнх агентлагууд нь төрийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа учраас улсын төсвөөс санхүүждэг. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6-т эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны зардал, 20.3-т эрүүл мэндийн даатгалын нийт үйл ажиллагааны зардал тухайн жилийн орлогын 5 хувиас илүүгүй байна гэж тодорхой заасан байдаг.</p> <p>Иймд Уг зөвлөмжийг хасах саналтай байна.</p>
18	<p>Зөвлөмж хэсэг:</p>	<p>Дараах зөвлөмжүүдийг холбогдох газаруудад нэмж оруулах:</p> <p>УИХ-д:</p> <ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн даатгалын сангийн жилийн төсвийн хуулийг батлахдаа орлого, зарлагын тэнцлийг хангах, орлогыг оновчтой төлөвлөх, төр хариуцах иргэдийн

Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө

			<p>шимтгэлийн орлогын хэмжээг бодитой болгож нэмэгдүүлэхэд анхаарч батлах нь зүйтэй байна.</p> <p>ЭМЯ-д:</p> <ul style="list-style-type: none"> • Төр шимтгэлийг нь хариуцах иргэдийн шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг ЗГ, СЯ-аар шийдвэрлүүлэх <p>Нийгмийн даатгалын Ерөнхий газарт:</p> <ul style="list-style-type: none"> • Даатгуулагчийн шимтгэл төлөлтийн нарийвчилсан мэдээллийг ЭМДЕГ-т бодит цагийн горимоор хүргүүлж, тус байгууллагыг судалгаа шинжилгээ хийх, хуулиар олгогдсон эрх үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх
--	--	--	--

Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн санал:

 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16, E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.ЭНХБОЛД ТАНАА
<div style="display: flex; justify-content: space-between;"><div>2024.11.14 №</div><div>01/2369</div></div> <div style="display: flex; justify-content: space-between;"><div>танай _____</div><div>_____ны № _____</div><div>_____т</div></div>	

**Тайлангийн төсөлд санал
хүргүүлэх тухай**

"Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу дараах саналыг хүргүүлж байна.

Тайлангийн төслийн 70 дугаар хуудсан дахь "ДҮГНЭЛТ"-ийн 6 дахь хэсгийг зарчмын хувьд дараахь үндэслэлээр хүлээн зөвшөөрөхгүй байна. Үүнд:

1."Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах зарим нэгжийг байгуулаагүй" гэсэн дүгнэлтийн хүрээнд

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж байна. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо бүрэлдэж, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны "Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц батлах тухай" А/19 дүгээр тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод зохион байгуулалтын бүтэц, түүний дэргэдэх байгууллагуудыг баталж, батлагдсан бүтцийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газар, түүний дэргэдэх зөвлөл, төв, алба, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дотоод зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталж, албан тушаал, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргад үүрэг болгосон. Энэхүү тушаалын хавсралтаар "Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр" (цаашид "Хөтөлбөр" гэх)-ийг баталсан.

Хөтөлбөрийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого", Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Засгийн газрын 2016 оны "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр тогтоол, 2017 оны "Агентлаг байгуулах тухай" 344 дүгээр тогтоол зэрэг

хууль эрх зүйн баримт бичгийг үндэслэн Засгийн газрын 2016 оны "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 4 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн ерөнхий загвар"-ыг удирдлага болгон төрийн албаны залгамж чанар, хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн байдал болон мэргэшсэн төрийн албан хаагчдын туршлага, олон улсын туршлага, хөгжлийн чиг хандлага зэргийг харгалзан боловсруулсан.

Хөтөлбөрийн 2.4-т үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг, 2.5-д үйл ажиллагааны гол зорилтуудыг, 2.6-д үйл ажиллагааны зорилтуудыг, 3.1-д бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримталсан зарчмуудыг тодорхойлж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг, албан хаагчдын ажлын байрны үндсэн чиг үүргийг тус тус тодорхойлсон. Эдгээр эрхзүйн баримт бичгийг үндэслэн чиг үүргийн дагуу хуваарилсан агентлагийн бүтцийн 7 нэгж, 5 хэлтэс, дэргэдэх 4 төв, зөвлөл, алба үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн "Шимтгэл хураалт, мэргэжил арга зүйн газар"-ыг шинээр байгуулан ажиллуулж байна. Иймд **"Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах зарим нэгжийг байгуулаагүй"** гэж дүгнэх үндэслэлгүй гэж үзэж байна.

Түүнчлэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35.17-д заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэд ажиллах эрсдэлийн удирдлага, актуар тооцоолол хийх, хөрөнгө оруулалт, аудитын орон тооны бус Мэргэжлийн хороог, мөн хуулийн 13.7-д заасны дагуу сангийн хөрөнгө оруулах үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил, арга зүйгээр хангах үүрэг бүхий орон тооны бус Олон нийтийн хяналтын зөвлөлийг тус тус байгуулаад байна.

2."зарим нэгжүүдийн үйл ажиллагааны нарийвчилсан чиг үүргийг батлаагүй" гэсэн дүгнэлтийн хүрээнд

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны "Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэгжүүдийн чиг үүргийг шинэчлэн батлах тухай" А/23 дугаар тушаалаар дотоод нэгжийн чиг үүргийг батлан мөрдөж байсан.

2019 оноос эхлэн мөрдөж байгаа Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтад "албан тушаалын тодорхойлолт" гэж тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг баталгаажуулсан баримт бичгийг." гэж заасан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/19 дүгээр тушаалаар үүрэг болгосны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/53 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц орон тоог, А/41 дүгээр тушаалаар Мэдээллийн технологийн төвийн бүтэц орон тоог, А/44 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн бүтэц, орон тоог, А/51 дүгээр тушаалаар Аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог, А/52 дугаар тушаалаар Дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог тус тус шинэчлэн баталж, Нийгмийн даатгалын байгууллагын батлагдсан орон тоо (1485)-ноос төрийн захиргааны 1227

орон тоонд хамаарах 133 албан тушаалын тодорхойлолтод Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 208-215 дугаар тогтоолуудаар зөвшөөрөл өгсний дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны "Албан тушаалын тодорхойлолт батлах тухай" А/101-А/104 дүгээр тушаалуудаар эдгээр албан тушаалын тодорхойлолтыг батлан мөрдөж байна. Албан тушаалын тодорхойлолт бүрд харьяалагдах газар, нэгжийн чиг үүрэг тусгагдсан болно.

Төрийн албаны тухай хуулиар чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод батална гэж заасан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/19 дүгээр тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-т агентлагийн зохион байгуулалтын бүтэц, нэгжийн үндсэн үүрэг, чиг үүргийг баталсан тул **"зарим нэгжүүдийн үйл ажиллагааны нарийвчилсан чиг үүргийг батлаагүй"** гэж дүгнэх үндэслэлгүй гэж үзэж байна.

3. *"хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээний үр нөлөө болон даатгуулагчийн эрсдэлийг хуваалцаж чадаж байгааг судлах зэрэг бодлогын чиг үүрэг орхигдсон"* гэсэн дүгнэлтийн хүрээнд

Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт баталсны дагуу хөгжлийн бодлогын баримт бичиг тухайлбал, Монгол Улсын "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого 2015-2030 зэрэгт нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүргийг тус газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар, эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, санал боловсруулах чиг үүргийг Дотоод аудит, мониторингийн газар, нийгмийн даатгалын сан, үйл ажиллагаанд судалгаа шинжилгээ хийх, нийгмийн даатгалын сангийн дунд болон урт хугацааны хэтийн (актуар) тооцоолол хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх, санал боловсруулах чиг үүргийг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын Судалгаа, актуар тооцооллын хэлтэс тус тус хэрэгжүүлж байна.

Иймд **"хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээний үр нөлөө болон даатгуулагчийн эрсдэлийг хуваалцаж чадаж байгааг судлах зэрэг бодлогын чиг үүрэг орхигдсон"** гэж дүгнэх үндэслэлгүй гэж үзэж байна.

4. *"шаардлагатай нэгжүүдэд сул орон тоог шийдээгүй"* гэсэн дүгнэлтийн хүрээнд

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны "Нийгмийн даатгалын төв болон орон нутгийн байгууллагын орон тооны хязгаарыг батлах тухай" А/45 дугаар тушаалаар нийгмийн даатгалын байгууллагын орон тоог 1485-аар баталсан бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 1349 албан хаагч ажиллаж байна.

Тус газар нь Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбар зөвлөлд Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг болон Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-д тус тус заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын болон дүүргийн Нийгмийн даатгалын газруудын сул

орон тоог нөхөх сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 2024 оны 06 дугаар сараас хойш хугацаанд нийт 5 удаа хүргүүлж, сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулж байна.

Мөн аймгийн Нийгмийн даатгалын газрууд нь сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн аймаг дахь салбар зөвлөлд тухай бүр өгч сул орон тоог нөхөж байна.

Цалин хөлсний хэмжээ бага, орон нутгийн нэмэгдэл хөлс олгохгүй байсантай холбоотойгоор нийгмийн даатгалын байцаагчид аймаг, сумын Тамгын газарт болон төрийн өөр байгууллагад шилжин ажиллах хөдөлгөөн нэмэгдсэн. Харин 2024 оноос Засгийн газраас орон нутгийн нэмэгдэл хөлс олгохоор шийдвэрлэсэн, цалин, урамшууллын хэмжээ нэмэгдсэн, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгож байгаатай холбоотойгоор цалин хөлс, орлогын хэмжээ нэмэгдснээр аймаг, сумын байцаагчийн сул орон тоо нөхөгдөх боломж нэмэгдэж байна.

Нийт 17 аймгийн 31 суманд байцаагчгүй байна. Эдгээр сумын байцаагчийн ажлыг ойролцоо сумын байцаагч, аймгийн Нийгмийн даатгалын газрын мэргэжилтнүүд хавсран гүйцэтгэх, мөн 3 сумын байцаагчийн ажлыг бусад төрийн байгууллагын албан хаагчаар хавсран гүйцэтгүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч, нийгмийн даатгалын үйлчилгээг тухайн сумын иргэд, даатгуулагчдад тасралтгүй үзүүлж байна.

Нийгмийн даатгалын байгууллага нь төрийн албан хаагчийн сул орон тоог нөхөх ажлыг холбогдох хууль, журмын дагуу дээр дурдсанаар тогтоосон хугацаанд гүйцэтгэж ирсэн. Иймд **"шаардлагатай нэгжүүдэд сул орон тоог шийдээгүй"** гэж дүгнэх үндэслэлгүй гэж үзэж байна.

Төрийн албан хаагчийн сул орон тоог нөхөх асуудал нь зөвхөн тухайн байгууллагын асуудал бус, төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа, ажлын ачаалал, ажиллах орчин зэрэг асуудлуудыг хууль эрх зүйн хүрээнд цогцоор нь шийдвэрлэж шийдэгдэх асуудал юм.

5."цахим систем нь салбарын ажилтан болон даатгуулагч, ажил олгогчийн хэрэгцээ, шаардлагыг хангахгүй байгаа" гэсэн дүгнэлтийн хүрээнд

Энэхүү дүгнэлтийг түүврийн хэмжээ хэт бага буюу эх олонлог төлөөлөх чадвар бага судалгаанд үндэслэн гаргасан байна.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 50 гаруй байгууллага өндөр хурдны шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбогдсон. Төв, орон нутгийн 31 нэгжид нийт 57 сервер компьютер, 6 өгөгдөл хадгалах төхөөрөмж, 1000 орчим ажлын компьютер, 300 гаруй зөөврийн компьютер болон дагалдах бусад тоног төхөөрөмж, сүлжээний аюулгүй байдлын техник хангамжууд ашиглагдаж байна. 1995 оноос хойших 29 жилийн өгөгдөл мэдээллийг ашиглан үйлчилгээ үзүүлж байгаа ба сүүлийн 23 жилийн мэдээллийг бүртгэлд суурилан үүсгэж, түүнээс өмнөх жилүүдийн мэдээллийг цахим баримтын сан үүсгэн ашиглаж байна. Системийн шинэчлэлийн чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаагүй бөгөөд сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд мэдээллийн технологийн мэргэжилтэн 10 хүний бүрэлдэхүүнтэй нэгж, үүнээс 4 программ зохиогч ажиллаж, 60 гаруй программ хангамжийг өөрийн хүний нөөцөөр хөгжүүлэн нэвтрүүлснээс эрүүл мэндийн даатгалын чиг үүрэг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт шилжсэнээр 2023 оны байдлаар 45 программ хангамж, мэдээллийн системийг

идэвхтэй ашиглаж байсан.

Эдгээр программ хангамж, мэдээллийн систем нь ялгаатай цаг хугацаанд, янз бүрийн технологи дээр хийгдсэн учир бусад төрийн байгууллагуудын мэдээллийн системтэй уялдан ажиллахад тодорхой хүндрэлүүд үүссэн. Мөн эдгээр салангид, олон программ хангамжийн тогтвортой үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээ, хөгжүүлэлт шинэчлэл хийхэд цаг хугацаа их алдаж байсан. Түүнчлэн нийгмийн даатгалын төв, орон нутгийн салбар 40 нэгж (21 аймаг, 9 дүүрэг, сумын 10 тасаг) тус тусдаа сервер компьютер дээр өөр хоорондоо үл хамааралтай мэдээллийн системийг ашиглаж ирсэн бөгөөд мэдээллийг нэгтгэн төвлөрүүлэхийн тулд нэгж бүрт бүрдүүлсэн мэдээллийг нэгтгэж мэдээллийн нэгдсэн сан үүсгэн хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж байсан нь динамик автомат бус шинжтэй тул мэдээллийг түргэн шуурхай нэгтгэх боломжид саад учруулж байсан.

Иймд мэдээллийг түргэн шуурхай нэгтгэх, боловсруулах, төвлөрсөн мэдээллийн сан бий болгож мэдээллийг нэг цэгээс хүргэх, нийгмийн даатгалын үйлчилгээг шуурхай үзүүлэх зорилгоор мэдээллийн системийг орчин үеийн технологи дээр суурилсан төвлөрсөн мэдээллийн сантай, хуулийн өөрчлөлтийг уян хатан зохицуулах боломжтой шинэ систем болгон өөрчлөх шаардлага тавигдсан.

2016-2018 онд Азийн хөгжлийн банкны “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төсөл”-ийн хүрээнд ITZone ХХК системийг шинэчлэх, хөгжүүлэх ажлыг 2019-2024 онд гүйцэтгэж, төслийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар хамтран хэрэгжүүлсэн.

Шинэ систем нь ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайлан, сайн дурын даатгалын, тэтгэврийн, тэтгэмжийн бүтээгдэхүүн үйлчилгээг хамарсан цогц систем болсон. Энэхүү систем нь банк болон бусад төрийн байгууллагуудад ашиглагдаж байгаа ОРАКЛ өгөгдлийн сан дээр суурилсан, илүү найдвартай, аюулгүйгээс гадна өндөр бүтээмжтэй уян хатан зэрэг давуу талуудтай. Мөн түүнчлэн өгөгдлийн сангийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулалгүйгээр өгөгдлийн төрөл болон бусад зүйлсийг нэмэх боломжтой. Өгөгдлийн хэмжээнээс хамааран багтаамжийг өөрөө тохируулдаг бөгөөд нөөцийг үр дүнтэй ашиглах боломжоор хангадаг. Өгөгдлийн сангийн өгөгдөл нь тусгайлсан сүлжээнд байрлан хадгалагддаг тул найдвартай ажиллахаар зохион байгуулагдсан.

Шинэ системийг бүрэн нэвтрүүлснээр нийгмийн даатгалын үйлчилгээ бүрэн цахимжих, мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт цаг хугацааны хоцрогдолгүй бодит цагийн горим (real time)-оор үүсч байгаа тул хэрэглэгчид (иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, төрийн болон бусад байгууллагууд) нийгмийн даатгалын үйлчилгээ (тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох, мэдээлэл солилцох, лавлагаа, тодорхойлолт авах зэрэг)-г цаг хугацаа, орон зайнаас үл хамааран шуурхай авах боломж бүрдэх, уян хатан, динамик суурьтай тул хууль тогтоомжийн өөрчлөлт болон хэрэглэгчийн хүсэлтийн дагуу богино хугацаанд системийн хөгжүүлэлтийг хийх боломжтой, ашиглахтай холбоотой үйлчилгээний болон урсгал зардлын төсвийг хэмнэх, зардал буурах, мэдээллийн аюулгүй байдал сайжрах, мэдээллийн давхардалгүй болж, бүртгэлд суурилсан цахим хяналтын үйл ажиллагаанд шинэ дэвшил гарч, нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын гар ажиллагаа багасч, ажлын ачаалал тэнцвэржиж, иргэдэд зөвлөгөө өгөх, үйлчлэх ажилдаа илүү цаг зарцуулах боломж бүрдэж байна.

Мөн шимтгэл төлөх, тайлагнах, тэтгэвэр, тэтгэмж авах хүсэлтээ цахимаар илгээх, хүсэлтийн шийдвэрлэлийн явц, авах тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, хуваарь ажил олгогч, даатгуулагчдад ойлгомжтой, ил тод, нээлттэй болж байгаа тул нийгмийн даатгалын байцаагч, ажилтнууд ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх нөхцөл бүрдэж байна. Харилцагч ажил олгогчдын хувьд системийн хэрэглээ тогтворжиж, тэдний зүгээс өмнөх системээс сайжирсан, цаашид хөгжүүлэлт хийгээд явахад сайн систем гэсэн санал, талархал ирүүлсээр байгаа болно. Иймд **"цахим систем нь салбарын ажилтан болон даатгуулагч, ажил олгогчийн хэрэгцээ, шаардлагыг хангахгүй байгаа"** гэж дүгнэсэн нь үндэслэлгүй гэж үзэж байна.

"Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт ... хуудастай


Хүндэтгэсэн,

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА



Ц.ГАНЦЭЦЭГ

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн санал:



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР
Чингисийн өргөн чөлөө, 20 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17032
Утас/Факс: (976) 7010 0005, Цахим шуудан: info@emd.gov.mn,
Цахим хуудас: www.emd.gov.mn


2024. 11. 13 № 01/4183
танай _____-ны № _____-т

┌ **ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН** ┐
└ **ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН** ┘
АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Д.ЭНХБОЛД ТАНАА

Үндэсний аудитын газраас хийсэн “Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч, хамтран ажиллахыг хүсье.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА  М.НАРМАНДАХ



Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын
2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн
01/11/23 дугаар албан бичгийн хавсралт

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААС "НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО,
ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ" СЭДЭВТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН
ТӨСӨЛД ӨГӨХ ТАЙЛБАР

1.94. Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн систем

**Нэг. Хамгийн өндөр дүнтэй буюу 6.666,724,920.0 төгрөгийн 3
үйлчилгээ авсан нэг иргэн байна. (регистр 3 үйлчилгээг
6,666,724,920 төгрөг)**

Тайлбар:

Тус мэдээлэл нь Ховд аймгийн Мянгад сумын эргэлтийн эмийн сангаас цахим
жороор үйлчилсэн эмийн сангийн мэдээлэл байна. Тухайн жор нь 2 эмтэй бөгөөд
КЛАВОМИД 375 (250МГ/125 МГ) эмийн мэдээллийг нэхэмжлэхдээ эмийн сангийн
програмаас буруу нэхэмжилсэн байх бөгөөд цахим хяналтын систем ажиллаж
10,500 төг дүнгээр олгохоор тооцсон байна. Өөрөөр хэлбэл анх нэхэмжилсэн дээрх
дүнгээр гүйцэтгэлийг олгох боломжгүй тул цахим хяналтаар олгохоор тооцсон
дүнгээр олгосон байна.

Системд хянагдаж тооцсон дүнг хүснэгтээр үзүүлэв.

#	Дугаар, РД	Өвөг нэр	ДДТД	Борлуулсан огноо	Илгээсэн огноо	Жорын эм тоо	Борлуулсан эм тоо	Нэхэмжилсэн огноо	Огноо	Үйлдэл
1	375...		00000407152	2023-12-29 13...	2023-12-29 13...	2	2	6,666,724,920.00	729,120.00	т.ш

**Хоёр. Хамгийн их үйлчилгээ авсан иргэн нь 37,439 ширхэг үйлчилгээ
буюу 1,917,100,283 төгрөгийг үйлчилгээ авсан байна. (AA00000000 регистр
37,439 үйлчилгээг 1,917,100,283 төгрөг)**

Тайлбар:

1. Яаралтай тусламжийн алсын болон ойрын дуудлагын тусламж үйлчилгээ
энэхүү регистрийн дугаараар бүртгэгдэн нэхэмжлэгдэж, гүйцэтгэлээр цахим
системд илгээгддэг. Өөрөөр хэлбэл Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай
удирдлагын төвөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу регистрийн дугааргүй бүртгэлээр
бүртгэгддэг болно. (албан бичгийг нотлох баримтаар хавсаргав.)

2. регистрийн дугаартай иргэн 303 төрлийн үйлчилгээнд
даатгалын сангаас 18,672,402 төгрөг авсан байна. Шимтгэл төлөлтийн мэдээлэлд
1-5 сард "хүүхэд", 6-9 сард "тэтгэвэр" гэсэн ангиллаар бүртгэгдсэн байна. Энэхүү
иргэн 2024.1-2024.5 сар хүртэл төрөөс шимтгэлийг хариуцах 0-18 насны "хүүхэд"
төрлөөр, 2024 оны 6 сараас эхлэн 0-18 насны ангилалаас хасагдаж эрүүл мэндийн
шимтгэл нь өөрөө хариуцах төрөлд шилжин, улмаар K05.2 буюу "халамжийн
тэтгэвэр авагч" төрлөөр шимтгэлийн төрөлд бүртгэгдсэн байна. Уг мэдээллийг
Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газартай байгуулсан хамтран ажиллах гэрээний
дагуу мэдээлэл хариуцагч байгууллагаас Хур системээр дамжуулан авдаг тул
шаардлагатай тохиолдолд холбогдох мэдээллийг мэдээлэл хариуцагч
байгууллагаас тодруулах боломжтой. Нөгөөтэйгүүр уг иргэн нь "диализын тусламж,
үйлчилгээ" буюу бөөрны дутагдалтай /Z49.2/ хэвлийн диализын үйлчилгээг
тасралтгүй, байнга авдаг иргэн байна.

Гурав. Регистрын дугааргүй хоосон утга дээр 675,000 төгрөгийн 943 үйлчилгээ авсан гэж бүртгэсэн байна.

Тайлбар:

1.Нэг иргэний бүртгэл дээр хоосон регистрийн дугаар бүртгэлтэй байгаа нь "нэг иргэний" эмнэлгийн үзлэгтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл гүйцэтгэл бодогддоггүй тусламж, үйлчилгээний бүртгэл юм.

Код	Үйлчилгээний тайлбар
1304	В гепатитын илрүүлэг
1901	Амбулаторийн үзлэг
1408	Ахмад настны хяналт
1302	БЗХӨ-ын илрүүлэг
1410	Бусад хяналт
1211	Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг
1204	Дислипидемия өвчний илрүүлэг
1303	ДОХ-ын илрүүлэг
1101	Ерөнхий үнэлгээ
1405	Жирэмсний хяналт
1206	Зүрх судасны өвчний эрсдэлийн үнэлгээ
1702	Зүрх судасны системийн сэргээн засах
1403	Зүрх судасны эмгэгийн хяналт
1602	Нөхөн дархлаажуулалт
1603	Нэмэлт дархлаажуулалт
1407	Нярайн хяналт
1305	С гепатитын илрүүлэг
1301	Сүрьеэ өвчний илрүүлэг
1201	Сэтгэц, зан төрхийн эмгэгийн илрүүлэг
1604	Тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалт
1601	Товлолт дархлаажуулалт
1406	Төрсний дараах эхийн хяналт
1209	Улаан хоолойн хорт хавдрын эрт илрүүлэг
1207	Умайн хүзүүний хавдрын илрүүлэг
1210	Ходоодны хорт хавдрын эрт илрүүлэг
1202	Хоёрдугаар хэлбэрийн чихрийн шижин өвчний илрүүлэг
1401	Хоёрдугаар хэлбэрийн чихрийн шижин өвчний хяналт
1409	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хяналт
1205	Хөхний хавдрын илрүүлэг
1102	Хувь хүний эрсдэлт хүчин зүйлсийн үнэлгээ
1705	Цахилгаан эмчилгээ
1203	Цусны даралт ихсэх өвчний илрүүлэг
1208	Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг
1103	Хүүхдийн өсөлт хөгжлийн үнэлгээ
1104	Хүүхдийн эрт илрүүлэг /0-5/
1105	Хүүхдийн эрт илрүүлэг /6-17/

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Санал 1	Хугацааны өөрчлөлтөд засвар оруулж, дараагийн саналыг хүлээн аваагүй болно.
Санал 2	Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцооны асуудлыг тусгасан тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.
Санал 3	Хүчингүй болсон Нийгмийн даатгалын тухай хуулийг дурдсан тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.
Санал 4	Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
Санал 5	Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
Санал 6	НДЕГ-аас ирүүлсэн баримтад тусгасан бодит гүйцэтгэл тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.
Санал 7	Аудитын талбарын ажил дууссаны дараа гарсан шийдвэр байна. Дүгнэлтийн хэсэгт өөрчлөлт оруулав.
Санал 7.1	Аудитын талбарын ажил дууссаны дараа гарсан шийдвэр байна. Дүгнэлтийн хэсэгт өөрчлөлт оруулав.
Санал 7.2	Нотлох баримтаар дэмжигдэхгүй байгаа тул саналыг хүлээн аваагүй болно.
Санал 7.3	Хөгжлийн бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх, даатгуулагчийн эрсдэлийг хуваалцаж чадаж байгааг судлах бодлогын чиг үүрэг орхигдсон асуудлыг дурдсан. Иймд дүгнэлтэд өөрчлөлт оруулаагүй болно.
Санал 7.4	Саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулсан.
Санал 7.5	Ирүүлсэн санал үндэслэлгүй тул саналыг хүлээн аваагүй болно.
Хавсралтын санал	Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

